

АГУУЛГА

- Г. Далайжамц
Эвлэлдэн нэгдэх эрх ба ажил олгогчид Үлдвэрчний Эвлэлийн
байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт 3
- П. Оюунчимэг
Цагдан хорих ажиллагаа ба хүний эрх 9
- Ж.Сүхбаатар
Сонгуулийн төв байгууллага ба түүний ерөнхий загварууд 16
- Ц. Цогт
Захиргааны хэргийн шүүх-хүний эрх 19
- Д. Ганзориг
Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх 25
- Ч. Алтангэрэл
Хүний эрхээр мэтгэлцэхүй: Хүний эрх түгээмэл шинжтэй юу? 30
- Ц. Одончимэг
Зохигчийн эрхийн хамгаалалт 41
- У. Мөнхбат, Ч. Нарантуяа, Ц. Одончимэг
Маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх арга: зуучлал 48
- ХЭҮК-оос олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан их дээд
сургуулиудын оюутны дунд зарласан “Хүний халдашгүй эрх, түүнийг
хангах баталгаа” сэдэвт эссэний уралдаанд I-р байр эзэлсэн эссэ 57
- Мөн уралдаанд II-р байр эзэлсэн эссэ 60
- Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан
Хүний эрхийн байгууллагуудын Үндэсний Чуулганы баримт бичгүүд
 - ◆ Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Хүний эрхийн
байгууллагуудын үндэсний Чуулган дээр хэлсэн үг 62
- Илтгэлүүд
 - ◆ Д. Сандаг-Очир
Хот суурин газарт иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нь 66
 - ◆ Д. Дорлигжав
Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх 71
 - ◆ Ё. Баярмаа
Аюулгүй стандартууд, түүний хэрэгжилт 83
 - ◆ Ч. Тамир
Хот суурин газарт иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нь
сэдэвт судалгааны тойм 94
- Чуулганаас гаргасан зөвлөмжүүд 107

CONTENT

• G. Dalaijamts Right to freedom of assembly	3
• P. Oyunchimeg Human rights and process of detain	9
• J.Sukhbaatar The central elected body and its models	16
• Ts. Tsogt Human rights and administrative court	19
• D. Ganzorig How to make a petition to administrative court	25
• Ch. Altangerel Debating human rights; Are human rights universal?	31
• Ts. Odonchimeg Right protection of parties	41
• U. Munkhbat, Ch. Narantuya, Ts. Odonchimeg Mediation- Solving dispute outside of court	48
• First award essay on “Inviolable rights” announced by NHRCM on the occasion of International human rights day among university and college students	57
• Second award essay on “Inviolable rights” announced by NHRCM on the occasion of International human rights day among university and college students	60
• Documents of the First National Forum of Human rights Institutions under the auspices of President of Mongolia and organized by NHRCM and Presidential Office of Mongolia	
♦ Opening speech of the First National Forum of Human rights Institutions by the Mr N. Enkhbayar, President of Mongolia	62
• Reports	
♦ D. Sandag-Ochir Protection of civilians from crime in urban area	66
♦ D. Dorligjav Right to live in safe environment	71
♦ E. Bayarmaa Safety standarts, and its implementation	83
♦ Ch.Tamir Brief report of the research on protection of citizens from crime	94
• Recomendations of National Forum	107

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ БА АЖИЛ ОЛГОГЧИД ҮЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

**Г.Далайжамц,
ХЭҮК-ын гишүүн**

Эвлэлдэн нэгдэх эрх гэдэг нь иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр ашгийн төлөө бус олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэж, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулах эрх зүйн боломж гэж үзэж болох юм.

Ажил олгогчид үйлдвэрчний эвлэл /ҮЭ/-ийн байгууллагын хамтын ажиллагаа хэрхэн яаж үүсдэг гол онцлог нөхцөл, удирдлага болгодог зарчмууд, хамтрах шаардлага, ямар чиглэлээр хамтардаг, түүний ач холбогдол, эдгээр нь ямар эрх зүйн зохицуулалттай байдгийг авч үзье.

Юуны өмнө энэ хоёр байгууллагын хамтын ажиллагаа юун дээр тулгуурлан үүсдэг, ямар онцлог нөхцөл шалтгаантай байдаг вэ? гэсэн асуулт гарч ирнэ.

1. Хөдөлмөрийн харилцаан дээр тулгуурлаж байж энэ хоёр байгууллагын хамтын ажиллагаа үүсдэг онцлог нөхцөлтэй.
2. Тухайн ажил олгогч эздийн байгууллагад ажиллаж байгаа ажиллагчид ҮЭ-ийн байгууллагыг үүсгэн байгуулж байж, ажил олгогч, ажиллагчдын эрхийг хамгаалах төлөөлийн байгууллага болох ҮЭ-ийн байгууллага хоёрын хамтын ажиллагаа үүсч бий болох онцлог нөхцөлийг шаардана.

ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан байдаг.

• **Хамтын ажиллагааны хэлбэрүүд**

1. Хамтын хэлэлцээр
2. Ярилцан тохиролцож бизнес болон бусад төлөвлөгөө гаргах
3. Хуралдаж шийдвэрлэх;
 - 3.1. Хамтарсан шийдвэр,
 - 3.2. Дангаар шийдвэр
4. Комисс, ажлын хэсэг байгуулж ажиллах;
 - 4.1. байнгын,
 - 4.2. түр хугацааны
5. Үзлэг, шалгалт явуулах

6. Хичээл, сургалт явуулах
7. Өдөрлөг, уулзалт, лекц, яриа зохион байгуулах
8. Баримт бичиг боловсруулах
9. Хамтын гэрээ байгуулж бүртгүүлэх /ХТХ-ийн 14, 15-р зүйл/
10. Түүнийгээ хэрэгжүүлэх
11. Хяналт тавих /ХТХ-ийн 16, 17-р зүйл/
12. Дүгнэх, тайлагнах /ЭМНХС-ын 2000 оны 92-р тушаалын хавсралт зөвлөмж/

А. Ажил олгогч, ҮЭ-ийн байгууллагын хамтын үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно.

- а) Ил тод байх
- б) Хараат бус байх
- в) Харилцан адил тэгш байх

Б. Үйл ажиллагааны зарчмыг хууль, тогтоомжоор баталгаажуулсан нь

1. ОУХБ-ын 98-р конвенцийн 2-р зүйлийн 1-д Ажил олгогч болон ажилчдын байгууллагууд тус тусын үүсэн байгуулалт, үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой асуудалд өөрсдөө буюу төлөөлөгч, гишүүдийн зүгээс оролцох аливаа үйлдлээс зохих ёсоор хамгаалуулна. 2-р зүйлийн 2-д Тухайлбал, ажилчдын байгууллагыг ажил олгогч буюу ажил олгогчийн байгууллагын эрх мэдлийн дор байгуулах, эсхүл ажил олгогч болон ажил олгогчийн хяналтанд байлгахын тулд санхүүгийн болон бусад аргаар дэмжих зорилго агуулсан үйл ажиллагааг энэ зүйлд заасан “оролцох үйлдэл” хэмээн үзнэ гэжээ.
2. МҮЭ-ийн эрхийн тухай хуулийн 4-р зүйлд “Үйлдвэрчний эвлэлүүд нь ... үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд бие даан чөлөөтэй явуулна” гэж заасан.
3. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4, 5-р зүйлд “... үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулах, олон түмэнд ил тод байх ...” гэж заан баталгаажуулсан байдаг.

Эдгээр нь ҮЭ-үүд болон ажил олгогч эздийн холбооны хамтын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг баталгаажуулсныг харуулж байна.

В. Ажил олгогч, ҮЭ-ийн байгууллагын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болох гол үндэслэлүүд

1. Хүний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хангах
2. Ажил олгогч, ажиллагчдын үйл ажиллагааг ардчилал, хууль ёсны зарчмаар явуулах
3. Хөдөлмөрийн харилцаанд оролцогч хоёр тал эрх, үүргээ хамтын зарчмаар хэрэгжүүлэх
4. Ажил олгогч болон ажилтан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо өөрсдийн төлөөлөгчөөрөө дамжуулж хамгаалуулах

Энэ дөрвөөс гадна өөр бусад зайлшгүй үндэслэл гарч ирэхийг үгүйсгэхгүй.

Эдгээр шаардлагаас үндэслэн хамтын ажиллагаа зайлшгүй байх хэрэгтэй болж байна.

Г. Ажил олгогч эзэд, ҮЭ-ийн байгууллагын хамтын ажиллагааны чиглэлүүд

1. Хүний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг нь эдэлж хэрэгжүүлэх боломж бүрдүүлэхэд идэвхитэй нөлөөлөх /МУХЭХҮХ-ийн 1.1.6, 1.1.6.8 ба 2.4.1.8/
2. Хүний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх /МҮЭЭТХ-ийн 5.1.5, 6; МУХЭХҮХ-ийн 1.1.6.3/
3. Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллах /ХТХ-ийн 3.1.4, 12, 14; МҮЭЭТХ-ийн 5.1.1/
4. Хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлэх /ХТХ-ийн 130-р зүйл/
5. Ажил, албан тушаалын жагсаалт, лавлах, ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах /ХТХ-ийн 21-р зүйл, бусад холбогдох дүрэм журам/
6. Үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээ, төрөл, нэмэгдэл хөлс олгох хугацаа, нөхцөл, хамрагдах ажил, мэргэжлийн жагсаалт, шагнал, урамшууллын төрөл, хэмжээ /ХТХ-ийн 48, 50, 51, 53-р зүйлүүд/
7. Хөдөлмөрийн норм, нормативыг өөрчлөх, шинээр тогтоох, хөдөлмөрийн хөлсний хэлбэр, ажилтанд олгох нөхөн олговор, нөхөн төлбөрийн төрөл, нөхцөл, олгох хугацаа гэх мэт /ХТХ-ийн IV бүлэг/
8. Ажил, амралтын цагийн журамтай холбоотой асуудал /ХТХ-ийн V бүлэг/
9. Экологийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн ажиллах аятай орчин нөхцөл бүрдүүлэх замаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж ажиллах арга барилд сургах, дадлагажуулах /ХТХ-ийн VI бүлэг/
10. Үнэ ханшны хэлбэлзэх түвшингээс хамааруулж үндсэн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх /ХТХ-ийн 18.1.6/
11. Ажил олгогч нь ажилтны нийгмийн хамгааллын арга хэмжээнд зориулсан сан байгуулах замаар орон сууц, түлээ, түлш, унаа, хоолны үнийн хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг бусад хөнгөлөлтийн асуудал /ХТХ-ийн 18.1.10/
12. Ажиллагсдын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, нийгэм, соёлын зориулалттай барилга барих, ашиглах, нийгмийн эмзэг бүлэгт багтдаг ажилтанд хөнгөлөлт үзүүлэх, ажиллагсдын эрүүл мэндийг сайжруулах зэрэг арга хэмжээ /ХТХ-ийн 18,1,10/
13. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан болон тэдгээр шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөн төлөхдөө амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ. /ХТХ-ийн 9,3/

14. Шөнийн цагаар ажилласан ажилтанд олгох нэмэгдүүлсэн цалин, хөлс, сул зогсолтын үеийн олговор, хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд олгох нэмэгдэл, амралтын болон бусад тэтгэмжийн асуудал /ХТХ-ийн 54, 56, 79, 80 дугаар зүйлүүд/
15. Хөдөлмөрийн маргааныг хүлээн авч хянан шийдвэрлэх арга хэмжээ авах /ХТХ-ийн 126-р зүйл, ЗГ-ын 1999 оны 122-р тогтоолоор баталсан ХТХК-ын дүрэм, МҮЭЭТХ-ийн 5,1,2/
16. Ажил хаялт болон бусад санал зөрүүтэй асуудлаар хамтын хэлэлцээ хийх, тохиролцоонд хүрэх /ХТХ-ийн 115-124-р зүйлүүд/
17. Ажиллагчдын мэдлэг, мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх, шинээр мэргэжил олгох /ХТХ-ийн 18,1,2/
18. Шинэ техник, технологи, ШБОС, тэргүүн туршлага нэвтрүүлэх, тэдгээрт ажиллагсдыг сургаж дадлагажуулах
19. Ажиллагсдын идэвхи санаачилгыг өрнүүлэх замаар хөдөлмөрийн бүтээл, үр ашгийг нэмэгдүүлэх
20. Үйлдвэрлэлийн өртөг зардлыг хямдруулах, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар бүтээгдэхүүн, бараа, үйлчилгээний үнэ, тарифыг тогтворжуулахаар талууд тохиролцох
21. Үйлдвэрчний эвлэл, түүний ажилтан, сонгуультаас үйл ажиллагаагаа явуулах бололцоо, нөхцөл бий болгох /өрөө тасалгаа, харилцаа холбооны хэрэгсэл болон бусад нөхцөлөөр хангах /ХТХ-ийн 18,1,11//
22. ҮЭ-ийн гишүүдийн татварыг тэдний зөвшөөрсөн үндсэн дээр бэлэн бусаар авах ажлыг зохион байгуулах /ЭМНХ-ын сайдын 2000 оны 4-р сарын 11-ний өдрийн 92 тоот тушаалаар баталсан зөвлөмжөөс/
23. Мэдээлэл, шинжилгээ, судалгаа болон үнэлгээний ажлыг гүйцэтгүүлэх буюу хамтран хийх. /ЭМНХ-ын сайдын 2000 оны 4-р сарын 11-ний өдрийн 92 тоот тушаалаар баталсан зөвлөмжөөс/

Д. Ажил олгогч, ҮЭ-үүдийн хамтын ажиллагааны ач холбогдол, зэрэг үр дүн

1. Хүний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хангаж, хамгаалах, хууль дээдлэх
2. Бүхий л үйл ажиллагаагаа хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрээр зохицуулан явуулах боломж бүрдэх
3. Ажиллагсдын мэргэжил, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар тэдний идэвхи санаачилгыг өрнүүлэх
4. Тухайн байгууллагын өмнө тавигдсан зорилтуудыг амжилттай биелүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулан үр ашгийг нэмэгдүүлнэ.

Дээрхээс үзэхэд ажил олгогчид болон ҮЭ-үүдийн хамтын ажиллагаа нь эрх зүйн доорхи зохицуулалтаар явагдаж байна.

а) Монгол Улсын үндэсний хуулиуд болон олон улсын гэрээнүүд

1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/
2. Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль /1991 он/

3. Төрийн ба төрийн бус байгууллагын тухай хууль /1997 он/

4. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 1948 оны 87 дугаар конвенц

5. Зохион байгуулах, хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 1949 оны 98 дугаар конвенц

б) Бусад хууль тогтоомжууд

1. Улсын Их хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” /2003 он/. Энэхүү хөтөлбөрт хүний эрх, түүний дотор хөдөлмөрийн харилцаанд хүний эрхийг хангаж хамгаалахад аж ахуйн нэгж, байгууллага болон үйлдвэрчний байгууллагад үүрэг, чиглэл болгосон зарим заалтуудаас толилуулья.

1.1.6. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг өргөтгөн бэхжүүлэх, тэдгээрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх таатай орчин бүрдүүлэх үйлсэд дорвитой үүрэг гүйцэтгэнэ. Хүний эрх, мөн олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээг иш үндэс болгож, тэдгээрт хууль ёсны шаардлага тавина.

1.1.6.2. Хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийн нэг бол эдийн засгийн ололт, нийгмийн хөгжилд дааштай хувь нэмэр оруулах, өөрсдийн ажиллагсдын төдийгүй бусад хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах явдал мөн.

1.1.6.3. Хувийн хэвшилд ажиллагчдын хүний эрхийн мэдлэг, эрхээ хамгаалах чадавхийг дээшлүүлж, хөдөлмөрийн харилцаанд дахь хүний эрхийн зөрчлийг тууштай бууруулж, эрх зөрчигдөхөөс сэргийлнэ. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахтай холбогдох заавар, журмын стандартыг хуульд нийцүүлж ажиллагчдад хүртээмжтэй болгоно.

1.1.6.7. Хувийн хэвшилд ажиллагчдын хүний эрхийн мэдлэг, эрхээ хамтран хамгаалах чадавхийг дээшлүүлж, хөдөлмөрийн харилцаанд дахь хүний эрхийн зөрчлийг тууштай бууруулж, эрх зөрчигдөхөөс сэргийлнэ. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахтай холбогдох заавар, журмын стандартыг хуульд нийцүүлж ажиллагчдад хүртээмжтэй болгоно.

1.1.6.8. Хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журам зэрэг ажиллагчдын эрхийг хангах эрх зүйн баримт бичгүүдийг үнэн зөв болгож ажлын байранд ил тод тавьж, тэдний байнгын хяналтад байлгана.

2.4.1.8. Хөдөлмөрийн эрх, хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын бусад эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын эрхийг өргөтгөж, ажил олгогчдын болон ажилтны төлөөлөх байгууллагын хоорондын зөвшилцөл, хамтын гэрээ, хэлэлцээрийг үнэн зөв, үр дүнтэй болгох арга хэмжээ авч, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний болон аймаг, нийслэлийн хэлэлцээрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг тогтоон хэвшүүлнэ.

2.1.4.9. Хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, ажилтны орлогыг нэмэгдүүлэх, тэдний дадлага, мэргэжил, мэргэшлийн өсөлтийг харгалзан

дэвших буюу илүү өндөр цалинтай ажилд шилжин ажиллах эрхийг хангах нөхцөл, журмыг боловсронгуй болгоно.

2. Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”

3. ЗГ-ын 1999 оны 123 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны дүрэм”

4. ЗГ-ын 2001 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн хамтын маргааныг жуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журам”

5. ЗГ-ын 2005 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр”

6. ЭМНХ-ын сайдын 2000 оны 92 дугаар тушаалаар баталсан “Хамтын гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг дүгнэх тухай зөвлөмж”

Е. Дүгнэлт, санал

Хөдөлмөрийн харилцаанд оролцож буй хоёр гол субьектийн нэг тал болох ажиллагчид нь нийгмийн баялгийг бүтээж, нийгэмд тодорхой үйлчилгээ үзүүлэх ажлыг өөрийн биеэр гүйцэтгэдэг учраас энэхүү харилцааны нөгөө тал болох ажил олгогчид буюу эзэдтэй байнга харьцаж адил тэгшээр эрхээ хэрэгжүүлэх боломж тэр бүр байдаггүй. Иймд тэд нар өөрсдийгөө төлөөлөх байгууллага болох ҮЭ-д эвлэлдэн нэгдэж үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг үүсгэн байгуулж тэдэнд зарим эрх, үүргийг шилжүүлж ирсэн түүхэн уламжлалтай. Үүнийг ч дээр дурдсан хууль тогтоомжоор баталгаажуулсан байдаг.

Өнөө үед өмчийн аль ч хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд олонхийн оролцоо, ардчилалгүйгээр нийгэмд зохих байр сууриа эзэлж, үйл ажиллагаагаа амжилттай явуулах боломжгүй болж байна. Энэ нь ардчилал, хүний эрхийн гол баталгаа болсон үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллахгүйгээр дангаар ноёрхлоо тогтоон ажиллах цаг үе нэгэнт улиран одож байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хамгийн энгийн үгээр тайлбарлахад аль ч байгууллагад ажил олгогч эзэд, ҮЭ-ийн байгууллага гэсэн хоёр тулгуур баганатай байж, үйл ажиллагаагаа явуулбал илүү бат суурьтай тогтвортой амжилт үзүүлж ажиллана хэмээн үзэж болох юм. Иймд аж ахуйн нэгж, байгууллагууд бүхэн ҮЭ-ийн байгууллагыг дэмжиж, хамтран ажиллаж, хүний эрх, эрх чөлөөг ханган хуулиа дээдлэн үйл ажиллагаагаа явуулахыг санал болгож байна.

Энэ нь даяаршлын эрин үед хууль, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан нийгмийн байгууллын мөн чанараар тодорхойлогдож байна.

ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

П.Оюунчимэг
Магистр, ХЭҮК-ын
Ажлын Албаны дарга

Урьдчилан хорих төв, “Ганц худаг” гэхээр шоронгийн тухай дуулсан, мэдсэн аймшигтай зүйрлэлүүд хэн бүхний өөр өөрийн төсөөллөөр хүн бүрт буудаг.

Тэртээ он жилүүдийн өмнө тэрний хүүхэд ганц худагт орж гэнэ, тэгээд дараа нь шоронд явж гэнэ гээд л томчуудын хоорондоо ярихыг сонсоод ямар учиртай газар байдаг юм бол, шууд л тэр шорон гэдэг газар руу явдаг юм байх даа хэмээн дүрслэн бодохыг хичээн гайхдаг байж билээ. Дараа нь хуулийн сургуулийн оюутан болж хууль хэмээгч аугаа их, ёроолд нь хүршгүй шинжлэх ухааны амсраас зүүгдэн ядаж явахдаа тэрхүү хоёр өөр газрын ялгаа, учрыг нэг тайлж ядсан билээ.

Урьдчилан хорих байранд хулгайч, алуурчин, дээрэмчин нар л ордог гэдэг ойлголттой байсан нийгмийн сэтгэл зүй тэр чигээрээ өөрчлөгдөн тэнд шүүхээр гэм буруу нь эцэслэн тогтоогдоогүй зөвхөн ямар нэгэн хэрэгт сэжиглэгдэн байцаагдаж байгаа хүмүүсийг хорьж шалгадаг газар гэдгийг одоо нэгэнт мэддэг болжээ. Тиймээ. Тэнд гэм буруу нь шүүхийн таслан шийдвэрлэх хүчин төгөлдөр тогтоол гарахаас өмнө хэрэгт шалгагдаж байгаа хүмүүсийг л хорьж нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарладаг хуулийн энэхүү албадлагын арга хэмжээг хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэрэглэх ёстой.

Гэхдээ энэ албадлагын арга хэмжээг тодорхой хугацаанд, тодорхой төрлийн гэмт хэрэгт хэрэглэж болохыг хуулиар нэгэнт заасан, ямар хүний зөвшөөрлөөр энэ арга хэмжээг хэрэглэхийг хүртэл хуулинд нарийн тусгасан байдаг. Харамсалтай нь хүн бүр хуулийг мэдэх албагүй ч энэ талын мэдлэг дутуу дулимагаас өөрсдийн эдлэх эрхээ хуулийн байгууллагын үйл ажиллагааны явцад хязгаарлуулах тохиолдлууд гардаг.

Хорих үндэслэлийн тухайд

ЭБШХ-ийн 8 дугаар бүлэг нь бүхэлдээ сэжигтэн, ялагдагч, шүүгдэгчийг цагдан хорих асуудлыг зохицуулсан бөгөөд оргон зугатахыг завдсан гэдэг нэр томьёог практик дээр хэрэглэх нь нилээн нийтлэг байгааг хэлэх хэрэгтэй юм. Цагдан хорих төвд хоригдож байсан хоригдогч нарын хорих тогтоолын үндэслэлийг харахад ихэвчлэн оргон зугатахыг завдсан, хүнд гэмт хэрэг үйлдсэн гэсэн үндэслэлээр цагдан хорьсон байдаг.

Хуулийн заалтуудаас харахад гэмт хэрэгт холбогдсон хүмүүс ялангуяа хүнд, онц хүнд төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүнийг хорих үндэслэл нь хэн ч

маргах аргагүй тодорхой биш, хэн нэгэн байцаагч эдгээр үндэслэлийн аль нэгийг бичээд хорих тухай саналыг прокурор, шүүхэд танилцуулахад зүйл ангийг нь хараад шүүгч шууд баталж болохоор байгаа нь хүний эрхийг ноштойгоор зөрчихөд хүргэж байгаа юм.

Мөн үүнээс гадна жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, насанд хүрээгүй хүмүүсийг хөнгөн болон хүндэвтэр төрлийн гэмт хэрэгт сэрдэгдсэн үед нь оргон зайлсан, оргон зайлж болзошгүй, урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн гэсэн үндэслэлүүдээр цагдан хорьж болохоор хуульд заажээ. Үүнээс үзэхэд ямар ч хэрэгт сэжиглэгдсэн, хэнийг ч баривчилж хорих үүд хаалга нээлттэй биш гэж үү?

Хорих хугацааны тухайд

Монгол улсын эрүүгийн хуулинд заасан гэмт хэргүүдээс хүнд, онц хүнд төрлийн 102 гэмт хэрэг байдаг бөгөөд эдгээрт цагдан хорих таслан сэргийлэх арга хэм жээг шууд хэрэглэж болохоор хууль зөвшөөрсөн байна.

Монгол улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу насанд хүрсэн хүмүүсийг 24 сар хүртэл, онц хүнд төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэн хоригдож байгаа хүмүүст 30 сар хүртэл хэрэглэхийг хуулиараа нэгэнт зөвшөөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдүүдэд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг 18 сар хүртэл байхаар зааж өгчээ. Сонсох, унших, харахад хүртэл урт хугацаа. Гэтэл энэ хүмүүс чинь уг ёсондоо бол зөвхөн тухайн гэмт хэргийг үйлдсэн эсэх нь нотлогдоогүй байгаа хүмүүс шүү дээ гэж бодохоор өөрийн эрхгүй айдас төрнө. Гэхдээ хууль тогтоогч нар маань үүнийг бодитой, боломжтой хугацаа хэмээн зөвшөөрч л баталсан үндэслэл нь юу байж болох вэ?

Хүүхдийн Эрхийн Конвенцийн шаардлага ёсоор бол гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхдэд хэрэглэх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг аль болохоор богино хугацаагаар, эцсийн арга хэмжээ болгон хэрэглэж байхаар заасан байдаг.

Гэтэл энэ заалт амьдрал дээр огт хэрэгждэггүй. Үүний нэг гол тайлбар, шалтгаан нь гэр оронгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй эсвэл оргон зугатаж болшгүй гэдэг нийтлэг тайлбарыг манай хуулийн байгууллагын ажилтнууд нэгэн дуугаар хэлдэг.

Удаан хугацаагаар хүүхдийг хорих нь хүүхдийн эрүүл мэндэд маш муугаар нөлөөлдөг. Бидний хийсэн шалгалтын явцад бөөстсөн, хирэндээ баригдсан, сайртсан хүүхдүүд байсан.

Хамгийн ойрын жишээ хэлэхэд манайд хүүхдэд хэрэглэдэг энэ цагдан хорих 18 сарын хугацааг ОХУ-ын хуулиар насанд хүрсэн хүмүүсийг хорих хамгийн дээд хугацаа юм.

Ноднин манай комисс олон улсын хүүхдийн байгууллагын нэг төлөөлөгч ирж уулзахдаа надаас ингэж асуусан юм.

...Танай хуулиар насанд хүрээгүй охидыг садар самуунд уруу татсан хэрэгтээ насанд хүрсэн эрэгтэйчүүд ямар ял авдаг вэ гэлээ. Би хуулийнхаа

заалтыг хэллээ. Гэтэл эргээгээд тэр хүн: - тэгвэл тэр насанд хүрсэн эрэгтэй хүн бодит гэмт хэрэг үйлдсэн, насанд хүрээгүй охиныг уруу татсан хэрэгтээ шийтгүүлж байгаа тэр хугацаа чинь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн үгүй нь нотлогдоогүй шүүх хурлаа хүлээж байгаа хүүхдүүдийн хоригдож байгаа хугацаанаас бага байна шүү дээ гэж хэлж билээ.

Тэгэхээр хүүхдүүдийг удаан хугацаагаар ингэж хорих нь шүүхийн тогтоолгүйгээр тухайн хүүхдийг хийсэн ч бай хийгээгүй ч бай тэр гэмт хэрэгт нь шүүхийн тогтоолгүйгээр ялаж байгаагийн нэг хэлбэр мөн гэж хэлэхэд хилсдэхгүй.

Хоригдож байгаа эмэгтрэйчүүдийн хувьд ч байдал мөн ялгаагүй. Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн хэмээн хорьж мөрдөх эрх байгаа хэдий ч тэдгээр эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр бүл, ялангуяа үр хүүхдээ хаана, юу хийж яваа, хэрхэн амьдарч байгаа талаар ямар ч мэдээлэлгүй хий дэмий л санаа сэтгэл нь зөвнин шаналсан нэгэн байдаг.

Дэлхий даяар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, ялангуяа амьд явах, халдашгүй дархан байх эрхийн асуудал дээр онцгой анхаарал хандуулдаг болсон. Монгол улс хүний эрхийг дээдэлсэн, шүүхээр хэрэг шийдвэрлэтэл гэм буруугүй байх зарчмыг хүлээн зөвшөөрсөн ийм үед дээрхи хугацаанууд нь хүний эрхийн үндсэн зарчмыг шууд л зөрчиж байгааг хэлэх нь зүйтэй байх.

Нэгэнт бид ардчилал хэмээх үнэт зүйлийг олж авч чадсан, түүнийгээ хөгжүүлэх гэж зүтгэж байгаа бол энэ асуудал дээр ч мөн адил онцгой анхаарах цаг нэгэнт болжээ.

Хорих зөвшөөрлийн тухайд

Хуулиар зөвшөөрөгдсөн, төрийн албан тушаалтан төрдөө тангараг өргөн, төрийн нэрийн өмнөөс үүргээ гүйцэтгэж байгаа тэр л байранд гэмт хэрэгт сэжиглэгдэн хоригдож байгаа гэм буруугүй хүмүүс ямар нэгэн дарамт шахалт, эрүүдэн шүүлтийг амсаж амьсгалах агаар, идэх хоол, хэвтэж амрах хэсэгхэн зайны төлөө амь насаараа дэнчин тавьж хийсэн гэх, хийгээгүй гэх хэргийнхээ төлөө тэнд хоригдож байна.

2002 оны шинэчлэн найруулсан хуулийн дагуу цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсноор прокурор зөвшөөрөл өгдөг байсан тооноос харьцангуй багассан хэмээн манай хуульч нар ярьдаг. Тэгвэл энэ яриа бодитой юу.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2005 оны 6 сард хийсэн шалгалтаар 1009 хүн 1 хоногоос 26 сар хүртэл хугацаагаар хоригдож байлаа. Уг нь бол ШШГЕГ-ын харьяа энэ цагдан хорих төв даац болон багтаамжаараа 650-670 хүнийг хүлээн авах багтаамжтай юм байна. Гэтэл энэ тоо даруй нэг дахин өссөн дүн гарсан байна.

Бидний хуучин ярьж заншсанаар сэжигтнийг албадан саатуулах буюу 72 цагийн тухай бас энд бичихгүй өнгөрч болмооргүй байна. Энд нэг баримтыг сөхье.

Одоо “Баривчлах төв” гэж нэрлэх болсон энэ байранд 2005 оны эхний 6 сарын байдлаар нийт 978 хүн баривчилсний 919 буюу 93.9 хувийг нь хойшлуулшгүй тохиолдол гэсэн үндэслэлээр, дөнгөж 59 хүнийг буюу 6 хувийг ЭБШХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу шүүхээр тогтоолыг нь батлуулсны дараа баривчилсан нь анхаарал татаж байна.

Ноцтой нь эдгээр 978 хүнийг бүгдийг нь дандаа ажлын бус цагаар баривчлах төвд хүргэн ирсэн байх юм.

Үүнээс үзэхэд сэжигтнийг баривчлах явдал нь шүүхийн зөвшөөрөлгүй, хойшлуулшгүй ажиллагаа нэрийн дор явагдаж буй нь тодорхой байна. Прокурорын хяналт ч үүнээс гадуур байх ёсгүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хорих байрны нөхцөл стандарт

Хэдийчинээ олон хүн хоригдоно төдийчинээ л нэг хүнд оногдох талбай багасна. Үүнийг дагаад халдварт өвчин гарах, тураалд орох, эрүү шүүлтэнд өртөх магадлал ихэсдэг. Цагдан хорих төвийн багтаамжийн талаар олон улсын гэрээ болон бусад баримт бичигт заагдсанаар 6.5 метр кв нэг хүнд оногдохоор заасан байдаг.

Монгол улсын 1999 оны “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулинд зааснаар нэг хүнд оногдох метр кв нь 2.5 мкв байх ёстой гэжээ. Гэтэл Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг цагдан хорих байрны хэдэд нь энэ хэмжээ хүчин төгөлдөр байдаг бол. Зөвхөн Ганц худгийн урьдчилан хорих төвийн 181 камерын 72 хувь нь хуулийн дээрхи шаардлагыг огт хангахгүй байна.

Хэрэв та Ганц худагийг сонирхон үзэх боломжтой бол нэг өрөөнд 5-6 хүн сэлүүхэн юм шиг байрласан, тэгсэн мөртлөө зарим камеруудад 14-16 хүнийг чихцэлдүүлэн байрлуулан нийтлэг дүр зураг таныг угтах болно. Гэтэл сэлүүхэн болон бөөнөөр чихсэн эдгээр камеруудын аль нь ч нөгөө хуулинд заасан 2.5 метр кв-даа хүрдэггүй байна.

Цаашлаад сахилгын болон өлсгөлөнгийн камерын талаар бол ярилтгүй. Хүн орохын аргагүй муухай үнэр, онгойж цөмөрсөн шал, ус шахвал л цэвэрлэгддэг жорлон, хиртсэн гудасны танаг, цагаан хэрэглэлгүй нөмөрсөн хөнжил зэрэг нь өнөөдрийн үнэн дүр зураг мөн.

Хориглогсдын эрхийн тухайд

Хоригдож буй хүмүүс эрүүл мэндээ хамгаалуулах, эргэлт уулзалтыг ар гэрээсээ болон ойр дотныхноосоо авах, мэдээллээр хангагдах, өмгөөлөгчийн болон хууль зүйн зөвлөлгөөг үнэ төлбөргүйгээр авах эрхтэй байдаг. Үүнийг хэн бугай нь ямар нэгэн дүрэм журмаар зохицуулах ёсгүй билээ.

“Тэнгэрийн дор төрж хуулийн дор амьдардаг” гэдэг үг өөрийн эрхгүй санагдана. Уг чанартаа дүрэм, журмыг хуулийн хүрээнд л зохицуулж гаргахаас хэн нэгэн хүн хуулиас дээгүүр, хуульд заагаагүй зүйлийг журамлаж, хэрэглэх ёсгүй. Гэтэл Ганц худгийн урьдчилан хорих төвд хатуухнаар хэлбэл хэрвээ

таны ах дүү амраг садан, эхнэр, нөхөр, танил, найз нөхөд чинь хоригдож байгаад та мөнгөгүй л бол тэнд эргэлт тойролт оруулах, уулзах ч эрхгүй болгосон журам гаргажээ. Цаг заваа гарздан өөрөө ямар нэгэн хэрэгт шалгагдаж байгаа юм шиг мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчээсээ гуйж авсан тэр бичиг чинь ч хэрэг болохгүй. Ганц худгийн эргэлт уулзалтын байрны үүдэнд долоо хоногийн хоёр өдөрт нь тусгай ТҮЦ ажиллана. Тэр ТҮЦ-нээс нь идэж уух зүйл, татах тамхийг нь авч өгөхгүй бол гаднаас юу ч байсан оруулахгүйгээр зохицуулжээ.

Энэ журмаа тус ангийн дарга тайлбарлахдаа гаднаас хоол ундны зүйл оруулахаар халдварт өвчин гарах магадлал өндөр байдаг. Өвчин гарсан тохиолдолд хэн тэр хариуцлагыг хүлээх вэ, үүнээс л урьдчилан сэргийлж байгаа ажил хэмээн тайлбарлаж байх юм. Мэдээж халдварт өвчин гарвал аюултай нь ойлгомжтой, гэтэл тэнд хоригдож байгаа хүмүүсийн хэд нь төлбөрийн чадвартай, хэд нь төлбөрийн чадваргүй байгаа талаар тоо судалгаа энэ ангид байдаг болов уу?.

Монгол улсын үндсэн хуулинд ялгаварлан гадуурхалтын талаар тодорхой заасан байдаг. Одоогийн дагаж мөрдөж байгаа дүрэм журам нь яахын аргагүй хөрөнгө чинээгээр нь хүнийг ялгаварлан гадуурхаж байгаагийн илрэл мөнөөс мөн билээ.

Эргэлт уулзалтын нэг гол ач холбогдол нь тухайн цагдан хорих байранд эрүү шүүлт байгаа эсэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй хэмээн тайлбарлагддаг.

Насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд бол бүүр ч өрөвдмөөр. Гэр орон, эцэг эхгүй тэнэмэл гэдэг нэр томьёог өөрийнхөө бус өрөөлийн буруугаас олж авсан эдгээр хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүүхдүүдийн зарим нь тэр эргэлт уулзалтын талаар огт мэдэхгүй.

1989 онд НҮБ-аас батлан гаргасан Хүүхдийн эрхийн тухай конвенцид Монгол улс аль 1990 онд нэгдэн орсон. Энэ конвенцийн заалт бүрийг биш юмаа гэхэд зөвхөн гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн талаархи заалтын талаар хэр олон шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнууд мэдэх бол.

Цагдаагийн байгууллагын хүүхдийн байцаагч хэмээн хүнд ачааг нуруундаа үүрч айл гэрийн эзэгтэй үүргээсээ ихэнх талыг албандаа зориулсан мөрдөн байцаагч бүсгүйчүүдийг эс тооцвол энэ талаар мэддэг хуульчдын тухайд хэцүү л тоо гарах байхдаа хэмээн би дотроо бодож явдаг.

Урьд нь эдгээр гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн хэргийг мөрддөг тусгай хэлтэс, хянадаг прокурорууд хүртэл ажилладаг байсан. Гэтэл одоо энэ албууд бүгд байхгүй болжээ.

Нөхцөл байдлын хувьд эмэгтэйчүүдийг хэт олноор нь бөөгнөрүүлэн хорьсон, хүйтэн нойтон орчинд удаан хугацаагаар байхад тэдний эрүүл мэндэд маш муугаар нөлөөлдөг гэдгийг хэлүүдэлтгүйгээр хүн бүр сайн мэддэг.

Ер нь цагдан хорих хугацаа, цагдан хорих байрны нөхцөл нь өөрөө эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр болдог. Удаан хугацааны туршид хоригдсон, өвдсөн, залхсан, турсан эдгээр хоригдогч нар сүүлдээ хийсэн хийгээгүй байцаагчийн тулгасан олон хэргийг хилсээр хүлээж тэр нь нотлох баримт хангалтгүй

цугласан гэдэг үндэслэлээр шүүхээс буцах, хэрэг хэрэгсэхгүй болох, цагаатах тохиолдол олноор гадаг.

Дотоодын хууль болон олон улсын гэрээнд зааснаар тухайн хорих байрны өрөө бүр байгалийн гэрэл тусах цонхтой, цонх нь салхивчтай, ердийн гэрэл нь тухайн хоригдож байгаа хүний унших, ажиллахад тохирсон байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг.

Гэтэл манай улсын хэмжээнд 8 аймгийн цагдан хорих байр газар дор буюу байшингийн подвальд, 3 аймгийн цагдан хорих байр нь хагас подвалийн байрлалтай, 11 аймгийн байр нь нэгдүгээр давхарт байна.

Хөдөө орон нутгийн цагдан хорих төвүүд нь гаднаа бие засах газартай бөгөөд өдөрт ердөө л 2 удаа л бие засах эрхтэй байдаг. Хүний физиологийн хэрэгцээг ингэж хязгаарласныг тэндхийн албан хаагч нар өдөрт 3-4 удаа гаргах боломжгүй, хүн хүч дутмаг байдаг, өвөл гадаа хүйтэнд даардаг гэх мэтийн ялих,шалихгүй шалтаг тоочин тайлбарладаг.

Тэгэхээр тэнд байгаа хүмүүс нь ундааны хуванцар саваар дүүрэн шээсийг өдөржин өрөөндөө хадгалан шивтэр аммиакны үнэр дунд өдрийг өнгөрөөж байгаа нь нууц биш билээ. Энэ нь хүний нүдний хараанд маш муугаар нөлөөлдөг тухай эмнэлэгийн ажилтантай санал солилцох үеэр над ярьж байсан билээ.

Үүнээс гадна цагдан хорих төвүүдэд их бага ч гэсэн тодорхой хэмжээгээр тураал байгаа бөгөөд үүнийг 90-ээд оны дунд үетэй харьцуулахад юу ч биш хэмээн ярьдаг өнөөгийн үед ялангуяа урьдчилан хорих төвүүдэд тураалтай хүмүүс байсаар байна. Комиссын хийсэн шалгалтаар Ганц худагт л гэхэд 42 хүн буюу нийт хоригдогсдын 4.2 хувийг 1-15 кг турсан хүмүүс эзэлж байв.

Зүй бус харьцаа дарамтлалын тухайд

Хорьсон хүнээ удаан хугацаагаар байцаадаггүй мартдаг, хамт хоригдож байгаа хүмүүсээр нь дарамтлуулдаг, эрүү шүүлт тулгуулдаг, өөрийн хүссэн мэдээ мэдээллийг олж авах гэж улайрдаг зэрэг нь эрүүдэн шүүлтийг бодитойгоор хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгодог.

2002 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороо, Улсын Ерөнхий Прокурорын Газраас цагдан хорих төвд хийсэн шалгалтын дүнг хэлэлцээд тогтоол гаргаж уг цагдан хорих төвд хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийг хуульд заасан үндэслэлгүй, прокурорын байгууллагын зөвшөөрөлгүйгээр удаа дараа цагдан хорих, өрөө сольж давтан гэмт хэрэг үйлдсэн, удаан хугацаагаар хоригдсон хүмүүсийн өрөөнд оруулж тэднээр зодуулах зэргээр дарамт шахалт үзүүлэх, хоригдож буй хүмүүстэй зүй бусаар харьцах, хөтөлж байцаах, хүч хэрэглэх зэрэг хууль бус ажиллагаа зарим төлөөлөгчдийн хэрэг хүлээлгэх арга хэрэгслэл болсныг тогтоолдоо тэмдэглэсэн байна.

Дархан-Уул аймагт хяналт шалгалтын ажлаар явж байтал цагдан хорих төвийн дарга нь хоригдож байсан яллагдагчийг зодож биед нь гэмтэл учруулсныгаа биднээс нуусан явдал гарсан билээ.

Тухайн үед цагдан хорих байрны даргатай энэ асуудлын талаар лавлан, асуудлыг шийдвэрлүүлэх талаар ярьж байтал прокурорын нэг ажилтантай тааралдаж энэ асуудлын талаар танилцууллаа.

Тэгээд прокурор цагдан хорих байранд өдөрт нэг удаа ирж ажилладаг юм байна. Гэтэл энэ хүмүүс чинь зодуулсан явдал гарсныг анхаарах хэрэгтэй байна. Прокурорынхоо шалгалтын явцад эдгээр хоригдож байгаа хүмүүсийн хувцсыг тайлуулж үзлэг хийж болдоггүй юм боловуу гэж асуухад... бид нарт тэгж байх зав алга, өөр зөндөө ажил байна хэмээн бүхимдаж билээ. Мөн чанартаа прокурорын тусгай хяналтын гол чиг үүрэг үүнд л чиглэгдэж, ийм л үйлдлээс урьдчилан сэргийлж байх ёстой билээ.

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА БА ТҮҮНИЙ ЕРӨНХИЙ ЗАГВАРУУД

Ж.Сүхбаатар
*Сонгуулийн ерөнхий хорооны
нарийн бичгийн дарга*

Сонгууль бол ардчиллын угтвар нөхцөл хэмээн нийтээр хүлээн зөвшөөрдөг. Ялангуяа ардчиллыг шинээр буюу сэргээн тогтоосон орнуудын хувьд чөлөөт, шударга сонгуулийн механизмаар дамжуулан нийтийг засаглан жолоодох эрх мэдлийг хадгалан хэрэгжүүлэгч иргэдийн төлөөллийн институтыг тогтмол хугацаанд эмхлэн бүрдүүлдэг байх нь ард түмний хүсэл зориг засаг төрийн үндэс болох тухай ардчиллын үнэт сургаалд бүрнээ нийцэх юм. Хэрэв ард түмэн нь өөрсдийн удирдагчдаа тайван замаар чөлөөт сонголтын үндсэн дээр өөрчлөж чаддаггүй бол тэдэнд дарангуйлал дор захирагдах, эсхүл хувьсгал хийх гэсэн аль нэг сонголт л үлдэнэ.

Иймд ардчилал тийш шилжилт хийж буй улс орнуудад сонгуулийг ардчилсан арга, хэлбэрээр, иргэдийн итгэлийг хүлээхүйцээр зохион явуулах, түүний бэлтгэл ажлыг хангах нь нэн чухал шаардлага, хэрэгцээ болж байна. Өдгөө уул “нийгмийн захиалга”-ыг гүйцэлдүүлэхэд англиар “electoral administration” хэмээх “сонгуулийн засаг захиргаа” онцгой үүргийг гүйцэтгэж байна.

Сонгуулийн засаг захиргаа бол сонгуулийг удирдах үүргийг биелүүлэгч сонгуулийн үйл явцын үндсэн субъект юм. Өөрөөр хэлбэл, сонгуулийн засаг захиргаа нь сонгуулийн менежментийг хийдэг байгууллага. Чухамдаа сонгуулийн менежментийн байгууллагуудын бүрэлдэхүүн, эрх хэмжээ, шинж чанар зэргээр нь сонгуулийг тайван өөрчлөлтийн эх суурь болох уу, эсхүл нийгэм-улс төрийн тогтворгүй байдлын өдөөлт шалтаг болох уу гэдгийг нь ч тодорхойлж болдог. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас Сонгуулийн комиссууд бие даасан байдлаар үүсэн байгуулагдах болсон бөгөөд олон улсын зөвлөх, зуучлагч нарын байнгын туслалцаа дэмжлэгээр тэдгээрийг хувьсган бэхжүүлж байгаагийн дүнд хөгжиж буй олон улс оронд эрх мэдлийн босоо, хэвтээ төвшинд хариуцлага, тайлагналтын тогтолцоог ихээхэн нэмэгдүүлж чадаж байна.

Ардчиллын замаар хөгжин дэвжсээр яваа өндөр хөгжилтэй улс орнуудад ч гэсэн сонгуулийн зохион байгуулалт, үйл явц төгс болчихоогүй л байна. Тухайлбал, АНУ-д явагдсан 1996 оны бүх нийтийн сонгуулийн дараа Ардчилсан нам болон Бүгд найрамдах намууд бие биенээ Калифорнид тэндхийн биш иргэдээр санал өгүүлсэн, Луйзанад зарим сонгогчид урьдчилсан санал хураалтыг хортойгоор ашигласан гэх зэргээр буруутгаж байсан бол 2000 оны сонгуулиар мөн л Флоридад санал тоолохтой холбогдсон маргаан дэгдэж байв. Энэ нь тийм ч хачирхалтай хэрэг биш аж. Асуудлын гол нь төрийн болон төрийн бус институцийн зүгээс сонгуулийн журмаас гажсан элдэв зөрчлийг илрүүлж

засч залруулдаг байх нь чухал юм. Үүний тулд юун түрүүн бие даасан байгууллага болон шударга голч шүүх эрх мэдэл байхыг шаардана. Ийм байсан цагт олон түмний итгэлийг хүлээх боломж бий болно.

Аль ч оронд сонгуулийг итгэж найдаж болохуйцаар үр ашигтай зохион явуулахад иргэд, засгийн газрын бус байгууллага, хэвлэл мэдээлэл, улс төрийн намуудын хамтын болон тус тусын тасралтгүй мониторинг шаардагдана. Сонгуулийн менежментийн байгууллагууд нь *намын, хагас намын, эсхүл намын бус; төвлөрсөн, эсхүл эс төвлөрсөн; тусгай шүүхийн байгууллага, эсхүл Засгийн газрын яам; эсхүл эдгээрийн аль алинаас хосолсон хэлбэрээр байж болох бөгөөд шүүгч, төрийн албан хаагч буюу эсхүл эрдэмтэд, шинжээчдээс бүрдэж болох ажээ.* Иймд тэдгээрийг ялган төрөлжүүлэхэд бэрхтэй.

Хэдий тийм боловч ерөнхийд нь дараах таван загварт хуваан үзэж болох юм.

- 1. Засгийн газрын бүтцэд багтдаг Сонгуулийн байгууллага.** Эл хандлага нь иргэний/төрийн/ алба нь өндөр нэр хүндтэй байдаг ардчилсан улс орнуудад тохирч үйлчилдэг. Гэхдээ хөгжиж байгаа буюу шилжилтийн үеийн улс орнуудад их ховор үйлчлэх ба тохиромжгүй гэж үздэг.
- 2. Шүүхийн байгууллагын хяналт шалгалт дор байдаг Засгийн газрын яамны бүтцэд багтах Сонгуулийн байгууллага.** Ийм Комисс нь сонгуулийг зохион явуулах үүрэгтэй Засгийн газрын яамыг хянах эрх бүхий шүүгчдээс бүрддэг. Энэ хандлага нь зарим талаар эхний загварын шинж чанаруудыг агуулж байдаг.
- 3. Мэргэжилтнүүдээс бүрдсэн парламентад шууд тайлагнадаг бие даасан Сонгуулийн комисс.** Энэ нь парламентад нэг нам зонхилоогүй байгаа үед илүү найдвартай байх ба хэрэв эсрэгээр нэг нам хэт зонхилсон байгаа үед ийм Комисс эрх баригч хүчинд “толгой бөхийлгөх”-өөс аргагүй болдог.
- 4. Улс төрийн олон намын төлөөлөгчдөөс бүрдсэн Сонгуулийн комисс.** Энэ нь улс төрийн намуудад сонгуулийн комисс юу хийхээр төлөвлөж байгааг мэдэх, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцох боломж олгож байгаагаараа сайн талтай. Гэхдээ парламентад хэт олон нам суудал авбал тухайн сонгуулийн комиссууд ажиллах чадваргүй болох аюултай. Мөн парламентад хоёрхон нам байгаад Комиссын дарга нь нэг талыг бариад, үр ашигтай ажиллахгүй бол тухайн комиссууд нь туйлшралд автдаг.
- 5. Хууль тогтоох байгууллагаас болон Ерөнхийлөгчөөс санал болгосон нэр хүнд бүхий хувь хүмүүсээс бүрдсэн намын бус Сонгуулийн комисс.** Ийм Комисс эрх мэдэлтэй, бие даасан байх боловч даргын удирдлагаас хэтэрхий их хамаардаг гэж үздэг.

Дээр дурдсан загваруудаас гадна сонгуулийн байгууллагуудыг *Засгийн газрын хандлагатай, Шүүхийн хандлагатай, Олон намын хандлагатай, Мэргэжлийн хандлагатай* гэж хуваан авч үзэх нь бий.

Сонгуулийг зохион байгуулагч аливаа захиргааны бүтцэд тавигддаг нийтлэг шаардлага бол бодитой байх, хараат бус байх, бие даасан байх явдал юм. Сонгуулийн байгууллагуудын бүх төвшинд ажилтнууд нь улс төрийн шахалт үзүүлэх болон бусад гадаад нөлөөллөөс ангид тусгаарлагдсан байх учиртай. Үүнд хууль зүйн баталгаа энэ тэргүүнд шаарддаг.

Сонгуультай холбоотой бараг бүхий л арга хэмжээ, түүний дотор шийдвэр гаргах зэрэг нь ил тод, нээлттэй явагдаж байх ёстой. Түүнчлэн Парис хотноо 1994 оны 3-р сарын 26-ны өдөр Олон Улсын Парламентын Холбооны Зөвлөлийн 154 дүгээр чуулганаар хуралдаанд оролцсон 112 улс орны бүх төлөөлөгчдийн санал нэгтгэйгээр баталсан “Чөлөөт, шударга сонгуулийн шалгуурын тухай тунхаглал”-ын 4-ийн 9-т: “Төр нь сонгуулийн үйл явцад хамаарах гомдол болон хүний эрх зөрчсөн тохиолдлыг Сонгуулийн комисс буюу шүүх зэрэг бие даасан, шударга байгууллагуудаар сонгуулийн үйл явцын тухайн хугацаанд шуурхай үр ашигтай шийдвэрлүүлэх арга хэмжээ авах ёстой” гэж заасан бөлгөө.

Берлиний хана нурснаас хойш бараг зүүн Европын бүх улс орон Сонгуулийн комиссуудыг байгуулсан. Сонгуулийн комиссууд нь хэтэрхий сүл бие даасан байдалтай, итгэл төрүүлдэггүй, үр ашиггүй ажилладаг гэх Африкт ч мөн адил ийм чиг хандлага уруу явж байна.

Латин Америкт сонгуулийн байгууллага нэлээн олон янз байдалтай байна. Аргентин, Бразил, Чили, Уругвай зэрэг улсад Сонгуулийн байгууллага нь бие даасан байх боловч шүүх эрх мэдлийн хүрээнд ажиллах жишээтэй.

Чухамдаа хөгжиж буй дэлхий ертөнцийг ардчиллах үйл явцад гарч буй дэвшил нь бие даасан комиссуудын сонгуулийг зохион явуулах үүрэг нэмэгдэж байгаа хандлагатай давхцаж байгаа юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 121 хөгжиж байгаа улс орнуудад хийсэн судалгаагаар тэдгээр улс орнуудын зөвхөн 21 нь л сонгуулийг Засгийн газраас зохион байгуулж байгааг олж тогтоосон байна. Бие даасан Сонгуулийн комиссууд сонгуулийг зохион явуулж буй хувь Латин Америкт 70 гаруй хувьтай, Ази, Номхон далайн орнуудад 55 орчим хувьтай, Сахарын бүсийн Африкт 50 гаруй хувьтай, Төв, Зүүн Европт 71 гаруй хувьтай байна. Харин өндөр хөгжилтэй ардчилсан цөөн тооны орнууд Сонгуулийн комисстэй байгаа юм. Гэхдээ сүүлийн үед мөн өндөр хөгжсөн ардчилсан улс орнууд, тухайлбал Их Британи, Швед зэрэг улсууд саяхан буюу 2001 оноос Сонгуулийн төв байгууллагатай болсон.

Бие даасан сонгуулийн байгууллагагүй өндөр хөгжилтэй ардчилсан улс орнуудад сонгууль зохион явуулах үүргийг Засгийн газрын байгууллага гүйцэтгэж байгаа бөгөөд түүнд тавих хяналтыг олон нийтийн зүгээс, шүүхээс хүчтэй тавьж хэрэгжүүлдэг байна.

1985-1994 онд болсон хөгжиж байгаа 50 улс оронд болсон сонгуулийн 23 нь бүтэлгүйтсэн бөгөөд тэдгээрийн гуравт нь л бие даасан Сонгуулийн комиссуудтай байсан. Эсрэгээр нь 23 улсад нь шилжилтийн сонгууль амжилттай болсны 12 нь бие даасан Комиссуудтай, 11 нь бүрэн бие даасан Комисстэй байжээ. 1983 онд Нигерийн үндэсний сонгууль бүтэлгүйтсэний учир нь сөрөг хүчний намууд эрх баригч хүчний хяналтад Сонгуулийн комисс байна гэж үзсэнтэй холбоотой. Мөн ийм шалтгаанаар 1997 онд Гайти, Камерунд сөрөг хүчин сонгуулийг бойкотолж байжээ. Бие даасан Сонгуулийн комиссууд байгуулагдсанаар сонгуулийн бүрэн дүүрэн амжилттай зохион байгуулахгүй боловч бие даасан сонгуулийн Комиссгүй байдал нь “эргэлзээтэй” сонгууль уруу хөтөлдөг нь түгээмэл байна. Иймд Сонгуулийн комиссуудыг бие даасан, чадвартай байхаар зохион байгуулах зүй ёсны шахалт, шаардлага амьдралаас урган гарах аж.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ - ХҮНИЙ ЭРХ

Ц.Цогт

Нийслэлийн Захиргааны
хэргийн шүүхийн шүүгч

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгогдсон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй. ...”¹ гэсэн заалт бие даасан, эрх мэдэл бүхий шүүх хүний эрхийг хамгаалах, түүний хэрэгжилтэд хяналт тавихад ямар чухал үүрэгтэй болохыг харуулсан юм.

Хэдийгээр манай улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдаад жил гаруй хугацаа өнгөрч байгаа боловч төр нь өөрийнхөө эсрэг буюу өөрийнх нь үйл ажиллагааг хянах дагнасан шүүхийг байгуулсан цөөн улсын нэг болж чадсан байна. Тухайн улсад шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хэр хэмжээнд байгаагаар хүний эрх, эрх чөлөөний бодит хэрэгжилтийг тодорхойлдог. Хүний эрхийг дээдлэн тунхаглах нь нэг хэрэг бөгөөд харин түүний бодитой хэрэгжилт нь хамгийн эргэлзээ, ээдрээтэй явдал байдаг.

Манай улсын хувьд ч хүний эрхийн хамгаалалт, түүний хэрэгжилт нь шүүх байгууллагатай шууд хамааралтай болохыг Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсон хоёрдугаар бүлэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”², Шүүхийн тухай хуульд “шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн”³ хэмээн тодорхойлсноос харж болох юм.

Ардчилсан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын хэрэгжилт, ялангуяа хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад шүүх байгууллагын тогтолцоо оновчтой, эрх мэдэл хүрэлцэхүйц байх ёстой. Энэ шаардлагаас урган гарсан нийгмийн хэрэгцээ, олон улсын хандлагаас улбаалан нийтийн засаглалын байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа ардчлалын үндсэн зарчмуудыг хэрхэн баримталж буйд захиргааны хэргийн шүүх дагнан хяналт тавих боломж бүрдсэн юм.

Төр гэдэгт шууд утгаар нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч - засгийн газар түүний харьяа захиргааны байгууллагуудыг хамруулдаг. Учир нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад хоёр засаглалын байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг Захиргааны хэргийн шүүх хянах хууль эрх зүйн үндэслэлгүй. Хууль тогтоох дээд байгууллагын үндсэн чиг үүрэг болох хууль батлах үйл ажиллагаанд Үндсэн хуулийн цэц (иргэдийн гомдлыг үндэслэн) хяналт тавьдаг, харин Үндсэн хуульд зааснаар шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой аливаа шийдвэрийг гагцхүү Улсын Дээд шүүх хянах журамтай.

¹ “Хүний эрх” Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ, 1998 он. 3-4 дэх талд.

² Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. 14-р зүйлд

³ Шүүхийн тухай хууль. 2002 он. 3-р зүйлд

Дээрхээс үзвэл Захиргааны байгууллага, түүний албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянах үндсэн чиг үүрэг бүхий дагнасан шүүх байгуулж, ажиллуулснаар Монгол улсад эрх зүйн (шүүхийн) хяналтаас гадна үлдэх төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа үгүй болсон байна. Энэ нь хүний эрхийн хэрэгжилт, хамгаалалтад эерэг нөлөөтэй болох нь тайлбарлалтгүй.

Захиргааны байгууллагын үйл ажиллагаа бүхэн нь тодорхой нэг шийдвэрийн эсхүл шийдвэр гаргах үйл явцын үр дүн байдаг. Нийтийн захиргааны бодлого, үйл ажиллагаа нийгмийн харилцааны бүхий л салбарт их өргөн хүрээнд хүртээмжтэй, нөлөөлөлтэй байдгийн улмаас захиргааны шийдвэр, тэдгээрийг үйлдэн гаргагч захиргааны байгууллага, албан тушаалтан маш олон төрөл, хэлбэртэйгээр оршиж байна.

Захиргааны хэргийн шүүхээр хянагдах хэргийн хариуцагч нь зөвхөн захиргааны байгууллага, албан тушаалтан байх нөхцөл нь энэхүү төрлийн маргааныг дагнан шийдвэрлэх шүүх, түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг тодорхойлох гол нөхцөл юм.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хүрээ хэмжээг тодорхойлохдоо “нийтийн захиргаа”-ны байгууллагын тогтолцоо, бүтцийг юун түрүүн анхаарах нь зүйтэй болов уу.

Захиргааны хэргээр дагнасан шүүхэд харьяалагдах хэргийн хариуцагч гэдэгт явцуу утгаар нь гагцхүү (1) төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүний албан тушаалтнуудыг ойлгохоос гадна өргөн утгаараа (2) хууль, тогтоолоор нийтийг засаглах чиг үүргийг өөртөө авсан засгийн газрын бус байгууллага, (3) нийтлэг үйлчилгээ үзүүлдэг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, сургууль эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний байгууллагын захиргаа, тэдгээрийн албан тушаалтнуудыг багтаасан байдаг. Эдгээрийг бүхэлд нь “нийтийн захиргаа” гэсэн нэр томъёогоор илэрхийлэх болсон байна.

Нийтийн захиргаа нь оршин тогтнож, “нийгмийг удирдан зохион байгуулах” зорилгоо биелүүлэхийн тулд хуулиар олгогдсон бүрэн эрх эдэлж, тодорхой үүрэг хүлээсэн байдаг. Нийтийн захиргаа нь энэхүү иргэдийн аюулгүй байдлыг хамгаалж, тэдгээрийн нийгэм дэх амьдралыг зохицуулж, хэрэгцээг нь хангахын тулд удирдлагын хүрээнд олон төрлийн үйл ажиллагааг явуулдаг. Гэвч “захиргаа” нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ихэнхдээ захирамжилсан шинжтэй арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд “захиргааны акт” үйлдэх аргаар илэрдэг.

Энэхүү нэг талын хүсэл зоригоор харилцааг зохицуулах арга, захирах ёсны хэвшсэн заншил, шийдвэрийг түүний үр дагаврыг өөртөө хүлээгчид (шийдвэрт өртөгсөд) цөөнгүй тохиолдол эсэргүүцэж, энэ нь захиргаа, түүний шийдвэрийг хүлээн авагч иргэний хооронд тухайн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн талаар маргаан гарах үндэслэл болдог.

Иргэний шүүх нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэдэг бол эрүүгийн шүүх нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг. Харин захиргааны хэргийн шүүх нь иргэн, хуулийн этгээдээс нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд

холбогдуулан гаргасан маргааныг хянан шийдвэрлэж, тухайн захиргааны шийдвэр, үйл ажиллагаа, эс үйлдэхүйд иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу гаргасан гомдол, нэхэмжлэлд үндэслэн захиргааны хэрэг үүсгэн тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн эсэхийг тогтоож, зөрчигдсөн эрхийг нь сэргээж захиргааны албан тушаалтан, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох тэргүүн зэргийн чиг үүрэгтэй дагнасан шүүх байдаг.

Захиргааны хэргийн шүүхүүд 2005 оны эхний хагас жилд 411 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авч, 37.2 хувь буюу 153 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, харин нийт нэхэмжлэлийн 49.4 хувь буюу 203 нэхэмжлэлд захиргааны хэрэг үүсгэн, шалгаж шийдвэрлэжээ. Энэ хугацаанд Дундговь, Булган аймгийн захиргааны хэргийн шүүх хэрэг шийдвэрлээгүй байна.

Шийдвэрлэсэн захиргааны хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл: Монгол улсын Их Хурлын сонгуулийн хуулиар 1, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулиар 43, Төрийн албаны тухай хуулиар 30, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар 3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар 5, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар 3, Газрын тухай хуулиар 27, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар 4, Ашигт малтмалын тухай хуулиар 7, Татварын багц хуулиар 14 хэрэг шийдвэрлэжээ. Эдгээр 137 хэрэг нь нийт шийдвэрлэсэн захиргааны хэргийн 67.5 хувийг эзэлж байна⁴.

Улсын Дээд шүүх, Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслөөс хамтран (олон нийтэд зориулан хэвлэн) гаргаж байгаа “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр” эмхтгэл нь захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээл авах боломжийг сонирхогч хүн бүрт олгож байгаа нь шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох болон иргэдийн эрх зүйн мэдлэгт тустай алхам болсон юм.

Эрүү, иргэний хэргийн шүүхээс онцлогтой нь Захиргааны хэргийн шүүх өөрөө хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, захиргааны актын хууль зүйн үндэслэлийг нотлох үүрэгтэй байдаг. Энэ нь иргэдийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай нотлох баримтыг гаргаж авах гэж цаг хугацаа алдах, үүнээс эрх нь улам даамжран зөрчигдөхөөс сэргийлсэн нөхцөл гэж ойлгож болно. Мөн шүүх энэ нотлох үүргээ хэрэгжүүлэхийн тулд хуулиар тогтоосон ердийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэггүй “мөрдөн шалгах” зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа баримтлах эрхтэй байдаг. Эдгээр нь нотлох баримтыг захиргаанаас шаардан гаргуулах, газар дээр нь үзлэг хийх зэрэг хэлбэрээр хэрэгждэг.

Шүүх нэхэмжлэлд үндэслэн захиргааны хэрэг үүсгэсэн тохиолдолд нэн даруй тухайн “маргаан бүхий” захиргааны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх

⁴ Улсын Дээд шүүхийн судалгааны төв. 2005 оны хагас жилийн шүүн таслах ажлын мэдээнээс иш татав.

ёстой. Захиргааны хэргийн шүүх “маргаан бүхий” захиргааны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрхтэй байгаа нь хүний эрхийг захиргааны хууль бус үйл ажиллагаанаас шуурхай, цаг алдалгүй хамгаалах боломжийг бий болгосон нийгмийн амьдралд нийцсэн, оновчтой хууль зүйн зохицуулалт болсон юм.

Гэвч хуульд тусгайлан заасан зарим тохиолдолд шүүхэд хянагдаж буй захиргааны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрхгүй байдаг. Жишээ нь: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас батлан гаргасан Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтад ашиглах “сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх” журмын хэрэгжилтийг хэдийгээр шүүх энэ журам хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэхээр хэрэг үүсгэн шалгаж байгаа боловч зогсоох, түдгэлзүүлэх эрхгүй. Учир нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хэм хэмжээ тогтоосон захиргааны шийдвэр (дүрэм, журам гэх мэт)”-ийн биелэлтийг шүүх зөвхөн тухайн салбарын хуульд түдгэлзүүлж болохоор зохицуулсан нөхцөлд түдгэлзүүлэх, түүнээс бусад тохиолдолд түдгэлзүүлэх эрхгүй хэмээн заасан байдаг.

Захиргааны хэрэгт өнгөц харвал иргэн - захиргааны байгууллага гэсэн хоёр маргагч талууд байдаг боловч ихэнх хэрэгт “гуравдагч этгээд” оролцдог. Шүүхээс хоёр талын маргааныг хянаад гаргах шийдвэр нь өөр бусад (гуравдагч) этгээдийн эрх ашгийг хөндөж болзошгүй тохиолдолд шүүх санаачлагаараа эсвэл тухайн этгээдийн хүсэлтээр хэргийг шийдвэрлэх ажиллагаанд “гуравдагч этгээд”-ээр татан оролцуулдаг. Ингэснээр “гуравдагч этгээд” нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нотлох баримт гаргах гэх мэт эрхийг эдлэх боломжтой болдог.

Ялангуяа газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон Засаг даргын шийдвэр, ашигт малтмалын хайгуул хийх эсхүл ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл олгосон Ашигт малтмал асуудал эрхэлсэн агентлагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан Тендерийн хорооны шийдвэр зэргийг хүчингүй болгох шаардлага бүхий захиргааны хэрэгт гуравдагч этгээд буюу дээрх шийдвэрүүдээр тухайн эрхийг авсан этгээд зайлшгүй оролцох шаардлагатай.

Захиргааны хэргийн шүүхэд хандахаас өмнө иргэн, хуулийн этгээд (нэхэмжлэгч)-эд тавигддаг хамгийн гол шаардлага бол гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлсэн байх явдал юм. Тухайн хууль бус шийдвэр, үйл ажиллагааг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтныг шууд харьяалдаг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан гомдол гаргах ёстой. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтныг тодорхойлоход хүндрэлтэй байвал тухайн албан тушаалтныг томилж, чөлөөлдөг, эсхүл шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй байх шинжийг голлон анхаарах нь зүйтэй.

Хэрэв шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй тохиолдолд гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлага тавигдахгүй, шууд захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй. Мөн (1)дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас гомдлыг захиргааны

журмаар урьдчилан шийдвэрлэснийг эс зөвшөөрсөн, (2)дээд шатныхаа захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, (3)шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг 30 хоногийн хугацаанд хянан шийдвэрлээгүй зэрэг тохиолдлуудад Захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрх нээгдэх хууль зүйн нөхцөл бүрдэнэ.

Шүүхэд нэхэмжлэл гаргахад тавигдах дээрх шаардлагыг биелүүлээгүйгээс жишээ нь Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх 2004 онд нийт **160** нэхэмжлэл хүлээн авснаас **84** нэхэмжлэлийг, 2005 оны 10-р сарын 01-ний байдлаар нийт **214** нэхэмжлэл хүлээн авснаас **56** нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан⁵ байна.

Гэтэл тус шүүх хүлээн авахаас татгалзсан 2004 оны 84 нэхэмжлэлийн 41, 2005 оны 56 нэхэмжлэлийн 24 нь тус бүр гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүйгээс буцаасан байна.

Захиргааны хувьд хуулиар олгогдсон нэгэн чухал боломжийг бүрэн дүүрэн ашиглах явдал өнөөгийн байдлаар их дутагдалтай байдаг. Энэ юу вэ гэвэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль өөрөө үндсэн хоёр хэсгээс бүрддэг. Нэг нь захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, нөгөө нь иргэдийн гомдлыг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэсэн хоёр хэсгээс тогтдог.

Гомдлыг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх журам нь захиргааны байгууллага тухайн маргаантай асуудлыг дотооддоо шийдвэрлэх боломжийг захиргаанд олгосон юм. Харамсалтай нь энэ журмыг ашиглахгүй, дотоод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрт гарсан гомдлыг үндэслэлтэй хуульд заасан журмын дагуу хянаж шийдвэрлэдэггүйгээр барахгүй өөрөөр нь шийдвэрлүүлэхээр гомдлыг тухайн албан тушаалтанд шилжүүлэх зэрэг байдал их байна. Энэ байдлыг нэгдүгээрт захиргааны хэргийн шүүх нь нэхэмжлэл гаргаж буй иргэн, хуулийн этгээдүүдээс гомдлоо захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэхийг шаардах, хоёрдугаарт захиргааны байгууллага (дээд шатны) нь уг гомдлыг зохих журмын дагуу өөрөө хянаж шийдвэрлэдэг болох замаар маргааныг “хялбар, үр нөлөөтэй” шийдвэрлэх арга хэрэгсэл болгох боломжтой.

Хэдийгээр захиргааны хэргийн шүүхийн тэргүүн зэргийн чиг үүрэг нь захиргааны болзошгүй “дур зоргийн” үйл ажиллагаанаас иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах явдал мөн боловч нөгөө талдаа нийтийг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн шийдвэр гаргах зорилгоор байгуулагдсан захиргааны байгууллагын хууль ёсны шийдвэр үйл ажиллагааг баталгаажуулах, иргэдийн хуулиас хальсан “хязгааргүй эрх чөлөө”-нөөс хамгаалах тохиолдол байдаг.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэн, хуулийн этгээд (1)зөвхөн өөрийнх нь субъектив эрх тухайн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас шууд шалтгаалан зөрчигдсөн гэж үзвэл тэр зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр захиргааны хэргийн шүүхэд хандах (2)иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн гэж үзэж байгаа эрх, ашиг сонирхол

⁵ Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2005 оны эхний гурван улиралын шүүн таслах ажлын мэдээнээс иш татав.

нь заавал хуулиар тэдгээрт олгогдсон байхыг шаарддаг.

Өөрөөр хэлбэл хуулиар олгогдоогүй эрх ашиг сонирхлыг сэргээлгэхээр шүүхэд хандах боломжгүй. Мөн түүнчлэн огт үндэслэлгүй асуудалд маргаан үүсгэж, захиргааны байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй байхын эсрэг нэхэмжлэгчийн хариуцлагын нөхцөл болгон улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал гэх мэт хэлбэрүүдийг хуулиар тогтоосон байдаг.

Иргэд тэдэнд хуулиар олгогдсон эрх, хамгаалагдсан ашиг сонирхлыг нь зөрчсөн гэх үндэслэл байвал Захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй, хэрэв энэ нь тогтоогдвол захиргааны шүүн таслах ажиллагааны үр дүнд (заримдаа захиргаа дотроо урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд) тэр эрх, ашиг сонирхол нь хамгаалагдах ёстой.

Харин нэхэмжлэлийн шаардлага хууль зүйн үндэслэлгүй бол захиргааны шийдвэр, үйл ажиллагаа хууль ёсны гэдэг нь шүүхийн шийдвэрээр давхар баталгаажиж энэ утгаараа захиргааны байгууллагын хууль ёсны шийдвэр үйл ажиллагаа-ны хууль зүйн хүчин төгөлдөр байдлыг улам бататгах юм.

Дагнасан шүүх байгуулагдсанаас хойшхи энэ богино хугацаанд зарим нэг захиргааны байгууллага, албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагааг энэ шүүхээр хянуулахгүй байх, хяналтаас нь гаргах алхам хууль тогтоох замаар хийгдсэн⁶, мөн “энэ шүүхийн хянаж байгаа хэргийг урьд ердийн шүүх хянаад болоод байсан, ер нь илүү зардал гарган ийм шүүх байх зайлшгүй шаардлагатай эсэх” тухай санал, яриа улс төр, нийгэм, хууль зүйн салбарын хүрээнд гарч байгаа нь манай улс Хүний болон иргэний эрхийг шүүхээр хамгаалах асуудалд нэгэнт хүрсэн дэвшилтэд үр дүнгээс алхам алхамаар ухрах ... хандлага биш биз.

Захиргааны хэргийн шүүхээр дамжуулан иргэдийн эрхийг хамгаалах, хангах энэ ажил хүний эрх, хууль зүйн салбарын мэргэжилтнүүдийн олон жилийн хөдөлмөрийн үр дүн, түүний дээр ард олны өргөн дэмжлэгтэйгээр бодитой болсон бөгөөд захиргаа хязгааргүй эрх мэдэлтэй байж, шийдвэр үйл ажиллагаагаа (иргэдийн гомдлоор) шүүхийн журмаар хянуулахгүй байх нь лав л ард олны хүсэл эрмэлзлэл биш. Мөн түүнчлэн энэхүү дагнасан шүүхийн үйл ажиллагааг хүчгүйдүүлэх замаар нийтийн захиргааны үйл ажиллагаанд иргэдээс гаргах зүй ёсны гомдлыг шударгаар шийдвэрлэх субьектгүй болгох нь мөн л иргэдийн сонирхол биш юм.

Нөгөөтэйгүүр нийтийн засаглалын байгууллага, түүний албан тушаалтнууд үнэхээр хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулсан бол дагнасан шүүхээр хянуулахад эмзэглэх, бултах шаардлага байхгүй. Хүний эрхийг хангах талаасаа: Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж ажилласнаар “хүний эрхийг хангах хууль зүйн баталгаа өргөжиж улмаар хамгаалах шинэ бөгөөд хүчтэй механизмтай болсон, нийтийн захиргааны хүрээнд гарсаар буй авилга, хүнд суртал чирэгдлийг хязгаарлан багасгаж, тэдгээр сөрөг үзэгдэлтэй тэмцэх шинэ арга хэрэглүүр бий болсон”⁷ зэрэг түгээмэл ач холбогдолтой юм.

⁶ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн зарим заалтуудыг 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон нь Засгийн газрын бүхий л шийдвэр, үйл ажиллагааг дагнасан шүүхийн хяналтаас гаргасан шинжтэй болсон.

⁷ Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. Ханнс Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” Академи. УБ. 2004. 60-61-р талд. Б.Чимид.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ

Д. Ганзориг
МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн багш

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу захиргааны байгууллагын дур зоргын үйл ажиллагаанаас хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүрэг бүхий дагнасан шүүхийг 2004 оны 6 дугаар сард байгуулан ажиллуулж байна. Энэ хугацаанд захиргааны хэргийн шүүх сонгуулийн хэрэг маргаанаас эхлүүлээд иргэдийн газар өмчлөх, төрийн алба хаах, сурч боловсрох эрхтэй холбоотой олон төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн. Эдгээр шүүхийн шийдвэрүүд эхнээсээ шийдвэр гүйцэтгэлийн шатанд очиж, хууль бус үйл ажиллагаа явуулсан захиргааны байгууллага, албан тушаалтны акт-¹ыг илт хууль бус гэж тооцох, хүчингүй болгох, захиргааны байгууллагын хууль бусаар үүргээ биелүүлэхгүй байгааг “засах” зэрэг иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалсан (хангасан), сэргээсэн зөв чиглэл нэгэнт бий болжээ. Нөгөөтэйгүүр шинэ байгуулагдсан шүүх бөгөөд урьд өмнө нь практик хомс тул захиргааны хэргийн шүүхийн хувьд шийдвэрлэх тулгамдсан олон асуудал байгааг² эрдэмтэд судлаачид, шүүгч нар тал талаас нь хэлэлцэж ярилцаж байна. Шүүхийг анхнаас нь “зөв” чиглэлтэй байлгаж, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж байх нь эцсийн бүлэгтээ хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгэм байгуулахад тус дөхөмтэй учраас ийнхүү санаа зовниж байгаа болов уу. Энэ сэдвийн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, түүний хэрэгжүүлэхтэй холбогдон гарч буй зарим асуудлыг хөндөхийг зорив.

Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авахаас эхэлнэ. Ер нь захиргааны хэргийн шүүх захиргааны актын “хууль зүйн үндэслэлийн тухай” асуудлыг шийдвэрлэх ажиллагаагаа өөрийн санаачилгаар бус гагцхүү иргэн, хуулийн этгээдээс

¹ “захиргааны акт гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /үйлдэл, эс үйлдэхүй/-г; энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /зарлиг, тогтоол, дүрэм, заавар, журам/-ийг захиргааны актад хамааруулна;” (ЗХХШХ-ийн 3.1.4)

² Захиргааны хэргийн шүүхийн тулгамдсан асуудал гэдгийг багцлахыг оролдвол а) хэрэг хянан шийдвэрлэх зарчим нь ямар байхыг шийдвэрлэх, б) хэргийн оролцогч нарын эрх зүйн байдлыг тодруулах в) шүүхийн шийдвэрийн үндэслэл нь ямар байхыг тодорхойлох, г) давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь ямар байхыг тодорхойлох зэрэг байх болов уу. (Д.Г)

гаргасан нэхэмжлэлийг үндэслэж явуулдаг онцлогтой. Тиймээс иргэн, хуулийн этгээдийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх гэж юу болох, энэ эрх нь хэдийд үүсдэг, (цаг хугацааны зохицуулалт), нэхэмжлэл гаргах процесс нь ямар байх, нэхэмжлэгч болсноор түүний эрх зүйн байдал нь хэрхэн тодорхойлогдох гээд олон төрлийн асуудал нь (нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой) энэ ажиллагааны “үндэс суурь” болдог.

Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн эрх зүйн үндэс буюу суурь зарчмыг шинэ Үндсэн хуулиар тодорхойлсон. Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар иргэн нь “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуудахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй”.³

Үндсэн хуулийн суурь зарчмын дагуу захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой харилцааг ЗХХШХ-ийн 12 дугаар зүйлээр нарийвчлан зохицуулжээ. Үүнд иргэн, хуулийн этгээд

- 1) хуульд тусгайлан заасан;
- 2) дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас ЗХХШХ-ийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу⁴ гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;
- 3) захиргааны байгууллага, албан тушаалтан ЗХХШХ-ийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;
- 4) шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй гэсэн 4 тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Энэ зүйлээс хэд хэдэн асуудал гарч ирнэ. Нэхэмжлэл гаргах эрхийг ямар субъект эдлэх, ямар хугацаанд нэхэмжлэл гаргах зэрэг асуудал байна.

Нэг. Нэхэмжлэл гаргах эрхтэй субъект. Хуульд зааснаас үзвэл нэхэмжлэл гаргах эрхийг эрх чадвар, чадамж бүхий иргэн, мөн Иргэний хуульд заасан

³ Үндсэн хуулийн Цэшийн гаргасан шийдвэрийг үндэслэж Улсын Их Хурлаас ЗХХШХ-ийн 4-р зүйлд өөрчлөлт оруулж, “иргэн Засгийн газар болон Сонгуулийн Ерөнхий хорооны актыг хууль бус гэж үзсэн тохиолдолд нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд бус харин Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргахаар “зохицуулсан” нь энэхүү эрх рүү халдсан, иргэн өөрийн эрхийг зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр шүүхэд хандаг эрхийг хязгаарласан, гүйцэтгэх дээд байгууллага (захиргааны)-ыг шүүхийн хяналтаас гаргасан алхам болсон гэж үзэж байна. Энэ нь хэдийгээр тусдаа асуудал мэт харгадгавч тодорхой тохиолдолд хэрхэн яаж зохицуулах нь ойлгомжгүй байдлыг үүсгээд байна. Жишээ нь Засгийн газар Үндсэн хуульд заасны дагуу “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах” (Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4) үүрэгтэй. Засгийн газар болон түүний бүтцийн байгууллагууд нь энэхүү үүргээ биелүүлээгүйгээс хөдөөд олон малчин малаа бэлчээх газаргүй, гол булаг байхгүй болох гэх мэтээр орон нутагтаа амьдрах аргагүй болж, хохирч байна. Иймээс тухайн нутгийн иргэд зөрчигдсэн эрхээ сэргээлгэх зорилгоор шүүхэд хандах эрхтэй. Гэтэл тийм механизм байхгүй, Үндсэн хуулийн Цэцэд хандлаа гэхэд хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлоо төлүүлэх талаар шийдвэр гаргах боломжгүй зэрэг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахгүй харилцаа үүсчээ.(Д.Г)

⁴ ЗХХШХ-ийн 8-р зүйлээр захиргааны дээд шатны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан үзээд ямар шийдвэр гаргаж болох тухай харилцааг зохицуулсан байна.

хуулийн этгээд⁵ эдлэх нь тодорхой байна. Ийнхүү тодотгохын учир нь зарим тохиолдолд эрх зүйн чадамжгүй буюу явуулсан үйл ажиллагааныхаа төлөө хууль, шүүхийн өмнө хариуцлага хүлээх чадвар, чадамжгүй этгээд нэхэмжлэл гаргах явдал цөөнгүй байгаатай холбоотой юм. Эцэг эхийн зөвлөл, тендерт өрсөлдсөн баг, эсхүл зарим үед албан ёсоор бүртгүүлээгүй этгээд нэхэмжлэл гаргах тохиолдол байна. Үүнээс үүдэн нэхэмжлэл гаргах эрхгүй субъект нэхэмжлэл гаргаснаас шүүх түүнийг хүлээн авахаас татгалзах үр дагавар үүсч болзошгүй.

Нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд эдлэх үү эсхүл эрх зөрчигдөөгүй ч гэсэн тухайн захиргааны актыг хууль бус гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх уу гэсэн асуудал нь сонирхол татсан, бас маргаантай асуудал бололтой. Шүүхээс зөвхөн эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд л шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээр хангагдана гэсэн практикийг хэвшүүлж байна гэж ойлгогдож байна. Иргэн, хуулийн этгээд нэхэмжлэл гаргахдаа тухай актыг (захиргааны) яагаад хууль бус гэж үзэж буй үндэслэлээ өөрийн өмгөөлөгчөөс эсхүл хууль зүйн товчооны туршлагатай хуульчаас асууж, лавласан байвал сайн байдаг. Захиргааны алдаатай актыг “илт хууль бус акт”, “маргаан бүхий акт” гэж ангилж байгаа⁶ бөгөөд илт хууль бус акт гэж үзэх тохиолдлыг хуулиар тохиолдол тус бүрээр тодорхойлсон⁷ байдаг бол маргаан бүхий актын хувьд эрх нь зөрчигдсөн болохыг тогтоох асуудал нь маргааны гол зүйл болдог. Нэгэнт хуулиар захиргааны илт хууль бусад тооцох нөхцөл (тохиолдол) тодорхой заагдсан учраас энд эрх зөрчигдсөн тухай асуудал бус харин захиргааны акт хуулиар тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг шүүх шийдэх нь тэргүүн зэргийн асуудал болох юм. Захиргааны илт хууль бус акт байгаа тохиолдолд хүний эрх, эрх чөлөө тодорхой хэмжээгээр хөндөгдөж, зөрчигдөх нь ойлгомжтой. Эдгээрийг үндэслэж захиргааны илт хууль бус актад тооцох нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд “нэхэмжлэгчийн (иргэн, хуулийн этгээдийн) эрх (субъектив) зөрчигдсөн эсэх шалгуур”-аар хязгаарлах шаардлагагүй гэж үзэж байна. Харин захиргааны актыг маргаан бүхий акт гэж үзэж, хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага гаргавал өөрийн зөрчигдсөн эрхийг тодорхойлж, “нотлох” нь нэхэмжлэгчийн “үүрэг” болно.

⁵ Өмчлөдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. (Иргэний хуулийн 25.1)

⁶ Энэ талаар П.Одгэрэл “Захиргааны эрх зүй. Ерөнхий анги”, УБ, 2004 он сурах бичигтээ дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

⁷ “1) Захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай; 2) бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй; 3) захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан; 4) захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус; 5) хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан; 6) нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн; 7) захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй; 8) захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн; 9) захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрсөн бол захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрдөг.” (ЗХХШХ-ийн 9-р зүйлээс)

Монгол Улсын хувьд захиргааны актад хэм хэмжээ тогтоосон зарлиг, дүрэм, заавар зэргийг хамааруулахаар заасан талаар урьд тэмдэглэсэн билээ. Гадны орнуудынхтай харьцуулвал энэ нь манай онцлог бөгөөд нийгмийн харилцааг хуулиар зохицуулах процесс явагдаж байгаа, захиргааны байгууллага өөрийн санаачилгаар хэм хэмжээ тогтоосон акт гаргах явдал түгээмэл байдагтай холбоотой. Ийм төрлийн захиргааны акт нь хууль тогтоомжид нийцсэн нь ч байна, мөн түүнд нийцээгүй актууд элбэг тохиолддог. Жишээлбэл, саяхан оюутнуудын жагсаал болж, төрийн ордон руу чулуу, мод нүүлгэсэн хэрэг болов. Оюутнуудыг ийнхүү жагсахад хүргэсэн нэг шалтгаан нь Засгийн газраас гаргасан тогтоол байсан бололтой. (Засгийн газрын 2003 оны 233-р тогтоол). Энэ тогтоолоор төрийн үйлчилгээний туслах албан тушаал эрхэлж буй хүмүүсийг төрийн албан хаагчийн чухал баталгаа⁸ хэмээн манайдаа тооцогддог “төрийн албан хаагчийн нэг хүүхдийн зардлыг төрөөс хариуцна” гэсэн заалтад хамааруулахгүйгээр заажээ. Ийнхүү хуулийн хэм хэмжээгээр хязгаарлаагүй заалтыг захиргааны байгууллага өөрийн актад оруулснаар хууль дээдлэх зарчмыг зөрчсөн. Ийм ч учраас Засгийн газар өөрөө хүчингүй болгосон болов уу. Хэм хэмжээ тогтоосон актын онцлог нь тодорхой нэг субьектэд чиглэгддэггүй, түүнийг тухайн нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрддөгт оршдог. Бүх нийтээр дагаж мөрддөг учраас тухайн актаар олон хүний (иргэн, хуулийн этгээдийн) эрх, ашиг сонирхол хөндөгдөнө. Тухайн хэм хэмжээ тогтоосон актаар эрхээ зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэн түүнийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах нь зүйн хэрэг. Харин энэ эрхийг хэм хэмжээ тогтоосон актаар шууд эрх нь зөрчигдсэн иргэн эдлэх үү, эсхүл эрх нь зөрчигдөөгүй боловч тухайн актыг илт хууль бус болохыг нотолж чадах иргэн мөн эдлэх үү гэсэн асуудал гардгийг шийдэх ёстой.

ЗХХШХ-д нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд зэрэг гаргаж болох тухай заалт бий. Тухайлбал, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно. Гэхдээ энэ тохиолдолд нэхэмжлэгчид дундаасаа төлөөлөгч томилон итгэмжлэл буюу бүрэн эрх олгож, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулах эрхтэй.

Хоёр. Нэхэмжлэл гаргах хугацаа. Ихэнх тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах хугацааг эрхээ зөрчигдсөнийг мэдсэнээс эсхүл тухай актыг гардаж авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд нэхэмжлэх эрхтэй гэж ойлгодог. Гэтэл энэ бол ташаа ойлголт юм. Учир нь хуульд энэхүү хугацааг зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд баримтлахаар заажээ.⁹ Тиймээс

⁸ “Гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхдийнх нь сургалтын зардлыг дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр тооцож төр хариуцах” (Төрийн албаны хуулийн 27.1.10)

⁹ “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.” (ЗХХШХ-ийн 6.1)

захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад хугацааны ямар нэг хязгаарлалт байхгүй. Хууль тогтоогч ийнхүү тогтоохдоо гадаад орнуудын, (юуны өмнө германы) туршлагыг харгалзан үзсэн бөгөөд нэхэмжлэл гаргах эрхийг хугацаагаар хязгаарлах нь Үндсэн хуульд заасан суурь зарчимтай харш байж болзошгүй гэж үзсэнээс гадна манай орны хувьд шинэ Үндсэн хууль батлагдахаас өмнө гарсан захиргааны акт өнөөг хүртэл үйлчилсээр байгааг тооцсон болов уу. Харин нэхэмжлэл гаргахад зайлшгүй байдаг угтвар нөхцөл буюу тухайн хэрэг маргааныг дээд шатны байгууллага, албан тушаалтан хянан үзэх-урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулсан байвал зохино. Ингэхийн тулд захиргааны дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргадаг бөгөөд энэ харилцааг одоогоор Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуулиар¹⁰ зохицуулж байна. Гэхдээ зарим тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд шууд хандаж, нэхэмжлэлээ гаргах боломжийг хуулиар үгүйсгээгүй байна. Тухайлбал, тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд дээд шатны байгууллага, албан тушаалтан (харьяалах) байхгүй бол шууд шүүхэд нэхэмжлэлээ гаргаж болно.¹¹ Түүнээс гадна уурьдчилан шийдвэрлэх ажиллагааг заавал явуулсны дараа шүүхэд хандах (нэхэмжлэл гаргах) ёстой” гэдэг нь хуулийг хэт “шууд” утгаар буюу “махчилж” ойлгосон ойлголтын “үр дүн”. Учир нь хуульд “урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй байсан тохиолдол” гэдгийг тухайлан заасан байна.¹² Амьдралд ч захиргааны дээд шатны байгууллагад хандаж, гомдол гаргах боломжгүй тохиолдол гардаг. Энэ тохиолдолд шүүхээс иргэн, хуулийн этгээдийн эрхийг хангахад чиглэсэн ажиллагаа явуулах нь дамжиггүй.

Грав. Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн агуулга. Иргэн, хуулийн этгээд нэхэмжлэлээ гаргахдаа хуульд заасан шаардлагыг хангасан байна. Тухайлбал, нэхэмжлэлд заавал тусгах зүйл гэж бий. Үүнд 1) нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа; 2) нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг; 3) нэхэмжлэлийн шаардлагын агуулга; 4) хавсаргасан баримт бичгийн жагсаалт орно. Эдгээрээс хамгийн гол зүйл бол нэхэмжлэлийн шаардлагын агуулга болно. Хуульд нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг дараахь байдлаар заажээ.¹³

1. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнийг нотолж чадах бол тухайн актыг хүчингүй болгуулах;
2. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх;

¹⁰ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол иргэн, хуулийн этгээд нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар энэ хуулийн 6.1.-д заасан хугацаанд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана. (ЗХХШХ-ийн 12.2)

¹² “Захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой;” гэж ЗХХШХ-ийн 34.1.4-д заасан байна.

¹³ ЗХХШХ-ийн 32.5

3. маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай;
4. захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсч байгаа.

Нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг зөв тодорхойлох нь нэхэмжлэлийг хангах үндсэн нөхцөл болно. Нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодорхойлоход захиргааны актын мөн чанарыг зөв таньж, ойлгох чухал байдаг. Хүмүүс ихэнх тохиолдолд акт гэдгийг бичмэл зүйл гэж өрөөсгөлөөр ойлгодог. Гэтэл захиргааны актыг бичмэл шийдвэрээс гадна ерөөсөө захиргааны байгууллагын бүхий үйл ажиллагааг ойлгох тухай заалтыг дээр өгүүлсэн билээ. Нэхэмжлэл гаргахдаа гол төлөв “хүчингүй болгож өгнө үү” гэсэн шаардлага тавих нь олонтаа. Гэтэл аман шийдвэрийг эсхүл эс үйлдэхүйг (үүргээ хугацаанд нь биелүүлэхгүй байгааг) хүчингүй болгох тухай ойлголт байхгүй болох нь хэн бүхэнд ойлгомжтой.

Эдгээрээс гадна иргэн, хуулийн этгээд нэхэмжлэл гаргахдаа тухайн актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт тавьж болох тухай заалт бий.¹⁴ Захиргааны актын биелэлтийг хуульд заасан журмын дагуу түдгэлзүүлж байх нь нэхэмжлэгчийн эрхийг хангах чухал механизм гэдэг талаас нь авч үзэх учиртай.

¹⁴ ЗХХШХ-д “ 45 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх

45.1.Энэ хуулийн 46 дугаар зүйлд болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.

45.2.Хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг зөвхөн хуульд зааснаар түдгэлзүүлж болно.

46 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл

46.1.Захиргааны актын биелэлтийг дараахь тохиолдолд түдгэлзүүлж болохгүй:

46.1.1.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноштой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол;

46.1.2.иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол;

46.1.3.захиргааны журам зөрчсөн этгээдэд хариушлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол;

46.1.4.хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол.” гэж заажээ.

ХҮНИЙ ЭРХЭЭР МЭТГЭЛЦЭХҮЙ: ХҮНИЙ ЭРХ ТҮГЭЭМЭЛ ШИНЖТЭЙ ЮУ? (DEBATING HUMAN RIGHTS; ARE HUMAN RIGHTS UNIVERSAL?)

Ч.Алтангэрэл
МУБИС-ийн Нийгмийн
ухааны тэнхмийн багш

Хүн төрөлхтөний эрх чөлөө, шударга ёс, тэгш эрхийн төлөөх олон зуун жилийн эрэл хайгуул, тэмцлийн үр дүнд Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн түгээмэл Тунхаглалыг батлан гаргасан явдал нь дэлхий дахины нийгэм-улс төрийн сэтгэлгээ, оюун санааны үнэт зүйл болон хүлээн зөвшөөрөгдсөн. Хүний эрхийн түгээмэл Тунхаглал нь дэлхийн улс үндэстнүүдийн улс төр, эдийн засаг, соёлын түүхэн хөгжлийн үр дүн, тэдгээрийн олон ургальч үзэл санаа, эрх чөлөөний төлөөх тэмцлийн зүй ёсны үр дүн болон томъёлогдсон юм.

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд заасан хүний эрх, эрх чөлөөний мөн чанар, агуулга нь тодорхой нэг соёл, уламжлалын хүрээнд буюу өрнөдийн либераль ардчилсан уламжлалаас хүрээнд үүсэн бүрэлдсэн гэж үздэг. Ялангуяа энэхүү Тунхаглалын үзэл санааны иш үндэс болсон Английн 1648 оны хувьсгал, АНУ-ын 1776 оны “Тусгаар тогтнолын тунхаглал”, 1789 оны Францын “Хүний болон Иргэний эрхийн тунхаглал” зэрэг баримт бичгүүд нь цөм өрнө дахины соёлын дотоодод бүрэлдэн бий болсон нийгэм улс төрийн сэтгэлгээний өв сангаас үүдэлтэй. Ийн хүний эрхийн сонгодог ойлголт, үзэл санаа нь “хүний нийгэм улс төрийн үйл ажиллагааны дээд үнэлэмж нь эрх чөлөө хийгээд үүрэг хариуцлага юм хэмээн үзсэн Платон, Аристотель нараас эхлээд бие хүний дотоод үнэлэмж, үйлийн учир шалтгааныг онцлон үзэж асан дундад үеийн сэтгэгчид, хувь хүний бие даасан байдал, хууль эрх зүйн субъект болох, гэрээ хэлцэл байгуулах, өөртөө эрх үүргийг хүлээн авах зэрэг шинж чанаруудыг онцгойлон авч үзсэн Гоббс, Локк, Руссо¹ нарын зэрэг үе үеийн сэтгэгчдийн үзэл бодол, мэтгэлцээний үр дүнд бүрэлдэн тогтжээ.

Хүний эрх нь хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлс болохынхоо хувьд хаана ч, хэзээ ч, бүхий л улс үндэстнүүд, овог аймаг, шашин шүтлэгтнүүдэд хамааралтай, хүчин төгөлдөр байх ёстой. өнгөрсөн хийгээд өнөөгийн түүх нь хүн төрөлхтөний эрх, эрх чөлөөний асуудал нь янз бүрийн соёл уламжлал болон төрийн хэлбэр, байгууламжаас шалтгаалан олон талт арга хэлбэрээр өрнөж ирснийг гэрчилнэ. Нэгэнтээ Ю.Хабермасын тодорхойлсноор: Хүний

¹ Antonia Perez Estevez Intercultural Dialogue and Human Rights: The Law of Peoples. 1998

эрх нь бүх нийтийн сайн сайхан байдлын төлөө бидний өвөг дээдсийн бүтээсэн нийгэм, түүний орчинд хамаарагч аливаа иргэдийн эдлэх хамгийн наад захын хууль зүйн эрх хэмжээ байх ёстой. Уг хууль нь төрд хамаарч байгаа иргэдийн хоорондын харилцааг, харин олон улсын хууль нь төр хоорондын харилцааг зохицуулдаг ажээ². Үнэхээр орчин үеийн дэлхий дахины хөгжлийн үйл явц нь хүний эрхийн асуудлыг аливаа улс орны дотоодод төдийгүй улмаар олон улсын шинжтэй глобал үйл явц болон өрнөхөд хүргэж байна. Үүний үр дүнд хүний эрхийн олон улсын гэрээ конвенциуд, тэдгээрийн хэрэгжилтийг шалган хянах НҮБ, түүний бүрэлдэхүүн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн шүүх, төрийн бус байгууллагууд, төр засгийн газруудын оролцоотой хүний эрхийн олон улсын тогтолцоо, механизм бүрэлдэн тогтож, ихээхэн үр дүнд хүрч буй боловч хүний эрхийн асуудалд холбогдох зарим хэлэлцүүлэг маргаан улам бүр хүчтэй өрнөсөөр байна.

Хүний эрхийн олон улсын мэтгэлцээний нэг үндсэн сэдэв нь “Хүний эрх ерөнхийдөө ямар хүрээнд хүчинтэй вэ?” буюу хүний эрхийн хэм хэмжээнүүд нь улс үндэстэн, шашин шүтлэг, соёл уламжлалын шинжээс хамааран харьцангуй шинжтэй эсэх тухай асуудал юм. Хүний эрхийн түгээмэл Тунхаглал батлагдан гарснаас хойшхи 50 гаруй жилийн хөгжлийн явцад хүний эрхийн олон улсын механизмыг хэрхэн бүрдүүлж хэрэгжүүлэх, ямар агуулга, хүрээнд тодорхойлох нь дэлхийн түвшин дэх олон улсын бодлогын чанартай мэтгэлцээн болон хувирдаг. Энэхүү олон улсын мэтгэлцээний үзэл санааны үндэс нь нэг талаас хүний эрхийн түгээмэл чанарын онол, нөгөө талаас харьцангуй чанарын онол юм.

Хүний эрхийн түгээмэл ба харьцангуй чанар:

Хүний эрхийн түгээмэл үзэл хандлагыг баримтлагчдын хувьд хүний эрх нь “объектив” шинжтэй бөгөөд аливаа шашин шүтлэг, соёл уламжлал, үнэт зүйлсийн тогтолцооноос ангид, бие даан оршдог тул тэдгээрийг дэлхий дахинаа зайлшгүй даган мөрдөх олон улсын хууль эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэгжүүлэх нь хамгийн үр дүн бүхий арга хэрэгсэл хэмээн үздэг. Энэхүү үзэлд тулгуурлан Хүний эрхийн Түгээмэл тунхаглал батлагдсанаас өмнөх хийгээд хойшхи хүний эрхийн сонгодог ойлголт, үзэл санаа нь бүхэлдээ “Европ төвт” болох тухай үзэл баримтлалыг дэвшүүлдэг. Уг үзэл баримтлалын оюун санааны үндэс суурь нь хувь хүний бие даасан байдлыг эрхэмлэдэг индивидуализм бөгөөд энэ нь орчин үеийн өрнийн ертөнцийг үүсгэсэн түүхэн үндэс суурь нь болж өгсөн. Индивидуализм нь 17-18-р зууны туршид хамжлагат ёс, ангийн болон кастын систем зэрэг эртнээс уламжлагдсан нийгмийн шатлан захирах ёсны уламжлалт хэлбэрүүдээс чөлөөлөгдөх хүслийн уриа дуудлага болон нийгмийн амьдралыг хувьсган өөрчлөх оюун санааны түлхэц болж, улмаар хүний эрхийн тухай сонгодог ойлголт бүрэлдэн тогтох үндэс болсон.

Түгээмэл үзлийг баримтлагчид өрнөдийн либераль ардчилсан нийгмийн хэв маягууд нь хүний ахуй, түүний дотроос ардчилал, шударга ёс, тэгш эрх

² Antonia Perez Estevez Intercultural Dialogue and Human Rights: The Law of Peoples. 1998

зэрэг эрх, эрх чөлөөний хувьд одоогийн байдлаар хамгийн их амжилт олоод буй нийгэм эдийн засгийн байгууламж бөгөөд тийм учраас хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, хамгаалах тал дээр бусад улс нийгмийн хувьд загвар болгон авч үзэж болно хэмээн өөрсдийн үндэслэгээг тавьдаг.

Түүний нөгөө тал болох соёл уламжлалын харьцангуй чанарын онол нь ХХ зууны эхэн үеэс хүний эрхэд холбогдох олон улсын эрх зүй, гадаад бодлого, соёлын болон антропологийн судалгааны салбарын мэдлэгийн харилцан интеграцийн үр дүнд өрнөдийн соёл иргэншил нь хөгжлийн хамгийн дээд шат хэмээн үздэг Евроцентрист хандлагыг шүүмжлэх агуулгаар бүрэлдэн бий болсон. Өөрөөр хэлбэл хүний эрхийн харьцангуй чанарын онол нь Европ төвт хандлага нь хүний эрхийн зонхилгч хандлага бус гагцхүү түүний нэг л бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгмийн иргэншил, соёл бүхэн өөрийн гэсэн эрх үүргийн тогтолцоог бүтээсээр ирсэн, тэдгээр нь харилцан тэгш эрхтэйгээр зэрэгцэн оршдог тухай асуудлыг хөндөн тавьдаг байна. Хүний эрхийн харьцангуй байдлыг номлогчдын гол бүрэлдэхүүн болох Азийн болон Ойрхи дорнодын улс орнууд, ерөөс бүхэлдээ гуравдагч ертөнцийн орнууд өөрсдийн соёл зан заншил, шашин шүтлэгийн язгуур чанаруудад нийцсэн хүний эрхийн альтернатив хэв маягийг идэвхтэй эрэлхийлж, номлож ирсэн. Тухайлбал, Хинди иргэншил дэх хүний эрх, Исламын шашин дахь хүний эрх зэрэг ойлголтууд орчин үеийн улс төр, хууль эрх зүй, философийн бүтээлүүдэд ихээхэн тохиолдох болсон³. Тэдний хувьд улс үндэстэн, шашин шүтлэг, бүс нутгийн соёлын ялгарал, олон ургальч байдлыг илэрхийлсэн хүний эрхийн олон улсын хэм хэмжээ бүрдүүлэн, түүний үйлчлэх механизмыг тодорхойлоход чиглэдэг. Дээр дурьдсанчлан хүний эрхийн талаархи олон улсын нэгдсэн ойлголт зөвшилцөл, хэм хэмжээ хараахан бүрэлдээгүй, тийм нөхцөл байдал үүсэхүйц нийгэм улс төр, эдийн засаг, соёлын орчин нэгэнт бий болоогүйн улмаас хүний эрхийн тухайд олон үзэл хандлага, байр сууриуд бий болсон байна.

Европ төвт хандлага - Уг хандлага нь хүний эрх, түүний орчин үеийн гол эх сурвалж болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь бүхэлдээ өрнөдийн соёл иргэншил, улс төр эрх зүйн үзэл санааны агуулга хүрээнд бүрэлдэн тогтож, улмаар нийгмийн түүхэн хөгжлийн явцад дэлхий нийтийн шинжтэй болон хөгжиж байна хэмээн үздэг. Хүний эрхийн түгээмэл чанарын онолыг баримтлагчид нь бүхэлдээ Европ төвт хандлагыг баримталж, хүний эрхийг өрнийн соёл уламжлалын үр дүн гэсэн байдлаар авч үздэг. Хэдийгээр энэхүү хандлага дэлхий нийтэд нилээд зонхилж буй хэдий ч хүний эрхийн талаархи үзэл бодлын зөрүү, байр суурийн ялгаа оршоор байгаа нь үнэн билээ.

Ази төвт хандлага - Энэхүү хандлагыг баримтлагчид индивидуализмын үзэл санаан дээр тулгуурлаж, нийгэм эдийн засгийн урт удаан хөгжлийн үр дүнд аажмаар бүрэлдэн бий болсон Европ төвт хандлага нь уламжлал, соёл үнэлэмжийн ялгаа зааг ихтэй, хамтач үзэл санаа, гэр бүл овгийн харилцаа зонхилсон, хөгжлийн хувьд харилцан адил тэгш бус бусад улс, бүс нутгуудад ялангуяа Азийн улс орнуудад үл тохирох тул хүний эрхийн түгээмэл хэм хэмжээ

³ Sitharamam Kakarala *Universality versus Relativity - A Reappraisal of the Debate*

байх аргагүй хэмээн үздэг. Иймээс өөрсдийн язгуур уламжлал, нийтлэгийн хөгжилд бүрэлдэн тогтсон эрх үүргийн өвөрмөц тогтолцоог бүрдүүлэх замаар хүний эрхийг хамгаалах нь зүйтэй хэмээн үздэг байна.

Дээд үнэлэмжийн хандлага - Энэхүү хандлагаар хүний эрх нь үлэмж төгс, дээд шинж бүхий абсолют үнэлэмж бөгөөд гагцхүү хүний эрхийн дээд соёл, нийгэм эдийн засгийн зүй зохист байгууламж бүхий иргэншил соёлын хөрсөнд хэрэгжих үндэстэй хэмээн үздэг. Судлаач Жак Доннелли⁴ “Хүний эрхийн энэхүү хандлага нь өрнөдийн нийгэм-соёлын орчин ч энэхүү дээд шаардлагыг хүлээж авах боломж нөхцөл хараахан бүрдээгүй хэмээн чанад хатуу шаардлага тавьдаг” хэмээн дүгнэсэн нь ихээхэн үнэний хувь бүхий шинжтэй юм.

Эсэргүүцлийн хандлага - Энэ нь Хүний эрхийн тухай ойлголт үзэл санааг огт хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд шашны, нийгмийн, улс төрийн хувьд ямарваа нэгэн зөвтгөх үндэслэлгүй дэмий хоосон зүйл хэмээн үзэх хэт үгүйсгэгч хандлага юм. Тухайлбал, уг хандлагын томоохон төлөөлөгч болох Ираны Ерөнхийлөгч Аятолла Хомейни “Хүний эрхийн түгээмэл Тунхаглал гэгч нь муу ёрын чөтгөр шулмын шавь нарын бүтээсэн хорлолын тарни бөгөөд бүхий л үнэн шашныг устгахаас өөр зорилго түүнд үгүй” хэмээн мэдэгдэж байжээ.

Хүлээн зөвшөөрөлцлийн хандлага - Хүний эрхийн хэм хэмжээ, үзэл санаанууд нь дэлхийн улс орнууд, тэдгээрийн соёл, зан заншил, уламжлалуудаар хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын шинжтэй болж байна. өөрөөр хэлбэл өнөө цагийн хүний эрхийн тухай ойлголт нь “соёлын харилцан зөвшөөрөлтийн үр дүн мөн” хэмээн үздэгт энэхүү хандлагын үнэт зүйлс оршиж байна. Тиймээс энэхүү хандлага хүний эрхийн олон улсын маргаанд нилээд чухалчлагдах болсон бөгөөд энэ тухайд хойно дахин хөндөн авч үзэх болно. Ялангуяа уг хандлагын үр дүнд 1981 онд тунхаглагдсан “Ислам шашинтны Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал” батлагдаж, дэлхийн тодорхой нэг хэсгийн ард түмэн, үндэстнүүд эерэгээр хүлээн авсан нь үнэхээр хүний эрхийн тухай асуудал хэдий тодорхой ялгаа заагтай боловч харилцан ойлголцолд хүрж байгаагийн нэгэн жишээ хэмээн ойлгож болох юм.

Эдгээр хандлагуудаас орчин үед ихээхэн нөлөө бүхий үндэслэл дэвшүүлж буй Ази төвт хандлагыг онцлон, бага зэрэг дэлгэрүүлэн авч үзье. Хүний эрхийн Ази төвт хандлага нь өнөө хир ойлголтын түвшинд сайтар нэгтгэгдэж цэгцлэгдээгүй бөгөөд төр засгийн газар, улс төрчид, судлаачид, хуульчдын дундахи томоохон маргааны сэдэв болоод байна. Учир нь Ази тив нь дэлхийн зонхилгогч шашнуудын үүсэл хөгжлийн түүхэн нутаг дэвсгэр, түүнийг даган соёл уламжлалын асар их ялгарал тэмцлийн талбар болж байдаг. Мөн улс төр эдийн засгийн тогтолцооны хувьд хагас-феодалын вант улс болох Кувейт, Саудын Араб, цэргийн дэглэмт Камбожи, Бирм, коммунист дэглэмт Хятад, Вьетнам, заримдаг ардчилал бүхий Малайз, Шри Ланка, дэлхийд тэргүүлэх хэмжээнд буй Япон, Сингапураас хэт уналтад ороод буй Бангладеш зэрэг харьцуулах аргагүй олон улс үндэстнийг нэгтгэж, өндөр хөгжилтэй зах зээлжсэн улс орнуудаас холимог, төвлөрсөн төлөвлөгөөт, эцэст нь өрхийн аж

⁴ Jack Donnelly, “Human Rights and Human Dignity: An Analytic Critique of Non-Western Conceptions of Human Rights”, *American Political Science Review* 76 (1982): 303-16

ахуйд суурилсан зэрэг эдийн засгийн олон хэвшлүүд бүхий улсууд зэрэгцэн оршиж байна. Нэгэнт хүний эрх өөрөө нийгэм-эдийн засаг-соёлын орчны рефлексив шинжтэй тусгал учраас Ази тивийн хувьд бүс нутгийн түвшинд төдийгүй улс орон бүрийн хувьд өвөрмөц, харьцангуй байдлууд түгээмэл байдаг.⁵

Хүний эрхэд холбогдох **Азийн төвт** хандлагыг дараахи үндэслэлүүдээр дамжуулан тодорхойлж болох юм. Үүнд:

Нэгдүгээрт: Хүний эрхийн ойлголт үзэл санаа нь нийгэм эдийн засаг, улс төр соёлын өвөрмөц орчин нөхцлөөс үүдэлтэй байдаг. Дэлхий дахинаа, ялангуяа Ази тивийн хувьд газарзүйн өргөн уудам бүс нутгийг хамарсан, хэл соёлын ихээхэн ялгаа бүхий уламжлалтай, нийгэм эдийн засаг, улс төрийн тогтолцооны хувьд ижил бус олон улс үндэстнүүд зэрэгцэн оршдог. Тиймээс хүний эрхийн асуудлыг нэгэн үнэлэмж, хэм хэмжээгээр тодорхойлох боломж байхгүй хэмээн уг хандлагыг баримтлагчид үздэг байна. Ази тивийнхний хувьд судлаачид төдийгүй төр засгийн газруудын зүгээс хүний эрхийн үзэл баримтлал, хэм хэмжээ нь нийгэм соёлын хувьд ихээхэн харьцангуй шинжтэй болохыг нотлох, баримтжуулах талаар бодлогын шинж чанартай тодорхой алхмуудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Тайландын Бангкок хотноо болсон Азийн бүс нутгийн зөвлөлдөх уулзалтаар “Хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд аливаа улс үндэстний түүхэн угсаа гарал, нийгмийн болон соёлын тогтолцоо, эдийн засгийн хөгжлийн ялгаа нь ихээхэн саад бэрхшээлүүд болдог хэмээсэн бол 1993 оны Хүний эрхийн Венийн олон улсын бага хурлын мэдэгдэлд “Засгийн газрууд хүний эрхийн асуудлыг хэлэлцэхдээ түүний үндэсний болон бүс нутгийн соёлын өвөрмөц байдал, нийгэм түүхийн нөхцөл байдлыг нь харгалзан үзвэл зохино”⁶ хэмээн мэдэгджээ.

Хоёрдугаарт: Азийн улс үндэстнүүдийн дундахь нийтлэг нэг шинж бол уг бүс нутагт хувь хүнийг бус харин тэдгээрийн нийтлэгийн эрх ашиг, хэм хэмжээг илүү эрхэмлэн үздэг явдал юм. Тухайлбал судлаач Хиаоронг Лигийн үзсэнээр⁷ “Дорнын болон өрнөдийн соёл, уламжлал дахь хамгийн том ялгаа бол хувь хүн ба нийтлэгийн харилцааны асуудал мөн. Ази тивийнхний хувьд түүхэн уламжлалын дагуу гэр бүл, овог аймаг, улс үндэстний гэсэн тодорхой нийтлэгүүдийн нэгэн гишүүн болох тухай мэдрэмж, сэтгэлгээ зонхилдог бол өрнийн соёлт ард түмнүүдийн хувьд өөрийн “БИ”-г эрхэмлэх чанар давамгайлдаг” байна. Иймээс хүний эрхийн тухайд өрнө дахинд “хувь хүн төвт хандлага” баримталж байгаа бол Ази тивийнхний хувьд “нийтлэг төвт хандлага”-ыг илүү эрхэмлэдэг хэмээн хэлж болно. үүнээс гадна Ази төвт хандлагыг дэмжигчид “хувь хүн төвт хандлага” нь хүний хамтын аж төрөх ёсыг орхигдуулж, нийгмийн дотоод зүй зохицол, тусгаар тогтнолд сөрөг нөлөөтэй байна хэмээн шүүмжилдэг байна.

⁵ Yash Gai Professor. The Asian Perspective on Human Rights University of Hong Kong. 1993.

⁶ Yash Gai Professor. Human Rights and Governance: Asian Debate. 1994

⁷ Xiaorong Li Asian values and Universality of Human Rights

Гуравдугаарт: Ази тивийн улс орнуудын хувьд улс төрийн учир шалтгаанаас илүү нийгэм эдийн засгийн утга холбогдлоор хүний эрхийн асуудалд ханддаг байна. Ийм учраас энэхүү бүс нутагт иргэний болон улс төрийн эрхээс илүүтэй нийгэм эдийн засгийн эрхийн асуудалд голлон анхаарлаа хандуулдаг байна. Тухайлбал, үүнтэй холбогдуулан БНХАУ 1991 оны Хүний эрхийн илтгэлдээ “өлсгөлөн хийгээд хүйтэн сэрүүн байдалд амьдарч буй хятад иргэдийн хувьд гэдэс цатгалан, мөр бүтэн амьдрах нь нэн тэргүүний хэрэгцээ мөн” хэмээн албан ёсоор мэдэгдэж байжээ. Энэ бүс нутагт иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрх хэмээх ойлголтыг тухайн улс орны “хөгжих эрх” хэмээн ойлголттой адил түвшинд хүлээж авдаг байна. Хүний эдийн засаг, нийгмийн эрхүүд нь тухайн улс үндэстнүүдийн хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавхиас шууд хамааралтай байдаг тул иргэд нь өөрсдийн ирээдүйн сайн сайхны төлөө зарим эрхээ эдлэхээс татгалзах буюу нийтлэг эрх ашгийн төлөө хувийн ашиг сонирхлоо хязгаарлах ёс суртахууны үүрэг хариуцлага хүлээж байдаг байна.

Дөрөвдүгээрт: Хүний эрх нь аливаа улсын үндэсний аюулгүй байдал, бүрэн эрхэт байдлын илэрхийлэл мөн гэсэн үзэл санаа нь Ази төвт хандлагыг баримтлагчдын дэвшүүлж буй нэг үндэслэл болно. Тухайлбал, Венийн Хүний эрхийн чуулга уулзалтын өмнө Тайландын Бангкок хотноо болсон Азийн бүс нутгийн зөвлөлдөх уулзалтаар Азийн төр засгийн газрын төлөөлөгчид хүйтэн дайны төгсгөл үеэс эрчимжиж эхэлсэн Өрнө-Дорнын тэмцэл, улс төрийн гадаад бодлогын асуудлуудыг хэлэлцээд хүний эрхийн зарим асуудлууд нь глобал давамгайлал бий болгох гэсэн өрнөдийн бодлого болох тухай, мөн Африк болон Латин Америкийн бүс нутаг нь өрнө дахины зах зээлийг өргөжүүлэх нэгэн төрлийн арга хэрэгсэл болж байгааг тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл өрнөдийн зүгээс хүний эрхийн үзэл санаагаар дамжуулан өөрсдийн үнэт зүйлсээ нэвтрүүлэх замаар улс төр, эдийн засгийн давамгайлал бий болгох бодлого хэрэгждэг хэмээх болгоомжлол, эсэргүүцэл Азийн улс орнуудад байдаг нь ойлгомжтой. Иймд Азийнхны тодорхойлж буйгаар хүний эрхийн асуудал нь тухайн улс орны өөрийн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдэх дотоод асуудал. Иймээс бусад улсын засгийн газар болон олон улсын байгууллагуудын хяналт, нөлөөллийн үйл ажиллагаа нь тухайн улсын дотоод асуудалд оролцох нь эрх зүйн болоод ёс зүйн үндэслэлгүй зүйл хэмээн үздэг байна.

Хүний эрхийн түгээмэл чанарыг шүүмжлэх нь:

Хүний эрх түгээмэл шинжтэй болох тухай үзэл хандлага нь өрнөдийн нийгэм соёлын түүхэн хөрс суурин дээр үүсэн бүрэлдэж, нийгэм, түүнийг бүрдүүлэгч хувь хүмүүс нь гэр бүл, шашин шүтлэг нийгэм дэх байр суурь зэрэг олон талт ялгарал бүхий байдлаар оршин амьдардгийг хүлээн зөвшөөрөхөд үндэслэдэг. Уг баримтлалын үүднээс “уламжлал” хэмээх ойлголтыг эсэргүүцэн харин “орчин үе” хэмээх ойлголтыг илүү чухалчлан үздэг бөгөөд уламжлалт нийгэмд хүний эрхийн тухай ойлголт, үзэл санаа бүрэлдэн бий болоогүй байсан тул түүний нийгэм соёлын өвөрмөц шинжийн тухай нарийвчлан авч үзэх аргагүй

хэмээн нотолдог байна. Харин орчин үеийн нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтүүд нь аж үйлдвэржилт ба либерализм бөгөөд энэ хоёр үйл явц нь хүний эрхийн тухай үзэл санаа, ойлголт сонгодог утгаараа бүрэлдэн тогтох үндэс суурь болсон гэж үздэг бөгөөд энэхүү шалгуурын үүднээс хүний эрхийн тогтолцоо, үзэл баримтлалыг зөвхөн өрнө төвт байдлаар тайлбарлаж, бусад бүс нутгийн үзэл баримтлалуудыг орхигдуулдаг.

Мөн өрнө төвт үзлийн үндэс болсон индивидуализм нь хувь хүмүүсийн хоорондын рациональ чанар хийгээд тэгш байдлыг тунхаглаж угсаа гарлын, шашны, нийгэм соёлын ялгааг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хүний эрхийн асуудалд энэхүү олон урьгальч байдлаар хандаж чаддаггүй, зөвхөн тулган хүлээлт байдлаар авч үздэг байна. Хүний эрхийн түгээмэл чанарын онолыг баримтлагчид дэлхийн нийтийн янз бүрийн хэсгүүд дэх нийгмийн болон соёлын ялгаа, өвөрмөц байдал, тэдгээрийн өөрчлөлт хөгжлийн динамик чанарыг үл ойшоож уламжлалт нийгмийн хөгжлийн үйл явцыг ганц хэв маягт, үл өөрчлөгдөгч, бүдүүлэг шинжтэй хэмээн дүгнэдэг байна. Энэхүү өрнөдийн нийгэм дэх хүний эрхийн оюун санааны үндэс суурь нь шашны болон метафизикийн үндэстэй боловч орчин үежихийн хирээр өөрийн дээрхи шинжүүдийг алдаж байна. Нөгөө талаас, өрнөдийн бус хүний эрхийн уламжлалууд нь бүх улс үндэстэн бүгд хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзэхүйц зөвшилцлийг эрэн хайж байгааг хайхрахгүй байхын аргагүй юм.

Хүний эрхийн харьцангуй чанарыг шүүмжлэх нь:

Хүний эрхийн харьцангуй чанарын хандлага нь мөн дараахи үндэслэлүүдээр шүүмжлэгддэг байна. Юуны өмнө: соёлын хэв маягуудыг өөр хоорондоо нэгдэлгүй, харилцан зөрчилтэй бөгөөд тогтонги шинжтэйгээр туйлшруулан авч үздэг нь тэдний хувьд томоохон асуудал үүсгэдэг байна. Үнэн хэрэгтээ соёлууд нь түүхэн хөгжлийн явцдаа маш өөрчлөмтгий бөгөөд харилцан шилжимтгий болох нь ойлгомжтой бөгөөд өөрсдөө энэхүү шалгуурыг ихээхэн чухалчлан үздэг. Ялангуяа хүний эрхийн сонгодог ойлголтын үе болох ХХ зууны хоёрдугаар хагасаас өнөөг хүртэл маш динамик шинжтэй соёлын харилцан шилжилт явагдаж байгаа нь өнөө цагт өрнөж буй хэл, соёлын глобальчлалын үйл явцуудаар тайлбарлагдах бөгөөд эдгээр орнууд ч энэхүү үйл явцын гадна үлдээгүй нь тодорхой.

Мөн энэхүү хандлагыг баримтлагчид, тэдгээрийн дотроос гуравдагч ертөнцийн элитүүдийн олонхи нь хүний эрх нь угаас тэдний соёлын нэн эртний бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн тухай асуудлыг хөндөн тавьдаг. Үнэхээр нэр томьёоны хувьд ялгаа бүхий боловч бүхий л нийгмийн тогтолцоонд эрх-үүргийн харилцаа, тэдгээрийн тухай үзэл санаа ямар нэгэн байдлаар хөндөгдөж байсан нь гарцаагүй. Гэхдээ үнэхээр эртний болон дундад үеийн нийгэм улс төрийн байгууламжуудад тэгш эрх, хүний эрхийн зарчмуудад тулгуурласан нийгмийн харилцаа үйлчилж байсан гэж батлахад хэцүү билээ. Тухайлбал Ойрхи Дорнодын Исламын шашинт ард түмнүүдийн төлөөлөгчид өөрсдийн шашны гол судар Кораны тухайд “Ислам шашин 14 зууны тэртээ хүн төрөлхтөнд хүний эрхийн хамгийн төгс хуулийг бүтээн өгсөн” хэмээх туйлширсан үндэслэлийг

дэвшүүлдэг хэдий ч тэдгээр улс орнуудыг өнөө цагийн хүний эрхийн хэм хэмжээний үүднээс авч үзвэл хүний эрх, тэгш байдал ихээхэн зөрчилд орж буй халуун цэгүүд болдог.

Дээрхи маргааныг шийдвэрлэхийн тулд зарим судлаачид индивидуализм болон коллективизмын эерэг, нийцэт чанарууд дээр үндэслэсэн “соёлын универсализм” хэмээх хандлагыг дэвшүүлдэг. Судлаач Рентелн “хүний эрхийг даян дэлхий дээрхи бүхий л үзэл санааг нэгтгэсэн ерөнхий үнэлэмжийн цогц байдлаар авч үзэж байх санал дэвшүүлсэн. Энэхүү ойлголтын үзэл санааны үндэс нь дээр дурьдсан “харилцан зөвшөөрөлцлийн хандлага” бөгөөд хүн төрөлхтөн энх амгалан хамтын нийгэмлэг байгуулахын тулд зохих шийдэл, эрэл хайгуулыг хийсээр байна.

Энэ тухайд холбогдох орчин үеийн улс төрийн философийн нэгэн томоохон эх сурвалж бол Жон Раулсын “Ард түмний хууль” хэмээх зохиол билээ. Энэхүү бүтээлдээ Ж.Раулс өөрийн “Зүй ёсны онол” хэмээх бүтээлийн залгамж болгон хүний эрхийн улс төрийн, хууль эрхийн, ёс суртахууны үндэслэлүүд, тэдгээрийн хүчинтэй байх нөхцөл шаардлагуудыг дэвшүүлэн тавьсан байна.

Түүний үзсэнээр зүй ёсны нийтлэг зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд “үндэстнүүдийн нийгэмлэг” (Society of Nations) бүх улс үндэстэн, нийгэм соёлын байгууламжийг хамарсан зөвшилцөл хийх ёстой бөгөөд энэхүү зөвшилцөл нь хүний эрхийн минимум шаардлагыг тодорхойлоход чиглэдэг. Хүний эрхийн минимум шаардлага хэмээх ойлголт нь *амьдрах эрх, аюулгүй байх, хувийн өмчтэй байх, шударга хуулинд захирагдах, үзэл санааны чөлөөт байдал болон эвлэлдэн нэгдэх эрх, мөн цагаачлах эрх*⁸ зэрэг нийтлэг эрхийн хэм хэмжээгээр тодорхойлогддог байна. Энэхүү зөвшилцлөөс өмнө тэрээр “Сайтар зохион байгуулагдсан нийгэм” (Well-ordered hierarchical society) хэмээх ойлголт бий болгосон бөгөөд энэхүү нийгэм нь дараахи шалгууруудыг хангаж байх ёстой. Үүнд: 1) Энхийг эрхэмлэгч байх, энэхүү зорилгод хүрэхийн тулд дипломат болон худалдааны, гэрээний зэрэг хүчирхийллийн бус арга хэрэгсэл ашигладаг байх, 2) Сайн зохион байгуулалт бүхий хуулийн тогтолцоотой байх, уг тогтолцоо нь зүй ёсны нийтлэг зарчмуудыг эрхэмлэн баримталдаг байх, 3) Сэтгэн бодох эрх чөлөө нь нийгмийн бүх гишүүдэд тэгш байх, түүнийг тодорхойлох хэмжүүрийг хүлээн зөвшөөрөх, эцэст нь 4) Цагаачлах эрх чөлөө нээлттэй байх⁹ зэрэг болно.

Эдгээр шаардлагуудыг хангасан улс үндэстнүүд нь “үндэстнүүдийн холбоо”-нд хамаарагдах бөгөөд өөрсдийн төрөлх байр суурийн (original position) үүднээс бусад улс орнуудтай хүний эрхийн хэм хэмжээний талаар хэлэлцэн зөвшилцөх эрхтэй болно. Энэхүү зөвшилцлийн үйл ажиллагаа нь хоёр үе шаттай хэрэгждэг ба оролцогчид нь нийт “ард түмнүүдийн хууль” болон хүлээн зөвшөөрөгдөхүйц зүй ёсны нийтлэг зарчмуудыг хэлэлцэх бөгөөд хүний эрхийг хүндэтгэх нь түүний нэгэн чухал зарчим болно. Зөвшилцлийн нэгдүгээр үе шатанд либераль-ардчилсан уламжлал бүхий улс орнууд “үндэстнүүдийн

⁸ John Rawls The Laws of Peoples Critical Inquiry 1993.

⁹ John Rawls The Laws of Peoples Critical Inquiry 1993.

хууль” болон хүлээн зөвшөөрөгдөхүйц ардчиллын болон зүй ёсны зарчмуудыг хэлэлцэн харилцан ойлголцолд хүрнэ. Ийнхүү эдгээр улсууд минимал зөвшилцөлд хүрсний эцэст либераль-ардчилсан бус улс үндэстнүүд зөвшилцлийн ширээнд суух бөгөөд тэд уг асуудлыг өөрийн уг байдалд нийцүүлэн шийдэх боломжоор хангагдсан байна. үүнийг нарийвчлан авч үзвэл хүний эрхийн минимум стандартыг тодорхойлох энэхүү зөвшилцөл нь ижил тэгш статус бүхий оролцогчдын хоорондын жинхэнэ үнэн “Диалоги” байх ёстой ажээ. Диалоги нь харилцан яриа, зөвшилцөл болох хувьдаа ярих, сонсох гэсэн хоёр талтай. Тухайн тохиолдолд ярьж буй нь “Би” бол сонсож буй нь “чи” болох бөгөөд харин нэг нь нөгөөгийнхөө хувьд “Бусад” болдог ажээ. Энэхүү диалогид оролцогчид нь янз бүрийн соёл иргэншил, уламжлал, нийгэм эдийн засгийн байгууламж бүхий улс орнууд байх учир тэр бүхэнд өөрсдийн гэсэн эрх, эрх чөлөөний үнэн, үнэлэмж, байр суурь байдаг. Ингээд, хүний эрхийн дэлхий дахины нийтлэг жишиг стандартад хүрэхийн тулд оролцогчид нь өөрөө ярих, эрхийн тухай саналаа дэвшүүлэх, мөн бусдыг сонсох гэсэн ижил тэгш эрх үүрэгтэй байх ёстой. Иймээс энэхүү зөвшилцөл нь жинхэнэ бөгөөд түгээмэл, хүний эрхэд холбогдох “үнэн”-ийг тодорхойлоход чиглэдэг. Гэвч энэхүү диалогийн явц нь Ж.Раулсын томъёолсноор хэрэгжихгүй байна хэмээн түүнийг шүүмжлэгчид үзсэн байна. Учир нь “Ж.Раулс анхнаасаа либераль-ардчилсан уламжлал бүхий өрнөдийн орнуудыг зөвшилцлийн нэгдүгээр эгнээнд тавьж үзсэн. Ер нь бодит байдал дээр либераль-ардчилсан орнууд зөвхөн ярих, санал дэвшүүлэх мөн өөрийн эрхийн үнэлэмжээ бусдаар хүлээн зөвшөөрүүлэх эрхээ эдэлж, бусдыг сонсох, тэдгээрийг хүлээн зөвшөөрөх үүргээ умартаж байна. Нөгөө талаас өрнөдийн бус улс орнууд сонсох, бусдыг хүлээн зөвшөөрөх эрхээ эдэлж, эсрэгээр өөрийн өмнөөс ярих, санал дэвшүүлэх эрхээ эдэлж чадахгүй байна” гэсэн шүүмжлэл өрнөдөг байна. Ерөнхийдөө орчин үеийн нөхцөл байдалд олон улсын байгуулагууд, төр засгийн газрууд, ард иргэдийн харилцан ойлголцлын үрээр хүний эрх нь бүх улс үндэстэн, нийгэм соёлын орчин нөхцөлд хүлээн зөвшөөрөгдөхүйц, хэрэгжихүйц суурь бөгөөд саармаг шинж бүхий үзэл санаа болоод байна. Мэдээж хэрэг зарим нэгэн эрх, түүнийг ойлгох ойлголт нь өрнөдийн болоод дорнын, бусад бүс нутгийн нийгэм соёлын уламжлалуудыг агуулсан байж болох боловч энэ бүгд нь өөрөө хүний эрхийн хэм хэмжээний нэг л бүрэлдэхүүн хэсэг болох нь ойлгомжтой. Үүний хамт хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, стандартад өрнөдийн бус нийгэм, соёлоос улбаатай хүний эрхийн шинэлэг агуулга, хэм хэмжээ нэвтрэн орж ирэхэд ямарваа нэгэн хязгаарлалт үгүй нээлттэй байдаг.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд хүний эрхийн олон улсын тогтолцоо үүсэн бүрэлдсэн үеэс эхлэн хүний эрхийн түгээмэл болон харьцангуй чанарын тухай маргаан нь нийгэм, улстөрийн сэтгэлгээн дэх цогц бөгөөд суурь шинжтэй мэтгэлцээний сэдэв болсоор байна. Харин Ж.Раулсын үзсэнчлэн дэлхийн улс түмнүүд хүний эрхийн нэгдмэл ойлголт, хэм хэмжээ бүрдүүлэх энэхүү диалогид өөрийн байр суурийг илэрхийлэн оролцож, тэдгээрийн үзэл санаа, соёл, үнэлэмжийн харилцан ойлголцож чадваас, түүний үр дүнд дэлхий нийтээр даган мөрдөж, хүлээн зөвшөөрөгдөхүйц хүний эрхийн соёл, хэм хэмжээ бүрэлдэн тогтох боломжтой болно. Өөрөөр хэлбэл хүний эрхийн Европ болон

Ази төвт хандлагууд бус харин “соёлын харилцан зөвшөөрөлцлийн хандлага” илүү чухалчлагдаж буй байр суурь нэгэнт эхэлжээ хэмээн ойлгож болох юм. Ийм байдлаар хүний эрхийн дэлхий дахины стандарт, хэм хэмжээний агуулга, цар хүрээ улам бүр баяжин боловсрогдож, олон соёлт ертөнцөд нийтлэг түгэн дэлгэрэх нь хүний эрхийг хамгаалах хэрэгжүүлэх зорилгод хүрэх нэгэн том алхам болох нь дамжиггүй.

ЗОХИГЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Ц. Одончимэг
ХЗҮТ-ийн ажилтан

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгддэг. Энэ ажиллагааны явцад хүний тэр дундаа маргагч тал буюу зохигчийн эрх зөрчигдөж болзошгүй тул ИХШХША¹ бүр хуулийн заалтад нийцсэн байх ёстой.

Монгол Улсад 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй ИХШХША²-аар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар иргэдэд өргөн эрх /шүүхэд мэдүүлэх эрх/ олгожээ.

Анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны явцад ИХШХША-аар олгосон эрх болох шүүхэд мэдүүлэх /шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах/ болон мэтгэлцэх эрхийг хэрхэн хангаж байгаа нь ХЗҮТ-өөс хийсэн “ИХШХШХуулийн хэгэгжилт, үр нөлөө” судалгааны нэг хэсэг байлаа. Энэхүү судалгааг асуулгын болон ярилцлагын аргаас гадна хавтаст хэргийг уншиж судлах аргаар явуулсан болно.

Одоо та бүхэнд энэ судалгааны гол үр дүнг танилцуулья.

I. Зохигчдын эрх хангах ажиллагааны төлөвшил

Санал асуулгад хамрагдагчдын:

- 56.4% нь шүүх ИХШХША-ны явцад зохигчдын эдлэх эрхийн тухай хуулийн заалтыг дурдаж тайлбарласан;
- 17.7% нь дэлгэрүүлэн тайлбарлаж өгсөн;
- 8.06% нь тайлбарласан эсэхийг ялгаж мэдээгүй;
- 6.4% нь огт тайлбарлаж өгөөгүй гэж хариулсан байх агаад 11.2% нь асуулгад хариулаагүй байна³.

Ийнхүү санал асуулгад хамрагдагчид анхан шатны шүүхэд иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдын эрхийг шүүгчээс тайлбарлаж өгч, уг эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжоор хангаж өгдөг гэж дүгнэхэд хангалттай биш байгаа гэж үзсэн ба хавтаст хэргийн судалгаанаас дараахь тоо гарсан болно:

- Нийслэлийн төвийн 6 дүүрэгт судлагдсан 833 хэргийн 684 буюу 82.1%-д;

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

³ Хавсралт-

- Нийслэлээс алслагдсан 2 дүүрэгт судлагдсан 256 хэргийн 242 буюу 94.5%-д;
- Орон нутагт судлагдсан 814 хэргийн 482 буюу 59.2%-д нь зохигчдын эрхийг тайлбарлан танилцуулсан байдал /баримт/ байхгүй байсан юм⁴.

Санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 70.8% нь шүүхийн зүгээс эрхийг маань хангалтгүй тайлбарлаж өгсөн гэж үзсэн байхад судлагдсан хавтаст хэргийн 73.9%-д нь зохигчдын эрхийг тайлбарласан тухай баримт хийгдсэн байх боловч гарын үсэг зуруулснаар гүйцэтгэсэнд тооцдог, ялангуяа хөдөө орон нутагт энэ тухай баримт хэрэгт байдаггүй, зөвхөн хариуцагчид эрхийг нь тайлбарласан /хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулах ажиллагаатай давхцуулан/ баримт үйлдэж уг ажиллагааг хязгаарладаг дутагдал ажиглагдсан юм. Харин нийслэлийн дүүргийн шүүхүүдэд хэргийн бүх зохигчдод эрхийг тайлбарладаг байдал хэвшиж байгаа нь талархууштай байлаа.

Шүүгчдээс зохигчдын эрх, үүргийг тайлбарлан ойлгуулах нь тэдний эрхийг хангах болоод шүүн таслах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нэг чухал арга зам юм. Гэтэл цөөн шүүгч зохигчдын нэхэмжлэлээсээ татгалзах, эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх гэх мэтийн учир холбогдол, үр дагавар, хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт ямар эрх эдэлж, үүрэг биелүүлэх талаар маш ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгч байсныг талархан тэмдэглүүштэй боловч нэлээд шүүгч тэр эрх үүргийг мэдэгдэх төдий ёс болгодог нь шүүх хуралдаанаас ажиглан судлах явцад харагдав.

II. Зохигчдын эрхийн хэрэгжилтийн байдал

Санал асуулгад хамрагдсан зохигчдын:

- 19.3% нь эрхээ маш сайн ойлгосон;
- 40.3% нь сайн;
- 40.3% нь зохих түвшинд ойлгоогүй гэж хариулсан юм⁵.

Зохигчдын эрхийн хэрэгжилт нь:

А. Зохигчдын боловсрол, мэдлэг, идэвх, санаачилга;

Б. Шүүхийн зүгээс зохигчдын эрхийг тайлбарлаж өгөх, эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх ажиллагаа;

В. Хуулийн зохицуулалтаас хамааралтай тул судалгаа хийхдээ эдгээрийг илүүтэй анхаарсан болно.

2.1. Шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилт

Шүүхэд мэдүүлэх эрхэд нэхэмжлэх, хүсэлт, гомдол гаргах эрх хамаарна⁶.

⁴ Хавсралт - /Хавтаст хэргийн аргаар судалсан судалгааны дүн/

⁵ Хавсралт

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйл.

• **Нэхэмжлэл гаргах эрхийн хэрэгжилт**

А. Санал асуулгад хамрагдсан зохигчид өөрсдөөс шалтгаалах дараахь бэрхшээлийн улмаас шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь хязгаарлагддаг гэж үзжээ⁷. Үүнд:

1. Хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас /9.6%/.
2. Улсын тэмдэгтийн хураамж төлөхөд хүндрэлтэй учраас /8.06%/.
3. Хариуцагч олддоггүй /6.4%/ учир нэхэмжлэл гаргаж чаддаггүй гэх шалтгааныг дурджээ.

Асуулгад оролцогчид дээрх шалтгааныг дурдсан боловч энэ нь үндсэндээ зохигчдын хууль, эрх зүйн мэдлэг мөхөс, ИХШХША-нд ямар эрхтэй оролцохоо ойлгоогүйтэй холбоотой байв. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэл гаргахад бэрхшээл болж буй асуудлыг хүсэлт гаргах замаар шийдвэрлүүлэх хуулиар олгосон боломжийг төдийлөн мэддэггүйгээс дээрх бэрхшээлтэй тулгардаг бололтой.

Б. Шүүх, шүүгчээс шалтгаалан зохигчдын дээрх эрх хэрэгжихгүй, бүрэн бус хэрэгжиж буй байдлыг авч үзвэл:

- Санал асуулгад оролцсон зохигчид шүүхэд нэхэмжлэл гаргахад шүүхийн ажиллагааны улмаас дараахь бэрхшээл учирдаг хэмээжээ. Үүнд:

1. Шүүх байхгүй нотлох баримт шаардан нэхэмжлэлийг хүлээж авдаггүй /9.6%/.
2. Өдөр, хугацаа зааж нэхэмжлэлийг хүлээн авдаггүй /12.9%/.
3. Шүүхийн нарийн бичгийн дарга нар хүнд сурталтай /17.7%/.
4. Шүүх нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэдэггүй /8.06%/.
5. Шүүгч нар хүнд сурталтай /3.2%⁸ гэх шалтгааныг багтаажээ.

Дээрх бэрхшээлүүд нь тухайн шүүх, шүүгчийн ажлаа зохион байгуулах чадвар, шүүн таслах ажиллагааны туршлага, практик, шүүхийн ажилтнуудын бусадтай харилцах харилцаанаас хамааралтай тул шүүхийн болон хэргийн менежментийг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

- Шүүгчийн хууль хэрэглэх ур чадвар нь зохигчдын нэхэмжлэл гаргах эрхэд нөлөөлж байна. Нэг жишээ дурдахад нэг шүүхэд гэрлэлт цуцлах тухай хэргийн зохигчид эвлэрсэн тохиолдолд:

- а/ ИХШХШХ-ийн 132.3-т зааснаар гэрлэгчдийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгодог;
- б/ ИХШХШХ-ийн 74.1-2-т зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг 2 өөр практик байна.

Энэ тохиолдолд хэдийгээр аль аль нь зохигчдын эвлэрлийг батлан шийдвэрлэж байгаа боловч ИХШХШХ-ийн 74 дүгээр зүйлийн заалтаар шийдвэрлэсэн тохиолдолд зохигчид шүүхэд дахин нэхэмжлэх эрхээ алдах буюу үр дагавар нь өөр гэдгийг шүүгчид анхаарч, хуулийн заалтыг зөв ойлгож шийдвэрлэх шаардлагатай.

⁷ Хавсралт-

⁸ Хавсралт-

В. Судалгааны явцад хуулийн зохицуулалтаас шалтгаалан нэхэмжлэгчийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хязгаарлагдаж буй байдал ажиглагдсан юм. Тухайлбал,

1. ИХШХШХ-ийн 16.1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэлийг тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргахад шүүх зөвхөн үл хөдлөх хөрөнгийн битүүмжлэлийг нээлгэх тухай нэхэмжлэлийг хүлээж авна гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээж авахгүй нэхэмжлэгчийн нэхэмжлэх эрхийг хязгаарладаг практик байна.
2. ИХШХШХ-ийн 62.1 дүгээр зүйл. Шүүх хуульд заасан эдгээр нотлох баримтаас гадна хуульд заагаагүй нотлох баримт болох “оролцуулах гэрчээр шүүхэд гэрчлэх гэж буй асуудлын талаар тодорхойлолт гаргуулж, нэхэмжлэлд хавсаргаж ирүүл” гэсэн шаардлага тавьж нэхэмжлэгчийн нэхэмжлэх эрхийг хязгаарладаг практик шүүхэд байна. Энэ байдал нэхэмжлэлийг хүлээн авах болон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах ажиллагааны үед гардаг ажээ.
3. ИХШХШХ-ийн 74.4 дүгээр зүйл. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд тухайн асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байхаар хуульчилснаар шүүхэд нэхэмжлэл гаргасан зохигчдын хувьд нэхэмжлэл гаргах эрхийг хугацаагаар хязгаарласан явдал болжээ. Жишээлбэл, нэхэмжлэгч шүүхэд хэд хэдэн шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан боловч шаардлагынхаа зарим хэсгийг ямар нэг хугацааны дараа гаргая гэхэд нэхэмжлэлээсээ татгалзахаас өөр ямар ч гарц хуульд байхгүй байгаа юм. Үүнтэй холбоотойгоор энэ тохиолдолд нэхэмжлэгч шүүхэд ирэхгүйгээр нэхэмжлэлийг буцаалгах арга хэмжээ авч өөрсөддөө боломж, гарцыг бий болгож байна.

• **Хүсэлт, гомдол гаргах эрхийн хэрэгжилт**

А. Санал асуулгад оролцсон иргэдийн:

1. 35.4% нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүсэлт гаргах эрхээ мэддэг;
2. 40.3% нь заримыг нь мэддэг;
3. 24.1% нь огт мэдэхгүй буюу энэ талаар сонсож байгаагүй гэж хариулжээ⁹.

Ярилцлагын судалгаанд хамрагдсан шүүгчид зохигчид эрхээ мэддэггүйгээс хүсэлт, гомдол гаргадаггүй, нэгэнт хүсэлт гаргахгүй бол шүүх өөрийн санаачилгаар ажиллагаа хийх боломжгүй байдаг бөгөөд энэ нь шүүн таслах ажиллагаанд багагүй бэрхшээл учруулдаг тухай ярьж байсан юм.

Б. Хэргийг уншиж байх явцад зохигчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэж буй байдал харилцан адилгүй байгаа байдал харагдсан бөгөөд хэргээс зохигчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн байдал харагддаггүй, нэхэмжлэл гаргахдаа гаргасан хүсэлтийг хэргийг шийдвэрлэх шатанд хангадаг, хүсэлтийг хангаагүй

⁹ Хавсралт-

тохиолдолд ямар нэг шийдвэр гаргадаггүй, хүсэлт гаргагчид энэ талаар хариу өгсөн эсэх нь тодорхойгүй байдал багагүй гарч байлаа.

Энэ нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагааны зохион байгуулалт, чанар, санаачилгатай холбоотой байв.

В. ИХШХШХ-д хүсэлтийг ямар хугацаанд шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүйгээс шалтгаалан нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргахдаа гаргасан хүсэлтийг шийдвэрлэдэггүй, шийдвэрлэхийг шаардахад нь дахин хүсэлт гаргахыг шаардах гэх мэтээр зохигчдын хүсэлт гаргах эрхийг хязгаарладаг дутагдал шүүгчдийн дунд оршиж байна. Ийм дутагдал байгаа боловч шүүн таслах ажиллагааны чанар, зохигчдын эрхийг хангах асуудалд анхааралтай ханддаг зарим шүүгчид зохигчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэхэд илүүтэй анхаарч ажиллагдийг тэмдэглэн хэлэх хэрэгтэй.

2.2. Мэтгэлцэх эрхийн хэрэгжилт

А. Зохигчид мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэхийн тулд ИХШХША-ны явцад нотлох баримтыг өөрөө гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ хэрхэн мэддэгийг судалж үзэхэд 61.2% нь мэддэг, 38.7% нь мэддэггүй ажээ¹⁰. Энэ нь мөн л иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг мөхөс байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, зохигчид хуулийн мэтгэлцээний талаархи заалтуудыг ойлгож мэдэхгүй байгаа, мэтгэлцэх үр чадваргүй байгаа, харилцан адилгүй чадал бүхий талууд мэтгэлцээнд орж байгаа тухайлбал, нэг тал нь өмгөөлөгчтэй байхад нөгөө нь өмгөөлөгчгүй гэх мэт байдлууд зохигчдын мэтгэлцэх эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Б. Зохигчид, өмгөөлөгчидтэй ярилцахад шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ төвийг сахисан байр сууриа баримталж чаддаггүй, санаачилгыг өөртөө авч явуулдаг, талуудын мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй, тоомсоргүй ханддаг, мэтгэлцээний үр дүнг шийдвэр гаргахдаа харгалзахгүй, хэргийн талаархи өөрийн байр суурьтаа үндэслэн шийдвэр гаргагдгаас мэтгэлцэх эрх зөрчигддөг хэмээж байлаа.

Шүүх хуралдаанаас ажиглан судлах явцад шүүгч хавтаст хэргийн талаархи төсөөлөл болон мэтгэлцээний үр дүнг харьцуулан шийдвэр гаргах ёстой атлаа зарим тохиолдолд шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй өөр бусад юм унших, зарим оролцогчийн ярьж буй зүйлийг таслан зогсоох, аль нэг талд ашигтай асуулт асуух зэрэг байдал ариалагүй байгаа нь харагдсан юм.

Шүүхийн мэтгэлцээний зарчим, журмыг хангаж буйг үнэлэх үзүүлэлтийн нэг хэсэг нь шүүх хуралдааны танхимыг аль болох мэтгэлцэхэд боломжтой, зохистой хэлбэрээр зохион байгуулах явдал юм. Мэтгэлцээний талууд тэгш байр сууринаас мэтгэлцэхийн тулд тэдний шүүх хуралдааны танхим дахь байрлал тохиромжтой байх шаардлагатай атал судалгаанд хамрагдсан

¹⁰ Хавсралт-

шүүхүүдийн олонхи нь энэ шаардлагыг хангаагүй байна. Талуудыг зэрэгцээ бөгөөд шүүхийн өмнөөс харсан байдлаар байрлуулсан нь талууд өөр хоорондоо биш, шүүхтэй мэтгэлцэх гэж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлж байсан бөгөөд энэ нь мэтгэлцээн жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг хязгаарлагдаж болох талтай.

В. Хуулийн зохицуулалтаас шалтгаалан зохигчдын мэтгэлцэх эрх дараахь байдлаар зөрчигддөг ажээ. Үүнд:

1 дүгээрт. ИХШХШХ-ийн 108.2 дугаар зүйлийн заалттай холбоотой. Хуулийн энэ заалтаар тогтоосон дараалал нь байцаан шүүдэг тогтолцооны нэг хэлбэр бөгөөд шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд хөндлөнгийн байр суурьтайгаар оролцох, мэтгэлцүүлэн шүүх зарчим буюу талуудын мэтгэлцэх эрхийг зөрчиж байгаа юм.

2 дугаарт. ИХШХШХ-ийн 112-114 дүгээр зүйлийн заалттай холбоотой. Хуулиар шүүх хуралдааны үед талуудад байр сууриа дүгнэн илэрхийлэх боломж олгоогүй ба практикт хуулийн энэхүү зохицуулалтыг тухайн шүүгч санаачилгаараа дараахь байдлаар хэрэглэж байна. Үүнд:

- а/ Талуудад дүгнэлт, санал хэлэх боломж олгохгүй байх;
- б/ Талуудад “нэмж тодруулах” гэсэн хэсэг дээр дүгнэлт, саналаа хэлэх боломж олгох;
- в/ Зарим шүүгч иргэдийн төлөөлөгчийн саналыг сонссоны дараа дүгнэлт санал хэлэх боломжоор хангах гэх мэт.

III. Дүгнэлт

ИХШХША-ны явцад зохигчдын эрхийг ханган хамгаалахын тулд дараахь чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

◆ *Иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд:*

1. Иргэдэд ИХШХША-нд оролцох эрхийн талаар цуврал сургалт зохион байгуулах;
2. Сургалтын гарын авлагыг ойлгомжтой, хялбар, энгийн байдлаар боловсруулж хэвлүүлэх;
3. Мөн дээрх байдлаар эвхмэл хуудас, плакат хэвлэн нийтийн хүртээл болгох;
4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ИХШХША-нд зохигчдын эдлэх эрхийг таниулсан нэвтрүүлэг, сурталчилгаа явуулах.

◆ *Анхан шатны шүүхээс зохигчдын эрхийг хангах ажиллагааг сайжруулах хүрээнд:*

1. Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед зохигчдын эрхийг хангах талаархи хуулийн заалтыг нэг мөр хэрэглэх талаар дээд шатны шүүх, шүүгчээс зөвлөмж өгч, мэргэжлийн удирдлагаар хангахад анхаарч, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;

2. Зохигчдын эрхийг хангах асуудлаар шүүгчдэд зориулсан сургалт зохион байгуулж, зохигчдын боловсрол, мэргэжил, нас, сэтгэхүйн онцлогт тохируулан эрхийг нь энгийн бөгөөд хялбар, ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгч байх аргачлал, арга зүй олгох;
 3. Шүүхэд нэхэмжлэл хүлээн авах хуульд заагаагүй хуваарийг хэрэглэхгүй байх;
 4. Шүүхэд нэхэмжлэл хүлээн авах, нотлох баримтад тавигдах шаардлага, бусадтай харилцах харилцааны асуудлаар шүүхийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалт зохион байгуулах;
 5. Шүүх хуралдааны танхимыг зохигчид мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой хэлбэрээр зохион байгуулж, улсын хэмжээнд жигдрүүлэх.
- ◆ *Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:*
1. ИХШХШХ-ийн 16.1 дүгээр зүйлийн зорилго нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой маргааныг тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхээр шийдвэрлүүлэх явдал болох нь хуулийн үзэл санаанаас харагдаж байна. Энэ нь хэргийн шийдвэрлэлтэд тустай байх нь ойлгомжтой. Тэгэхээр ИХШХШХ-ийн 16.1-ийн “эд хөрөнгийн ..” гэсний өмнөх “буюу” гэдгийг “болон”, эсхүл “,” болгож өөрчлөх;
 2. Дээрх заалтын үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэргийн шүүхийн онцгой харьяалалд үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бүх шаардах эрхийг хамааруулан ойлгох талаар УДШ-ээс албан ёсоор тайлбарлах;
 3. Зохигчдын хүсэлт гаргах хэлбэр, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, журмыг хуулиар тогтоох;
 4. ИХШХШХ-д нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзахаас гадна нэхэмжлэлээ, эсхүл шаардлагаа татан авах боломжтой байхаар зохицуулалт нэмж оруулах;
 5. ИХШХШХ-ийн 108.2 дугаар зүйлийн заалтыг
 - Асуулт тавих дарааллыг эхлээд нэхэмжлэгч талын гэрчээс, дараа нь хариуцагч талын гэрчээс мэдүүлэг авахаар;
 - Гэрчийг оролцуулсан талаас гэрчийн мэдүүлгийг бүрэн сонссоны дараа эсрэг тал нь асуулт тавьдаг байхаар;
 Нотлох баримт гаргасан тал буюу талууд эхэлж асуулт тавих боломжтой байхаар өөрчлөх;
 6. ИХШХШХ-д заасан шүүх хуралдаан явуулах ерөнхий журамд иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргахын өмнө талууд өөрсдийн байр сууриа дүгнэн илэрхийлэх боломж олгосон /ЭБШХ-д заасан шүүмжлэлийн шаттай адил/ заалт нэмж оруулах нь зүйтэй.

МАРГААНЫГ ШҮҮХЭЭС ГАДУУР ШИЙДВЭРЛЭХ АРГА: ЗУУЧЛАЛ

*У.Мөнхбат, Ч.Нарантуяа, Ц.Одончимэг,
ХЗҮТ-ийн ажилтан*

Үүсэл хөгжил

Зуучлал нь маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх нэгэн арга бөгөөд анх¹ АНУ-д хөдөлмөр эрхлэлтийн салбарт албан ёсоор бүтэц, зохион байгуулалтын хувьд төлөвшсөн ба одоогоор тус улсад маргааныг шийдвэрлэх гол арга болоод байна. АНУ-ын Хөдөлмөрийн яамнаас 1913 онд хөдөлмөрийн маргааныг зохицуулж шийдвэрлэх бүрэлдэхүүнийг бий болгожээ. Дэлхийн II дайны дараа зуучлал хүчтэй хөгжиж эхэлсэн бөгөөд 1947 онд дээрх бүрэлдэхүүн нь Холбооны зуучлах болон зөвшилцөх үйлчилгээ үзүүлэх алба нэртэйгээр зуучлалаар дамжуулан үйлдвэрлэлийн салбаруудад тогтвортой байдлыг хангах үүргийг хүлээсэн байна.

1964 онд Иргэний эрхийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд тус хуульд заасан ёсоор АНУ-ын Хууль зүйн яамны дэргэд хэлэлцээ, зуучлалын журмаар алагчилахтай холбоотой маргааныг шийдвэрлэх Нийгмийн харилцааны үйлчилгээ үзүүлэх алба (Community Relations Services)-г байгуулжээ. Үүсгэн байгуулагдсанаасаа хойш тус алба нь маш олон зөрчилдөөнтэй асуудалд амжилттайгаар оролцсоноос дурдвал, ялган тусгаарлах тушаалууд болон Ку Клукс Клантай холбоотой нийгэмд үүссэн үймээнийг намжаахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Түүнчлэн 1960-аад оноос эхлэн холбооны улсын болон муж улсын төсвөөс санхүүжүүлэн сайн дурын зуучлагчийн оролцоотойгоор “жигжиг” маргааныг шийдвэрлэх хөршийн шударга ёсны төв (neighborhood justice centers)-үүдийг байгуулжээ. Эдгээр төв нь ихэвчлэн байр өмчлөгч болон түрээслэгч, хөршүүд, гэр бүлийн гишүүд, ажлын байрны болон хайр сэтгэлийн байдлаас үүсэлтэй болон бусад олон төрлийн маргааныг шийдвэрлэхэд оролцдог бөгөөд шүүх болон холбогдох байгууллагаас хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар жишиг болох хэргийн талаар мэдээлэл авдаг байна.

АНУ-д шүүхийн ачаалал ихээхэн нэмэгдсэн, түүнчлэн 1970-аад оны эцэс 1980-аад оны эхээр иргэдээс шүүхэд нэхэмжлэл гаргах явдал огцом ихэссэн тул шинэ арга замыг эрэлхийлэх үүднээс зарим тохиолдолд иргэний хэргийг

¹ Маргааныг мэтгэлцэх журмаар шийдвэрлэхийн сацуу энхийн замаар буюу сайн дурын үндсэн дээр хэлэлцээ хийж, зөвшилцөлд хүрэх явдал эртнээс улбаатай гэж хэлж болох юм. Шашны шинжтэй эртний ном сударт үүний жишээ олон гардаг. Тухайлбал, Исус Христийг “Бурхан болон хүмүүн хооронд зуучлагч” гэсэн байхад лалын шашинтнуудын уламжлалд Мухамед “Та нарт би машаг, энэрэл болон залбирлаас агуу нэгэн хэмжээс буйг хэлэх үү? Энэ бол хүмүүс хоорондын зөвшилцөл юм” хэмээн өгүүлсэн тухай байдаг.

зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлүүлэхээр шилжүүлэх болж, шүүхийн бүтцийн дотор зуучлалын албыг бий болгох явдал түгээмэл болов. 1988 он гэхэд Флорида мужийн иргэний хэргийн шүүхүүд бараг нэхэмжлэл бүрийг юуны түрүүнд зуучлагчид шилжүүлэх болсон ба үүнийг даган бусад муж улс болон холбооны улсын зарим шүүхүүд энэхүү туршлагыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар зуучлал нь маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхийн өмнөх шат болоод байна.

АНУ-д маргалдаж буй талуудын хооронд хэрхэн үр ашигтай зуучлах талаар сургалтууд байнга явагддаг бөгөөд эдгээрийг зөвхөн их, дээд сургуулиудад бус харин бүр бага наснаас нь буюу бага, дунд сургуульд сурагчдын сэтгэл зүйд тохируулан зөрчилдөөнийг хэрхэн арилгах тухай тусгай хичээлийн хэлбэрээр заадаг болжээ². Ийн сургалт явуулах нь хүүхдүүд ухамсарт амьдрал хөл тавимагцаа үүсч болзошгүй маргаанд хандах хандлагад ихээхэн нөлөөлдөг байна.

Зуучлалыг АНУ-аас гадна Австри, Их Британи, Финлянд, Итали, Шинэ Зеланд зэрэг улсад өргөнөөр хэрэглэж эхэлсэн бөгөөд Европын Холбоо ч ач холбогдлыг нь ойлгож, ЕХ-ны Зөвлөлийн Иргэний болон худалдааны эрх зүйн маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх тухай ногоон номд зуучлалыг- “шударга ёсонд хүрэх замыг сайжруулахад чиглэсэн бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм” хэмээн тодорхойлжээ. Үүнийг даган ЕХ-ны гишүүн улсууд дотоодын хууль тогтоомждоо зуучлалын тухай тухайлсан акт, заалтуудыг оруулж эхэлсэн бөгөөд тухайлбал, шинээр гишүүнээр элссэн БНУУ хууль тогтоомжоо харилцан уялдуулах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Зуучлалын тухай 2002 оны LV хуулийг³ батлан гаргасан байна.⁴ Энэхүү хуульд заасны дагуу тус улсын Хууль зүйн яам зуучлагч болон зуучлагчийг ажиллуулж буй хуулийн этгээд (компани, зуучлалын төв, сан зэрэг)-ийн бүртгэлийг хөтлөх бөгөөд үйлчлүүлэхийг хүссэн этгээдүүд интернетээр дамжуулан тус бүртгэлд орж, тохиромжтой зуучлагчийг нутаг дэвсгэр болон мэргэшсэн байдлаар нь сонгох боломжтой юм.⁵

Монгол Улсад маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх нэгэн аргыг хуульчилсан нь арбитрын ажиллагаа юм. Арбитрын тухай 2003 оны хууль батлагдсанаар Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын үндэсний арбитрын үйлчилгээний цар хүрээ өргөжиж, зөвхөн дотоодын ба олон улсын арбитр төдийгүй зуучлах, эвлэрүүлэх үйлчилгээ үзүүлдэг болсон байна. МҮА мөн Арбитрын дүрэм, тарифдаа өөрчлөлт оруулж, Зуучлалын тухай шинэ дүрэм, Түр арбитрын үйл ажиллагаанд тусалцаа үзүүлэх тухай дүрмийг баталжээ.⁶

² Хүчирхийлээс урьдчилан сэргийлэх ажлын нэгэн хэсэг болгон 1983 оноос эхлэн Маргааныг шийдвэрлэх үндэсний хүрээлэн (NIDR or National Institute for Dispute Resolution) Зөрчилдөөнийг шийдвэрлэх боловсролын сүлжээг байгуулж, тус ажлын хүрээнд төрөл бүрийн байгууллагуудад зориулсан хөтөлбөрийг боловсруулж, дэмжиж эхэлсэн байна.

³ Тус хууль нь 2003 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

⁴ Somfai, B. A mediáció, mint alternatív konfliktuskezeles, Del-Dunantuli Gazdasag, 2001 December

⁵ <http://im.netforum.hu/knyr/internet/menu.html>

⁶ 2004 оны 9 дүгээр сард МҮА, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн ШЭМШХ-өөс хамтран зохион байгуулсан “Арбитр ба маргаан шийдвэрлэх бусад арга” сургалтын материалууд

Зуучлалын тухай ойлголт

Зуучлал бол маргааныг сайн дурын үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд талуудын хүлээн зөвшөөрсөн хөндлөнгийн гуравдагч этгээд маргалдагч талуудад харилцан шийдвэрлэх асуудлыг тодорхойлох, эдгээр асуудлыг шийдвэрлэх аргуудыг боловсруулах болон тал бүр хүлээн зөвшөөрөхүйц шийдвэрт хүрэхэд туслах хувийн ажиллагаа юм. Маргааныг мэтгэлцээний журмаар шийдвэрлэх англи-америкийн зарчмын эсрэгээр хөндлөнгийн этгээд нь шийдвэр гаргах эрхгүй бөгөөд аливаа талын буруутай, эсхүл гэм буруугүйн талаар дүгнэлт гаргадаггүй.⁷

Маргааныг шүүх, арбитраар шийдвэрлүүлэхээс ялгагдах гол онцлог нь зуучлалын үр дүнд заавал шийдвэр гарахгүй бөгөөд шийдвэрт хүрсэн тохиолдолд тус шийдвэр нь талууд хүлээн авахуйц байх бөгөөд заавал биелүүлэх шинжийг агуулдаггүй явдал юм.

Зуучлалын давуу тал нь гэвэл,

- зуучилж буй гуравдагч этгээдийн оролцоо бага байх бөгөөд талууд амьдралд нь нөлөөлөх чухал асуудлаар гаргах шийдвэрийг хянах боломжтой байдаг;
- үр дүн нь талуудын хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн байдаг;
- талууд шийдвэр гаргаж, зуучлагч удаан үргэлжлэх, тохиромжтой зөвшилцөлд хүрэх явдлыг хангах үүрэгтэй тул шүүхийн шийдвэртэй харьцуулахад талууд гарсан үр дүнд илүү сэтгэл ханамжтай байдаг учраас түүнийг биелүүлэх нь ч сайн байдаг;
- зуучлалын ажиллагаа нь талуудын дэвшүүлсэн бүх асуудлыг хэлэлцэх бөгөөд үйлдлийн зөвхөн хууль зүйн үндэслэлээр хязгаарлагдахгүй;
- ирээдүйд гарч болзошгүй маргааныг шийдвэрлэх чадварыг сайжруулж, маргахын оронд хамтран ажиллах нь чухал болохыг ойлгуулдаг;
- зуучлалын ажиллагаа нууц байх бөгөөд талууд өөрсдийн нууцыг хадгалан үлдэх боломжтой;
- зуучлал нь шүүхээр маргааныг шийдвэрлүүлснээс илүү хурдан бөгөөд “өртөг багатай” байдаг.

Харин сул тал нь гэвэл,

- зуучлалын ажиллагаа нь жишиг тогтоодоггүй, иймд нэгэн төрлийн хэргийг байн байн хэлэлцэх тохиолдол гардаг⁸;
- зуучлалын ажиллагаа нь нийгэмд зан байдлын хэм хэмжээг тогтоодоггүй, өөрчилдөггүй, хэрэгжүүлдэггүй;
- зуучлалын ажиллагааны явцад илүү чадвартай, эсхүл хүчтэй тал давуу байдалд хүрэх магадлалтай;

⁷ Carrie Menkel-Meadow, *Mediation: Theory, Policy and Practice* xiii-xviii, xxix (2000)

⁸ Прецедент тогтоохгүй байх нь сул тал болох эсэх асуудал маргаантай юм. Зуучлалын ажиллагаанд талууд хооронд ирээдүйд үүсэх зөвшилцөлд анхаарлаа хандуулах бөгөөд тал бүрийн хэрэгцээ, сонирхол өөр өөр тул прецедент тогтоох нь ач холбогдолгүй байж болно.

- зуучлал нь сайн дурын байх тул нөгөө талыг ажиллагаанд татан оролцуулахад хүндрэл үүсч болзошгүй, учир нь зуучлалыг санал болгох нь сул байдлаа хүлээн зөвшөөрсөнтэй адил мэт санагдаж болох;
- зуучлалын ажиллагаа нь маргаан дуусгавар болохын баталгаа болохгүй. Шийдэлд хүрэхгүйгээр зуучлал дуусч болох юм.⁹

Зуучлалыг арбитрын ажиллагаатай хавсарган хэрэглэж болох ба үүнийг зууч-арб¹⁰ хэмээн нэрлэх бөгөөд энэхүү ажиллагаанд оролцогч талууд зуучлалын үр дүнд зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд маргааныг арбитраар шийдвэрлүүлэх бөгөөд маргаанд зуучлагчаар оролцсон хөндлөнгийн этгээд арбитраар байх бөгөөд түүнийг цаашид арбитраар ажиллахыг талууд хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд талууд арбитраар шийдвэр гаргахдаа зуучлалын үр дүнд олж авсан таатай бус мэдээллийг ашиглахаас татгалзаж чадахгүй хэмээн үзэх нь нийтлэг байдаг.¹¹

Ямар тохиолдолд зуучлагчийн оролцоотойгоор маргааныг шийдвэрлэх нь тохиромжтой вэ?

Зуучлал нь хэдий гуравдагч этгээдийн оролцоотойгоор маргааныг шийдвэрлэх ч зуучлагч нь шийдвэрээ “тулгах” эрх мэдэл үгүй тул талууд өөртөө илүү итгэлтэйгээр тус ажиллагаанд оролцож, “ялах - алдах” шийдвэрийн төлөө бус харин харилцан бие биенээ ойлгож, “ялах - ялах” шийдэлд хүрэхийг эрмэлздэг. Иймээс ч талууд хоорондын харилцаа цаашид үргэлжлэх тохиолдолд маргаанд юуны түрүүнд зуучлагчийг оролцуулах нь тохиромжтой байдаг. Учир нь удаан хугацааны турш үргэлжилсэн, эсхүл цаашид үргэлжлэх магадлалтай харилцаа холбооны хувьд, зөрчилдөж буй талууд наанадаж эхний үед харилцан ашигтай шийдлийг эрэлхийлж, тогтнож буй холбоогоо хадгалан үлдэхийг хичээдэг. Энэхүү хандлагын өөр нэгэн давуу тал нь оршин буй харилцаа холбоонд зөрчилдөөн үүсэх тохиолдолд талууд түүнд хэрхэн хандах, түүнийг шийдвэрлэх талаар хэр хэмжээний хүчин чармайлт гаргах байдал болон цаашдын төлөвийг нь харуулна.

Дээр дурдсанаас гадна маргаан бүхий асуудлыг хууль зүйн хэлбэрт оруулах нь хүндрэлтэй, эсхүл тохиромжгүй бол зуучлалын ажиллагааг сонгох нь зөв байж болох. Учир нь аль нэг тал ялж, нөгөө тал нь алдах шийдвэр гарахгүй бөгөөд нэгэнт байдал иймийн тул талууд хэлэлцээ хийх, зуучлагч оролцуулан маргааныг шийдвэрлэх нь илүү оновчтой байна. Тухайлбал, зуучлалын үр дүнд хоёр талд тэнцүү хэмжээнд үүрэг хүлээлгэх нь шүүхээр маргааныг хэлэлцсэний эцэст аль нэгэн талд илүү хариуцлага оногдуулснаас үр ашигтай байж болох юм.

⁹ Lela P. Love and Joseph B. Stulberg, Understanding Dispute Resolution Processes, in Michigan Mediator Skill-Building Manual, Michigan Supreme Court (revised 1997)

¹⁰ Med-Arb нь Mediation-Arbitration буюу зуучлал-арбитрын ажиллагааны товчилсон хэлбэр юм.

¹¹ Center for public resources, the ABC's of ADR: a dispute resolution glossary, 13 (11) Alternatives (to the High Cost of Litigation) 1 (1995)

Харилцан ашигтайгаар буюу тал бүр хожих магадлалтай маргааныг, өмнө нь маргааныг үр дүнтэйгээр хэлэлцэн шийдвэрлэж байсан, эсхүл харилцан ойлголцол өндөр түвшинд байгаа тохиолдолд шүүхэд хандахаас илүүтэйгээр зуучлал үр ашигтай байдаг. Туршлагаас харахад, олон асуудал бүхий маргааныг шийдвэрлэхэд санал болгох шийдэл нь мөн олон тул зуучлагчийг оролцуулах нь тохиромжтой юм.

Хэлэлцээ

Аливаа тал болон түүний төлөөлөгч зуучлалын ажиллагаанд хэлэлцээ хийж, үр дүнд хүрэх зорилгоор оролцох бөгөөд талууд хооронд зуучилж буй этгээд хэлэлцээ хийх явцыг удирдана. Иймээс зуучлалыг үр ашигтай явуулахад хамгийн шаардлагатай зүйл бол хэлэлцээ юм.

Хэлэлцээний хуваах буюу байр суурьны (өрсөлдөх) хэлбэрийг мөн “ялах-алдах” хэмээн нэрлэх бөгөөд энэ нь талууд бие биеийнхээ байр суурьд харилцан буулт хийх боловч байр суурь нь тулах цэгт хүрмэгц өрсөлдөж, мэтгэлцэж эхэлнэ. Ингэхдээ хэлэлцээ хийгчид туйлширсан байдлаар байр сууриа илэрхийлж, өөртөө аль болох ихийг олж авахын тулд заналхийлэл, аливаа бусад арга залиг хэрэглэн, зарим тохиолдолд өрсөлдөгчөө төөрөлдүүлэхийн тулд мэдээллийг нуун дарагдуулдаг байна. Талууд ийн туйлширч, өөрсдийн хүсч буй зүйлийг олж авахын тулд хэт муйхарлаваас хэн хэнд нь ашигтай шийдэлд хүрч чадахгүйд хүрнэ. Иймээс ч “барэг” шууд эсрэг ашиг сонирхлын тухай ярьж болох юм. Бенжамин Франклиний дүгнэж хэлснээр, “Холбогдох талуудад ашигтай бус тохиолдолд наймаа хэзээ ч үүсэхгүй байх байсан. Байр суурь нь зөвшөөрөх хэмжээнд аль болох давуу байдалд хүрэхийн тулд хэлэлцээ хийх нь илүү ашигтай байх нь мэдээж. Шуналаас болж хэлэлцээ үр дүнгүй болж, хоёр талд ашигтай байж болохуйц наймаа хийгдэхгүй байх нь хэлэлцээний хамгийн сөрөг үр дагавар нь болох юм.”¹² Хэлэлцээний энэхүү хэлбэр нь талууд тулах цэгт хүрмэгц нөгөө талдаа хэрхэн буулт хийж буй байдлаас шалтгаалан буулт хийх, хамтран ажиллах болон өрсөлдөх гэсэн гурван төрөл байна.

Хэлэлцээний хоёр дахь хэлбэр болох ашиг сонирхолд суурилсан буюу асуудлыг шийдвэрлэх хэлэлцээ нь байр суурьны хэлэлцээнээс ялгарах гол онцлог нь маргааны зүйлийг “хуваах”-аас гадна тэрхүү зүйлийг илүү өргөжүүлэх боломж, үйл ажиллагаанд төвлөрдөг явдал юм. Энэхүү үзэл нь мөн чанартаа талуудын хэрэгцээ шаардлагын хүрээ ихээхэн өргөн бөгөөд хэрэгцээ бүр хоорондоо зөрчилдөхгүй, харилцан үгүйсгэхгүй тул зөвшилцөлд хүрэх боломжит тохиолдол нь ч их байдаг гэсэн үндсэн зарчимд суурилдаг.¹³

¹² Howard Raiffa, *The Art and Science of Negotiation*, 33-34 (1982)

¹³ Хэлэлцээний энэхүү хоёр хэлбэрийн ялгааг гаргаж буй дараахи маш хялбархан жишээг Carrie Menkel-Meadow өөрийн “Хууль зүйн хэлэлцээний өөр нэгэн үзлийн тухай: асуудлыг шийдвэрлэх бүтэц” (“Toward another view of legal negotiation: the structure of problem solving”) өгүүлэлдээ дурдсан байдаг. Хоёр хүүхэд бялууг хэрхэн хувааж идэх талаар маргахад хэлэлцээний хуваах зарчмын дагуу асуудлыг шийдвэрлэвээс бялууг хоёр хуваана, магад тэнцүү хэсэгт. Харин нэг хүүхэд кремд нь, нөгөө нь жигнэмэгт нь дуртай бол өөрийн дуртай хэсгийг авсанаар хүүхэд тус бүр 100 хувь сэтгэл ханамжтай үлдэх болно.

Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад аливаа хэрэг маргааныг “талуудын эвлэрэл”-ийн үндсэн дээр шийдвэрлэх эрх зүйн үндэс бий. Тухайлбал,

***Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль*¹⁴**

Энэхүү хуульд зохигчдын маргаж буй асуудлын талаар эвлэрэх эрхийг хуульчилсан ба зохигчид ийнхүү эвлэрсэн тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр заажээ. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх гэдэг нь талуудын эвлэрлийг баталсан тухай захирамж гаргах явдал юм. Хуульд зааснаар зохигчид дараахь байдлаар эвлэрч болно. Үүнд:

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах;
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх;
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх;
- Маргаж буй шаардлагын тодорхой хэсгийн талаар зөвшилцөлд хүрэх.

Зохигчид дээрх байдлаар эвлэрсэн тохиолдолд бичгээр тохиролцож, гарын үсэг зурж баталгаажуулах¹⁵ болон шүүхийн өмнө эвлэрлийн гэрээ байгуулах¹⁶ ба шүүх бичгээр баталгаажуулсан баримт болон эвлэрлийн гэрээг үндэслэн хэргийг захирамжаар шийдвэрлэнэ.

Зохигчид эвлэрсэн бол уг хэргийг шүүх дахин авч хэлэлцэхгүй. Өөрөөр хэлбэл, зохигчид шүүхийн өмнө эвлэрсэн бол шүүхэд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл, гомдол гаргах эрхгүй болно.

***Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*¹⁷**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд эвлэрэх эрхтэй.

Хуульд зааснаар захиргааны хэрэг үүсгэсэн шүүгч талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авна¹⁸. Захиргааны хэргийн нэхэмжлэгч хариуцагч нар нь:

- Харилцан буулт хийх;
- Нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох хэлбэрээр хоорондоо тохиролцоно.

Ийнхүү тохиролцсон бол эвлэрлийн гэрээ байгуулах болон тохиролцоогоо бичгээр илэрхийлж гарын үсэг зурах хэлбэрээр баталгаажуулна. Хэрэв шүүх хуралдааны үед эвлэрвэл шүүх хуралдааны тэмдэглэлд энэ тухай тусгана.

¹⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсад 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны №7-д хэвлэгдсэн.

¹⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.

¹⁶ Дээрх хуулийн 74 дүгээр зүйлийн 74.6.

¹⁷ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны №3-т хэвлэгдсэн.

¹⁸ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5.

Талууд эвлэрсэн бол уг маргааныг захиргааны хэргийн шүүх дахин авч хэлэлцэхгүй.

Хөдөлмөрийн тухай хууль¹⁹

Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагч урьж оролцуулах, хөдөлмөрийн арбитраар хэлэлцэх хэлбэрээр эвлэрүүлэн зохицуулна²⁰. Талууд эвлэрүүлэх арга хэмжээнд оролцохоос татгалзах эрхгүй бөгөөд зуучлагч, хөдөлмөрийн арбитрч нь хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахын тулд хууль тогтоомжоор олгосон бүх боломжийг ашиглах үүрэгтэй. Зуучлагч оролцуулахдаа талууд зуучлагчийг тохиролцон сонгох бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй бол тухайн сум, дүүргийн Засаг даргад хандаж хүсэлт тавин зуучлагчийг томилуулна. Засаг даргын томилсон зуучлагчаас талууд татгалзах эрхгүй. Зуучлагч нь хөдөлмөрийн хамтын маргаанд холбогдох баримт бичиг, мэдээллийг талуудаас шаардан авах эрхтэй.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн нь тус байгууллагад гаргасан гомдлыг шийдвэрлэхдээ талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй хэмээн дээрх хуульд заажээ²¹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгоно.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөж болно. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүдэд маргалдагч талуудыг шүүхийн бус журмаар эвлэрүүлэн шийдвэрлэх, түүнийг гүйцэтгэх буюу биелүүлэх журмын талаар заасан байдаг байна. Тухайлбал, 1969 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улс Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын хооронд байгуулагдсан Иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай гэрээний 56 дугаар зүйлд “хэлэлцэн тохирогч хоёр этгээд энэхүү гэрээнд зааснаар нөгөө этгээдийн нутаг дэвсгэрт гаргасан дор дурдсан баримт бичгийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах”-аар заасан байна. Үүнд:

- иргэний болон гэр бүлийн хэргийн талаархи эд хөрөнгийн холбогдолтой эвлэрүүлэх хэлцэлүүд;
- хэрэв нэг тал нь аж ахуйн газар бол аж ахуй, худалдааны маргааны талаар гаргасан хөндлөнгийн шүүхийн шийдвэр, мөн эвлэрүүлэх хэлцэл²².

¹⁹ Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны №2-т хэвлэгдсэн.

²⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн 116 дугаар зүйл.

²¹ Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэг.

²² Энд шүүхийн шийдвэрийг дурдаагүй, зөвхөн шүүхийн бус журмаар шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үндэслэлийг дурдав.

Ийнхүү Монгол Улсын хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээнд талууд эвлэрэн хэлэлцэх замаар хэрэг маргаанаа шийдвэрлэх эрх зүйн үндсийг хуульчилсан байх боловч эдгээрийн ихэнхэд нь маргагч талууд шүүхийн ажиллагааны явцад эвлэрэн хэлэлцэж, шүүх уг эвлэрлийг баталж захирамж гарган хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр зохицуулжээ.

Шүүхэд шийдвэрлэгдэж буй нийт иргэний хэргийн 60 орчим хувь нь хялбаршуулсан журмаар буюу талуудын эвлэрлийн үндсэн дээр шийдвэрлэгджээ²³. Энэ журмаар хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практикийг судалж дараахь дүгнэлтийг хийсэн юм. Үүнд:

Нэгдүгээрт. Маргалдагч талууд шүүхийн ажиллагааны явцад шүүхийн оролцоогүйгээр эвлэрэн хэлэлцдэг. Өөрөөр хэлбэл, тэд өөрийн хүсэл, зоригийн үндсэн дээр эвлэрдэг тул талуудын эвлэрэлд шүүхийн үүрэг төдийлөн байхгүй. Гэтэл талууд эвлэрэн, түүний үндсэн дээр шүүх хялбаршуулсан журмаар /захирамжаар/ шийдвэрлэж байгаа хэргийг шүүгчийн шийдвэрлэсэн хэрэгт оруулан дүгнэдэг нь тохиромжгүй юм. Процессийн хувьд авч үзэхэд шүүх уг хэргийг шийдвэрлээгүй, харин талууд өөрсдөө маргаанаа эвлэрэх замаар шийдвэрлэснийг шүүх баталж буй ажиллагаа мөн.

Хоёрдугаарт. Монгол Улсын хэмжээнд 2004 оны байдлаар анхан шатны шүүхийн нэг шүүгчид оногдох ажлын ачааллыг судалж үзэхэд дунджаар:

- эрүүгийн 33 хэрэг;
- иргэний 150 хэрэг;
- захиргааны 9 хэрэг, 57 зөрчил;
- ял солих, ялаас хугацааны өмнө тэнсэн сүллах тухай 9 материал, нийт 258 хэрэг материал шийдвэрлэсэн тоо гарч байгаа юм²⁴.

Зохигчдын эвлэрлийг баталж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг шүүгчдийн ажлын ачааллыг нэлээд нэмэгдүүлдэг болохыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн хувь хэмжээ, нэг шүүгчид оногдох хэргийн тооны харьцаа харуулж байна.

Гуравдугаарт. Ийнхүү шүүх талууд хоорондын эвлэрэл, тохиролцооны асуудлыг шийдвэрлэж байгаа нь шүүхийн зардлыг ч мөн тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг нь тодорхой.

Гадаадын зарим орнуудын жишиг хандлага болон өөрийн орны өнөөгийн эрх зүйн зохицуулалтад үндэслэн шүүхээс гадуур буюу шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэдэг арга замыг нэвтрүүлснээр шүүгчдийн ажлын ачаалал багасаж, шүүхийн зардал, төсөв хэмнэгдэхээс гадна шүүхийн ажлын зохион байгуулалт ч сайжрах үндэстэй юм. Мөн иргэд ч бага өртгөөр, богино хугацаанд, өөрийн ашиг сонирхолдоо нийцсэн /зөвшилцөлд хүрсэн, ялах - ялах/ шийдвэр гаргуулах бүрэн боломжтой болно.

²³ Хууль зүйн үндэсний төв, Шүүх эрх зүйн шинэчлэл төслийн хамтран явуулсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө” судалгааны дүн. 2005 он.

²⁴ Монгол Улсын дээд шүүхийн 2004 оны жилийн тайлан. 15 дахь тал.

Иймээс Монгол Улсад маргааныг шүүхээс өмнөх шатанд шийдвэрлэх арга, журмыг нэвтрүүлж, энэ талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй.

Харин манай орны эрх зүйн хөрсөнд маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх эрх бүхий бүрэлдэхүүн нь шүүхийн бүтцэд багтсан аппарат байх, аль эсхүл бие даасан чөлөөт /маргалдагч талууд өөрсдөө сонгон шийдвэрлүүлдэг/ байгууллага байхын аль нь тохиромжтой болохыг та бүхэн мэргэн оюундаа тунгааж үзнэ буй заа.

ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ ЭРХ, ТҮҮНИЙГ ХАНГАХ БАТАЛГАА*

Л.Энхбаяр
Тагнуулын дээд сургуулийн
II дамжааны сонсогч

И.Кант “ Иргэний Нийгэм нь угтаа агуу их Эрх чөлөө юм.
Эрх Зүйн үндэс нь Хүний Эрх, Эрх Чөлөө мөн.”

Тийм ээ. Хүний Эрх, Эрх Чөлөө гэдэг бол тэрхүү Эрх, Эрх чөлөөг эдлэгч Субъект, өөрөөр хэлбэл хүний салгаж үл болох эрхэмсэг дархлаа бөгөөд түүнийг хэзээ ч, хэдийд ч, хаана ч, ямар ч үед хөндөж үл тоомсорлож болохгүй ажгуу. Ер нь ямарваа нэгэн Төрийн гол үүрэг бол иргэнийхээ өмнө түүний Эрх, Эрх Чөлөө, Хууль Ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд Нийгмийн дэг журмыг хангах, тэр зөрчигдсөн эрхийг нь сэргээн тогтоох үүргийг тус тус хүлээж иргэнийхээ зан үйлийн боломжит хэмжээ хязгаарыг баталгаажуулан зохицуулж өгсөн байдаг билээ.

Тэгвэл энэ Эрх, Эрх чөлөөг маань чухам яагаад дээдэлж зохицуулж байгаа мөн үүнээс ургаад энэхүү зан үйлийн боломжийг яагаад Төр хариуцан хангаж баталгаажуулж байна вэ гэдгийг ойлгох хэрэгтэй.

Үүнийг ойлгохын тулд эхлээд Эрх гэсэн ойлголтыг тайлбарлах нь чухал.

Эрх гэдэг бол аливаа зүйлийг хийх тодорхой нөхцөл дэх боломж, зан үйлийн горим журам. Харин Хүний Эрх гэдэг бол хүнд тусгайлан олгогдсон түүний хийж болох боломж болж байна. Гэхдээ энэ удаад би хүний эрхэм үнэт зүйл болсон эрхийн маань гол суурь, үндэс болсон Хүний Халдашгүй Эрхийн талаар ярих хэрэгтэй. Угтаа үүнийг ойлгож ухаарснаар хүнээс хүнтэй, нийгэмтэй харьцах харилцааны эрх тэгш байдлыг, эрх үүргийн нөхцлийг, эрх харилцааны үндсийг олж тодорхойлоход ач холбогдолтой юм. Харин үүнээс сэргүүлэн тавьж судлах юм бол хүний халдашгүй эрхийг ноцтой зөрчсөн хэлбэр олон гарч байгаа ба хуульд тусгагдаж хамгаалагдсан хүний эрх, түүний баталгаа хоёр нь бас л учир дутагдалтай, тэрхүү эрхээ баталгаажуулах нөхцөл дутмаг, нөхцөл бүрдсэн ч үйлдэл нь эрхээ зөрчсөн, эрхээ хамгаалж, хангасан үр дагаварыг аль нь ч гаргахгүй байгаа нь харамсалтай.

Дэлхий дээрх гол зүйл бол Хүн, Хүн өөрөө сэтгэдэг амьтан, сэтгэдэг амьтан л бол халдашгүй дархан эрхтэй байх ёстой. Мөн байгаль, нийгмийн уг үндсэн

* ХЭҮК-оос олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан их дээд сургуулиудын оюутны дунд зарласан “Хүний халдашгүй эрх, түүнийг хангах баталгаа” сэдэвт эссэний уралдаанд I байр эзэлсэн эссэ

баялаг эрдэнэ бол Хүн. Хүн бүр эрх зүйн этгээд байдаг ба төрсөн цагаасаа аваад нас барах хүртлээ эрх эдлэж, үүрэг хүлээх ёстой бөгөөд эрх нь дотроо халдашгүй гэсэн эрхэм тодотголыг агуулж байдаг. ХЭТТ-н 3-р зүйлд ч мөн “Хүн бүр эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэсэн байдаг. Энэхүү эрх нь Хүний угаас заяасан *Хувийн Эрх* юм. Тодруулбал Хүний өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй мөн Позитив эрх биш харин төрөөс зөвшөөрөн олгосон ямар ч тохиолдолд хэн ч дур мэдэн хөндөж, хязгаарлаж болохгүй тийм эрхүүдийн нийлбэр цогц, эдгээрийн бүрдэл буй за. Энэхүү эрхийг хүнд өөрт нь байгаа оюуны болон биеийн хүчний бүхий л боломж өөрөөр хэлбэл хүний туйлын эрхүүдийн нийлбэр цогц гэж бас хэлж болно. Хувийн эрх гэдэг бол иргэний халдашгүй эрх юм. Энэ нь иргэний бусадтай харилцах харилцаа, нууцтай холбоотой эрхүүдийг агуулна.

Одоо тэгвэл *Хүний Халдашгүй Эрх* гэдэг маань өөрөө Туйлын Эрх - Жам ёсны Эрх - Хувийн Эрх - Иргэний халдашгүй Эрхүүдийг багтаасан цогцолбор ойлголт болж байгаа учир гагцхүү ганц, хоёрхон эрхийн талаарх ойлголт биш агаад юмсын дотоод холбоо, зүй тогтолтой адилхан хүний эрхүүд маань ч нэг нэгэнтэйгээ салшгүй холбогдон уялдана. Үүнээс үзэхэд халдашгүй эрх бол хүний эрхийн гол зангилаа асуудал ба бусад эрхүүдийн оргил нь юм. Халдашгүй эрх бол өөрөө тодорхой онцлог бүхий хэд хэдэн эрхээс бүрдэнэ.

- **Чөлөөтэй байх:** Бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол болон нийгмийн дэг журмыг зөрчихгүй, ямар ч дарамт шахалт, хязгаарлалтгүйгээр өөрийн хүсэл сонирхол дагуу аливаа үйлдлийг хийх боломж.
- **Бие эрхтний халдашгүй дархан байх:** Ямар ч тохиолдолд хэн ч дур мэдэн хүнийг үйлдэл, эс үйлдэхүй хийлгэх, түүний нууцыг олж мэдэх, нэр төрийг нь гутаан доромжлох, бие махбодид нь халдаж болохгүй боломж.
- **Орон байрны:** Тухайн хүний буюу гэр бүлийн гишүүдийн хууль ёсоор амьдарч буй гэр, байшин, өргөө, тасалгаанд зөвшөөрөлгүй хэн ч орох, нэвтрэх, түүнийг устгах, сүйтгэх, хууль бусаар ашиглах, өмчлөхийг хориглосон бусдын орон байрны халдашгүй дархан байдал юм.
- **Нууцын:** Тухайн хүний гуравдагч этгээд мэдэх ёсгүй гэж үзсэн хувийн ба гэр бүл, эд хөрөнгө аливаа мэдээллийг агуулсан, баримт бичиг тэмдэглэл, ашиг сонирхол, нэр хүнд эрхийг бусдад задруулж болохгүй туйлын эрх.
- **Нэр төрийн:** Ямар ч нөхцөлд, ямар нэгэн ялгаваргүйгээр өөртэй нь бие хүний хувьд нэр төрийг нь хүндлэн харьцаж, хандах ба хэн ч нэр төрийг нь доромжлох, гутаах эрхгүйгээр тогтоосон боломж
- **Өмчийн:** Аливаа хүний шударгаар өмчилж буй эд хөрөнгөд хэн ч дураараа хандаж өмчлөлөөс нь салгаж болохгүй

Энэ бүгдээс үзэхэд Хүний Халдашгүй Эрх бол ямар ч үед хөндөж, хязгаарлаж болохгүй эрх гэдэг нь харагдаж байгаа бөгөөд мөн эдгээр нь хоорондоо мөнхүү бусад эрхүүдтэй холбогдож тэдгээр эрхүүдийн гол үндэс, суурь, тулгуур багана болж байна .

Хүн эхээс төрдөг нь үнэн

Эхээс төрөөд амьдрах нь үнэн

Амьдарч яваад нас гүйцдэг нь үнэн ажгуу.

Тэгвэл энэ хугацаанд хүн өөрийгөө Халдашгүй Эрхээр битүү хүрээлэн өсч, хөгжих тусам энэ эрх маань нэмэгдэж зарим нь бүр зузааран бэхжигдэж хүрээлэгдэж байдаг.

Хүний Эрхийг хэрэгжүүлэх, түүнийг хүнтэй нь холбож өгөх, түүний гол мөн чанар болгох зүйл нь хүний эрхийг хангах Баталгаа байдаг. Хүний халдашгүй эрхийн элемент бүрийг бүрэн хамгаалж, хангаж чадсан тохиолдолд хүний эрхийн эрх чөлөө бүрдэх бөгөөд улмаар нийгмийн дэг журам цаашилбал тухайн улс орны хөгжил, дэвшил дээшилж бадрах болно. Хүний халдашгүй эрхийг хангах **Эдийн засаг /чөлөөт өрсөлдөөн, эдийн засгийн хөгжил, ДНБ, инфляци зэргийн нөлөөлөл эдгээрийн эерэг байдал/, Улс төр /төрийн тогтвортой байдал, сонгох, сонгогдох эрх, зэргийг цухас дурдаж болно/, Нийгэм, Хууль зүй /гол нь хүний эрхнийг хуульчлан баталгаажуулсан, бэхжүүлсэн хамгийн гол хүчин чадал бүхий хүний эрхийг өндөрт тавин тодорхойлж хангаж өгсөн/ үндсэн баталгаа нөгөөтөйгөөр бусад баталгаа байх болно. Бусад баталгаандаа би угтаа халдашгүй эрхийн бүрэлдэхүүн тус бүрийн баталгааг авч үзэж байна. Үүнд:**

- Чөлөөтэй байх, Нууц, Нэр төр, Бие эрхтний, Орон байрны, Өмчийн халдашгүй дархан байдлыг хангах баталгаа
- Хэвлэл, Мэдээллийн үйл ажиллагаагаар хүний эрхийг хангах баталгаа
- Эрх зүйн орчинг бүрдүүлэх баталгаа /хүний эрхийг эрх зүйн хүрээнд зохицуулах, өргөмжлөх/
- Соёл, ёс суртахууны баталгаа /хүний эрхийг нийтэд хүлээн зөвшөөрүүлэх, тэдний ухамсар, соёл, зан байдал, амьдралын үйл ажиллагаанд дадал зуршил болгон хэвшүүлэх/
- Олон улсын гэрээ конвенц, эрх зүйн актуудаар баталгаажуулах
- Экологийн, Эрүүл мэндийн, Аюулгүй Байдлын

Дээрх баталгааг зохицуулан хангаж өгснөөр төрийн үүрэг биелэх ба харин иргэний үүрэг маань энэ баталгааг эрхийнхээ хүрээнд, үүргээ хүлээн биелүүлснээр хэрэгжинэ.

Хүний Халдашгүй Эрх түүнийг хангах Баталгаа хоёр нь нэг зоосны хоёр тал бөгөөд нэгийг нь нөгөөгүйгээр төсөөлөхийн аргагүй. Энэ хоёр нь харилцан нэг нэгнийгээ тодруулан томьёолж байдаг чухал ач холбогдолтой зүйл болж байгаа ба энэ нь Хүн - Хүмүүсийн холбоо - Нийгэм - /УТ-ЭЗ/ Төр - Улс орны хөгжил, дэвшлийн гол чухал үндэс суурь оршвой.

ХҮНИЙ ЭРХ БА ЭРХ ЧӨЛӨӨ*

*Ц.Эрдэнэчимэг
“Халх журам” дээд сургуулийн
I дамжааны сонсогч*

Хүний халдашгүй эрх, эрх чөлөө гэдэг бол тухайн хүнд өөрт нь байдаг хүмүүс зарим нь хүний эрхэнд эрх чөлөөгүй байдаг. Энэ нь тухайн хүн өөрөө эрхээ эдэлж чадахгүй байгаа нэг хэлбэр юм. Хүний эрх гэдэг бол миний бодлоор хүнд өөрт нь л байдаг аль нэгэнд байгаа гэж найдаж болдоггүй юм. Хүний бие эрхтэний халдашгүй эрх гэдэг нь ямарч тохиолдолд хэнч бай дур мэдэн хүний аливаа үйлдэл хийлгэх эсвэл хийлгэхгүйн тулд нууцад хамаарах зүйлийг нь олж мэдэх үг хэлүүлэх, мэдүүлэг өгүүлэх, нэр төрийг нь гутаах, доромжлох зэрэг тодорхой зорилгоор албадаж хүчтэй өвтгөх эсвэл бие дээр нь элдэв зураг тэмдэглэх, сорил туршилт хийх байдлаар хүний бие махбодид халдаж болохгүй туйлын эрх мөн.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуулийн 38, 45-р зүйлд заасан байдаг.

Хүмүүстэй холбоотой ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд хүний халдашгүй эрхийг хамгаалах тухай асуудал цаг ямагт гарч ирдэг.

Иргэдийн халдашгүй дархан байдал, нэр төр бусад эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхол өмчийн олон хэлбэрийг хамгаалах, олон нийтийн газар иргэдийн тайван байдлыг хангах, хүмүүсийн амьдарлын хэрэгцээг хангах явцад тэднээс хоорондоо харилцах зайлшгүй нөхцлийг бүрдүүлэх зорилготой. Манай нийгмийн бүтээн байгуулалтын хэрэгцээ шаардлагаар нөхцөлдөн гарна. Монголын ард түмний эрх ашигт нийцсэн эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээгээр зохицуулагдана. Хүн хүнээ дарлан мөлжих явдлаас ангижирсан, нийгмийн гишүүдийн дунд нийгмийн гишүүдийн эрх тэгш ёс тогтсон үед нийгмийн хувийн эрх ашгийн нэгдэлд нийгмийн эрх ашгийг урьтал болгон үзэх түшиглэсэн нийгэм бие хүний хоорондын харилцааг илэрхийлэгч зарчим мөн.

Нийгмийн эрх ашигт зохицуулан уг зорилтын үндсэн дээр хүмүүсийг нэгтгэгч ёс суртахуун, улс төрийн нэгдлээр онцлог зохион байгуулалтын тодорхой бүтэц бүхий өөрөөр хэлбэл хүний халдашгүй эрх, удирдан захирагч байгууллагатай нийгмийн зохицол мөн. Үүнд өмчийн эрх ашгийг авч үзвэл. Хүн бүрт эд хөрөнгийг хувьдаа болон бусадтай хамтарч өмчлөх эрхтэй. Хэний ч эд хөрөнгийг дураар хураан авч болохгүй гэж Олон улсын хэмжээнд

* ХЭҮК-оос олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан их дээд сургуулиудын оюутны дунд зарласан “Хүний халдашгүй эрх, түүнийг хангах баталгаа” сэдэвт эссэний уралдаанд II байр эзэлсэн эссэ

халдашгүй эрхийн агуулгаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Иймд өмчийн халдашгүй эрх гэдэг нь аливаа хүний шударгаар өмчилж байгаа эд хөрөнгөнд хэнч дураар халдан өмчлөлөөс нь салгаж болохгүй туйлын эрх гэж тодорхойлж болно. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авах хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө гэж өмчийн халдашгүй эрхийг хүлээн зөвшөөрсөн билээ.

Өмч эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх нь хүний өөрийнх нь хэрэгцээ амьдарлын шаардлагатай шууд хамаарна. Хүн эрхээ эдэлж байгаа гээд бас замбараагүй загнаж болохгүй. Сая л гэхэд манай өндөр настангууд тэтгэвэр нэмэгдүүлж өгөөч гээд төрийн ордонруу халдсан. Мөн оюутны эрхийн өдөр болсон тэр үед манай оюутнууд олон улсын оюутны эрхийн өдрөөр жагсаал цуглаан хийсэн бөгөөд эрхээ эдэлж байгаа нь гээд төрийн ордонруу бүдүүлгээр дайрч цонх хагалан, гудамжинд зогсож байсан машиныг эвдэлж хэмхэлж байсан. Энэ нь бусдын хувийн өмчид халдаж буй хэрэг юм. Харин иргэд бид эрх чөлөөндөө анхаарч улс орноо хөгжүүлэх юмсан гэж ярих хүмүүс олон. Хэрэв тэгж их хөгжүүлэхийг хүсэж байгаа юм бол боловсон харьцаатай хүн өөрийхөө эрх ашгаа мэддэг байх ёстой. Хүний нийгэм үүссэн цагаас хойш захирах захирагдах харьцаан дээр оршин тогтнож ирсэн.

Нэгэнт л эрх мэдэл нь нийгэмтэй холбоотой байдаг учраас нийгмийн үндсэн нэг хэсэг бо ж байдаг. Нэгэн улс төрч тодорхойлохдоо “хүн угаасаа эрх мэдэлрүү тэмүүлдэг чанарыг агуулдаг”. Иймд эрх мэдэл баялаг нэр хүнд эрх чөлөө зэргийг олж авч улмаар амьдарлаа сайжруулах нэгэн арга хэрэгсэл болдог байна. 2005 оны Улсын их хурлын байнгын хорооны хурлаар сонгуулийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг явуулсан бөгөөд уг хуулийн төсөлд зааснаар Олон нийтийн болон бусад радио телевизээр нэр дэвшигчдийн сурталчилгааг үнэ төлбөргүй явуулна гэж заасан байсныг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар дэмжсэн. Үүнийг юу гэж ойлгох вэ. Улсын их хурлын гишүүд бол ард түмний эрх ашгийн төлөө төлөө ажиллах үүрэг хүлээсэн хүмүүс. Энэ хүмүүс ичихгүй хувийн өмчийн үйл ажиллагааг дураараа өөрчилж эрхэнд нь халдах санаа гаргаж байна. Энэ мэт иргэд нь ч төрийн түшээд нь ч тухайн хүний эрхийн талаар хомсхон бодолтой байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАМБАРЫН ЭНХБАЯРЫН ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН ДЭЭР ХЭЛСЭН ҮГ

2005 оны арванхоёрдугаар сарын 09

Хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулгандаа хүрэлцэн ирсэн Та бүхэнд чин сэтгэлийн мэнд дэвшүүлж, “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх” сэдэвт энэхүү чуулганы ажиллагаанд амжилт хүсэж байна.

Маргааш арванхоёрдугаар сарын 10. Энэ өдөр бол НҮБ-аас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон **ХҮНИЙ ЭРХИЙН ӨДӨР** билээ.

1990-ээд оноос монголчууд энэ өдрийг илүү сайн мэдэх болсон төдийгүй эдүгээ Монгол улсын хэмжээнд **НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ ТЭМДЭГЛЭЛТ** өдөр хэмээн хуульчлан тогтоогоод хоёр жилийн нүүр үзэж байна.

Хүний эрх, эрх чөлөө бол нэг өдрийн хэрэг биш уух ус, амьсгалах агаар мэт хүн бүрийн өдөр тутмын байнгын хэрэгцээ бөгөөд, түүнийг хамгаалах, хэрэгжүүлэх, баталгаажуулах тухай асуудал нь аливаа төр болон тийм үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан, иргэн бүрийн анхаарлын төвд ямагт байх асуудал мөн. Гэхдээ жилийн нэгэн өдрийг хүний эрхийн өдөр хэмээн онцгойлон тэмдэглэхээр тогтсон нь энэ өдөр тухайн улс орны төр, засаг, иргэний нийгмийн байгууллагууд, улмаар бүр дэлхий нийтээрээ хүний эрхийн төлөв байдал, түүний хэрэгжилт, баталгаажуулалтын асуудалд анхаарал хандуулж, хийснээ үнэлж дүгнэж, хийхээ хэлэлцэн тогтож, зорилтоо тодорхойлж ажиллахыг сануулсан хэрэг билээ. Энэ жилийн хүний эрхийн өдрийг чухам энэ утга агуулгад нь ойртуулан тэмдэглэхийг эрмэлзэхдээ Төрийн тэргүүн би хүний эрхийн байгууллагуудаас үндэсний чуулган хийх талаар гаргасан санал санаачилгыг дэмжихийн сацуу түүнийг Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулахыг зөвшөөрсөн юм.

Миний энэ шийдэл нь нэг удаагийн буюу тохиолдлын үйлдэл биш харин Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт сууж тусгагдсан төрийн бодлого зорилтын хэрэгжилтийн нэг хэсэг гэдгийг хэлье.

Иймээс би бүрэн эрхийнхээ хугацаанд жил бүрийн энэ өдрийг Монгол улсынхаа хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг иргэд болон төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтран хэлэлцэж, хүн бүрийн баталгаат эрхийг хангуулахын төлөө бодит ажлыг санаачлан түүнийхээ гүйцэтгэл дүгнэлтийг хэлэлцдэг өдөр болгохоор төлөвлөж байгаагаа сонсоё.

Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй энэ чуулганы бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлж ЕТГ-тай хамтран ажилласан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон ХЭҮК-т гүн талархал илэрхийлье.

“Хөгжлийн төлөө зүтгэл, хүний төлөө сэтгэл” гэсэн уриа бүхий сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд суурилсан Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны гол цөм нь хүн, түүний хөгжлийн асуудал билээ. Ийм ч учраас УИХ-ын энэ намрын чуулганы нээлт дээр хэлсэн үгэндээ би хүний хөгжлийн асуудлыг онцгойлон дэвшүүлж, төрийн бүх шатны байгууллага анхаарлаа хүнд төвлөн чиглүүлж, бодлого үйл ажиллагааныхаа үр дүнг хүний хөгжлийн түвшингөөр үнэлж дүгнэдэг арга барилыг удирдлага болгох чиглэлийг өгсөн билээ.

Хүний хөгжлийг эрхэмлэж байгаа нь үнэн бол хүний эрхийн асуудал онцгой анхаарах нь лавтай. Учир нь хүний эрх хаана баталгаатай хэрэгжиж байна, тэнд хүний хөгжлийн чөлөөт боломж бий болж, нэмэгдэж байдаг. Хаана хүний хөгжил хангагдаж байна, тэнд хүний эрх зөрчигдөх гажуудал, доголдол багасч байдаг зүй тогтолтой.

Хүний эрх, эрх чөлөө нь хүний хөгжлийн уг сурвалж нь ч, бас үр дүн нь ч мөн тул хүний эрхийн асуудлаас хүний хөгжлийг ангид, салангид авч үзэх учиргүй ээ. Тиймээс бид мянганы хөгжлийн зорилтуудыг эх орондоо хэрэгжүүлж, монгол хүний хөгжлийн түвшинг дээшлүүлбэ гэвэл иргэдийнхээ эрх, эрх чөлөө, нэн түрүүнд суурь, үндсэн эрх, эрх чөлөөг хангах талаар үндэсний чадавхи, боломжийг дайчлан ажиллахаас өөр замгүй. Энэ гурвалсан зорилтыг нэгдмэл нэг бодлогоор зангидан хэрэгжүүлэх шаардлагатайг энд хуран цугласан төрийн ба төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл та бүхэн нэн түрүүнд ухамсарлан, нийтэд үлгэрлэн ажиллах хэрэгтэй байна.

Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал ч ийм агуулгатай бөгөөд уг хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээсэн УИХ, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрийн удирдлага ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд тус тусын чиглэлээр юу хийснээ эргэн харж, нийтэд тайлагнаж, нийгэмд мэдээлэх цаг хугацаа болж байгааг үндэсний чуулганы индрээс миний бие Төрийн тэргүүний хувьд анхааруулан сануулахын ялдамд тус хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар үндэсний хөтөлбөрийн хорооны нарийн бичгийн даргын илтгэлийг та бүхэн өнөөдөр анхааран, сонсч, тал бүрээс нь шүүн хэлэлцэж, ажил хэрэгч саналаа нэмэрлэнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлбэ.

Ардчилсан нийгэм нь бүх иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаална хэмээн ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлаас гаргасан “Улаанбаатарын тунхаглал”-д дэвшүүлсэн зорилт, түүний үзэл санааг энд эргэн санацгаая. Энэ тунхаглалдаа бид хүний эрхийн гажуудал болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг засч залруулах үндэсний байгууллагын тогтолцоо болон механизмыг буй болгон бэхжүүлэх, тийм үйлдэл гаргасан хэнийг ч болов хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх,

Хүний эрх, эрх чөлөөг бүрэн хүндэтгэх явдлыг хангахын төлөө ажилладаг шударга хүмүүсийг хамгаалах үүрэг хүлээсэн билээ.

Ардчилсан өөрчлөлтийн 15 жилд Монгол улсад хүний эрхийн асуудал нь хийсвэр ойлголт, ерөнхий тунхаглалаас бодит хэрэгжилт, баталгаат эрх болох чиглэлд багагүй ахиц гарсныг үгүйсгэх аргагүй юм.

Олон улсын хүний эрхийн Билд нийцүүлэн тунхаглаж, шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан хүн ба иргэний эрх, эрх чөлөөний иж бүрдэл үзэл санаа салбарын эрх зүйн хуулиудад тусгалаа олсноор эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн гэж хэлж болно. Түүнчлэн Монгол улс хүний эрхийн талаархи НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 40 шахам гэрээнд нэгдэн орж, зохих үүрэг хүлээн ажиллаж байна.

Засгийн газар одоогоос 5 жилийн өмнө буюу 2000 оны 12 дугаар сарын 10-нд хүний эрхийн үндэсний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “үндэсний хөтөлбөр боловсруулах төсөл”-ийн хүрээнд хүний эрхийн төлөв байдлын талаар улсын хэмжээнд дэлгэрэнгүй судалгаа хийж, үнэлэлт өгсөн.

Улмаар хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний байгууллагын статус, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлсон хууль батлагдаж, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/ байгуулагдаж, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулж, парламентаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлж байна.

Хүний эрхийг сахин биелүүлэх, хамгаалах, хангах үүргээс чөлөөлөгдөх нэг ч байгууллага, албан тушаалтан байх ёсгүй. Юуны урьд хүний эрхийг хангах үндэсний механизмыг үр дүнтэй ажиллуулахад түүний бүрдэл хэсэг болох байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, шахаж шаардаж ажилуулья.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдаад 2 жил боллоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг 2 жил тутам гаргаж, УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж байх тухай УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын заалтыг хэрэгжүүлж, энэ асуудлыг ирэх жилийн хаврын чуулганаар хэлэлцэхийг УИХ-д хандан санал болгож байна. Энэ бол зөвхөн Засгийн газрын мэдээлэл тайланг сонсоод өнгөрөх төдий биш, хүний эрх, хүний хөгжил, нийгэм эдийн засгийн хөгжил, үндэсний аюулгүй байдлын асуудалтай уялдуулж, нухацтай авч хэлэлцвэл зохих асуудал мөн гэдгийг цохон хэлье.

Засгийн газрын бүхий л үйл ажиллагаа хүний эрхийн нийгэм, эдийн засгийн баталгааг бий болгоход чиглэгдэж байдаг гэж хэлж болно. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах, ажлын байр бий болгох, амьдрах, суралцах, эрүүл аж төрөх таатай орчин бүрдүүлэх гээд бүх л зорилт нь хүний эрхийн асуудалтай холбогддог. Иймд Засгийн газрын гишүүн бүр эрхэлсэн салбар хүрээндээ, бүх шатны Засаг дарга нар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүртээ хүний хувийн болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын тодорхой эрхүүдийг хангах нөхцөл бүрдүүлэх, хамгаалан хангах талаар явуулж буй үйл ажиллагаагаа дээд шатны удирдлагын болон иргэдийнхээ өмнө хариуцан тайлагнавал зохино. Энэ удаа Улсын мэргэжлийн хяналт эрхэлсэн сайд, ЦЕГ-ын даргын илтгэлүүдийг сонсохоор чуулганы хөтөлбөрт тусгасан байна. Дараа дараагийн жилд бусад яам, салбарын удирдлага болон зарим аймгийн Засаг даргын илтгэлийг сонсодог уламжлал тогтвол сайн болох буйзаа.

Ардчилсан нийгмийн нэг гол шинж бол иргэддээ бүх талын оролцоог

хангаж байдагт оршино. Иргэдийн оролцоо өргөжсөн нийгмийг иргэний нийгэм ч гэдэг. Хүний эрхийн хэрэгжилт нь чухам л иргэдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын бүх талын оролцоог шаардаж байдаг нь тодорхой. Иргэдийн үүсгэл санаачилгын байгууллагууд нь иргэдийн аль нэг эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой байдаг. Энэ удаагийн чуулганд хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй төрийн бус байгууллага, түүний төлөөлөгчид уригдан оролцож байна. Хүний эрхийг хангах механизмын нэг чухал хэсэг болох төрийн бус байгууллагууд нь төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудтай сөргөлдөхийг урьдал болгох биш иргэдийн эрх ашгийн төлөө тэдэнтэй үр бүтээлч түншлэлийг хөгжүүлж, нэг зорилгын төлөө хамтран ажиллах соёлыг дэлгэрүүлэхийг уриалж байна.

Энэ чуулганд 21 аймгаас уригдан ирж оролцож байгаа ХЭҮК-ын хөдөө орон нутаг дахь итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь орон нутагтаа хүний эрхийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, түүнийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд оншгой үүрэг хүлээсэн хүмүүс билээ. Үндэсний комиссын үйл ажиллагааг орон нутаг төлөөлж байгаа Та бүхэнд итгэл хүлээлгэж буйгаа илэрхийлэхийн ялдамд иргэдийнхээ эрх, эрх чөлөөг бүрэн хүндэтгэх явдлыг хангуулахын төлөө сэтгэл тавин, зүтгэл гарган ажиллахыг хүсье.

Хүний эрхийн асуудал нэн олон талтай, туйлын өргөн хүрээтэй. Энэ удаа тус чуулган “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” гэж Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2-т заасан хүний эрхийн холбогдолтой тодорхой сэдвээр хийгдэж байгаа нь асуудалд ерөнхий биш, тодорхой хандаж буйн илрэл төдийгүй өнөөгийн манай нийгэмд нэн анхаарал татсан, тулгамдсан асуудлыг хөндөж байгаагаараа чухал ач холбогдолтой.

Хүний анхдагч, суурь, үндсэн эрхийн нэг болох энэхүү эрхийн баталгаа, хэрэгжилт, та бидний амьдарч, ажиллах нийгмийн орчны аюулгүй байдал, эрсдэл болон учруулж байгаа болон болзошгүй хөнөөл хохирлыг багасгаж, хүний эрхийг хангах арга замыг тодорхойлон ярилцах нь өнөөдрийн чуулганы гол зорилт байх нь дамжиггүй.

Энэ сэдвээр судалгааны багуудын тайлан болон холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэлд тулгуурлаж судлаач мэргэжилтнүүд, төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнууд, иргэдийн төлөөлөл та бүхэн тал талаас нь ярилцана хэмээн итгэж байна.

ХОТ СУУРИН ГАЗАРТ ИРГЭДИЙГ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ НЬ

*Д.Сандаг-Очир
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
хошууч генерал*

Монгол улс дэлхий нийтийн ерөнхий чиг хандлагыг баримтлан өөрийн орны онцлогт тохируулан үндэсний хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөөний асуудлыг тусган хэрэгжүүлж байна.

Хууль тогтоомжийн заалтууд нь нийгмийн аль ч салбарт үйлчлэхийн зэрэгцээ өдрөөс өдөрт урган гарч буй шинэ шинэ эрэлт хэрэгцээ, түүнийг дагасан харилцаа, онцлогоос хамааран улам боловсронгуй болж байна.

Монгол улс ардчиллын замыг сонгон авсан цагаасаа хойш хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдал зэрэг зайлшгүй байх ёстой гол хүчин зүйлүүдийг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн хууль, эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалж байна.

Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх нь төрийн бодлогын нэн тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах талаар дэс дараатай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна.

Монгол улсын Үндсэн хуулиар аливаа хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн дэг журмыг гажуудуулахыг хориглосон байдаг.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж, хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг удирдлага болгон ажиллаж байна.

Сүүлийн 3 жилд /2002-2004 он/ улсын хэмжээнд 61394 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх 3 жилийнхээс 12.9 хувиар буурсан байна.

Дээрх хугацаанд хүн ам нэлээд төвлөрсөн төв, суурин газарт 43409 гэмт хэрэг үйлдэгдсэн нь нийт гэмт хэргийн 70.7 хувийг эзэлж байна.

Төв суурин газарт үйлдэгдсэн гэмт хэргийн 35.7 хувь нь хулгайлах, 12.1 хувь нь иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг, 9.7 хувь нь танхайрах, 5.9 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 4.7 хувь нь залилан мэхлэх, 4.9 хувь нь дээрэмдэх, 2.5 хувь нь булаах, 2.1 хувь нь хүчиндэх гэмт хэрэг байна.

Статистик тоо баримтаас үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нийт гэмт хэргийн зонхилох хувийг эзлэж байна.

Хэдийгээр гэмт хэргийн гаралт буурч байгаа ч гэмт хэрэг үйлдэгсэдийн арга нарийсч харгис хэрцгий, зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байгаагийн гадна галт зэвсэг хэрэглэж гэмт хэрэг үйлдэх явдал цөөн биш байгаа нь анхаарал татаж байна.

Гэмт хэргийн улмаас зөвхөн хохирогч төдийгүй түүний ар гэр, ах дүү, төрөл төрөгсөд, түүгээр ч зогсохгүй тэдний эргэн тойрны олон хүний эрх ашиг хохирч байна.

Сүүлийн гурван жилд гэмт хэргийн улмаас 5821 хүн амь насаа алдаж, 18698 хүн гэмтэж, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 65.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд цагдаагийн нийт бие бүрэлдэхүүн анхаарал төвлөрүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргасан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 оны 41 дүгээр тогтоолоор хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний цогц эрх зүйн баримт бичиг болох “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Энэхүү хөтөлбөр нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа, механизмыг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйлсэд төрийн байгууллага, албан тушаалтны санаачилга, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн чухал баримт бичиг юм. Цагдаагийн ерөнхий газраас “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг гарган хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд Монгол улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенци, бусад хууль тогтоомжид заасан, түүгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах асуудал хурцаар тавигдаж байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн дэмжлэг туслалцаа, хүч оролцоогүйгээр төдийлэн үр дүнд хүрэхгүй гэдэг нь тодорхой юм.

Иймээс цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулахад анхаарал төвлөрүүлж ирлээ.

Энэ байдалд судалгаа дүгнэлт хийж Цагдаагийн ерөнхий газар Монголын нээлттэй нийгэм хүрээлэнтэй хамтран 1999-2004 онд “Цагдаа-Олон нийтийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлж ирлээ.

Тухайлбал: Сүүлийн жилүүдэд төв суурин газарт иргэдийг гэмт халдлагаас хамгаалах цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулан шуурхай хүргэх зорилгоор Япон улсын цагдаагийн байгууллагын туршлага болох “Кобан” буюу цагдаагийн бичил хэсгийн 34 байрыг нутаг дэвсгэрийн төр захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр барьж 24 цагаар ажиллуулж байгаа нь үр дүн өгч байна.

Мөн энэ намар баруун аймгуудын төв зам болох Төв аймгийн Лүн сумын төвд үлгэр жишээ цагдаагийн бичил хэсгийг шинээр барьж ашиглалтад орууллаа.

Бараа бүтээгдэхүүний баглаа боодол, тээврийн хэрэгслийн гадна талд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг байрлуулах, хариуцсан нутаг дэвсгэрээ квадратын системд хуваарилан албан хаагчдад хариуцуулах, цагдаа олон нийтийн төв байгуулах, уулзалт ярилцлага, тэмцээн, уралдаан, өдөрлөг зохион байгуулах, телевиз радиогийн нэвтрүүлэг, гарын авлага, зураг хуудас, санамж тараах зэрэг олон ажлуудыг дурьдаж болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсний дүнд цагдаагийн ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүний эрх, эрх чөлөөг хангах үүднээс хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын явцад мэдүүлэг байцаалт авахад орчин үеийн арга тактикийг ашиглах, иргэдэд үзүүлэх ажил үйлчилгээг боловсронгуй болгох, цагдаа иргэдийн хооронд түншлэлийн харилцааг бий болгох зэрэг үйл ажиллагаанд чанарын бодитой алхамууд хийгдлээ.

Цагдаагийн байгууллагаас бусад холбогдох байгууллагатай хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сүүлийн 3 жилд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 12.9, албан газар, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 28.1, нийтийн зах, худалдааны төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 15.2, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.0, хүүхэд оролцсон гэмт хэрэг 11.3, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 5.0 хувиар тус тус буурлаа.

Цагдаагийн байгууллага эрх зүйн шинэчлэгдсэн орчинд хүний эрх, эрх чөлөөг хангах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, эрх зүйн шинэчлэлтийг гүнзгийрүүлэхэд чиглэгдсэн нэлээд арга хэмжээ авч байна.

Дээрх ажлын хүрээнд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, нийгмийн хэв журам хамгаалах, замын цагдаагийн албаны болон нутаг дэвсгэрийн цагдаагийн бүтцэд зарим өөрчлөлт оруулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Эдгээр арга хэмжээнүүд нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хөндөгдсөн эрх ашгийг нь сэргээн эдлүүлэхэд иргэдэд ойр, тэдний дэмжлэг туслалцааг авах, нээлттэй байх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд төв суурин газар, түүний дотор нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудад шилжин суурьшигчдын тоо улам бүр өсөж, түүнийг даган нийгмийн сөрөг үр дагавар үүсэх нөхцөл бүрэлдэж байна.

Нийт хүн амын 45.8 хувь оршин сууж байгаа нийслэл хотод бүх гэмт хэргийн 48.6 хувь нь үйлдэгдсэн байна.

Төв суурин газарт үйлдэгдсэн гэмт хэрэгт нийт 38398 хүн холбогдон шалгагдсаны 75.1 хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй, 6.3 хувь нь эмэгтэйчүүд, 5.7 хувь нь оюутан, сурагч, 4.0 хувь нь хүүхэд байна.

Дээрх тоо баримтаас үзвэл нийгмийн дунд бий болсон ажилгүйдэл, ядуурал, архидан согтуурах явдал нь гэмт хэрэг гарах гол шалтгаан нөхцөл болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэхээс харьцангуй хямд өртөгтэй, үр дүнтэй ажил гэдгийг хүн бүхэн хүлээн зөвшөөрдөг билээ.

Энэ ажил нь төрийн болон төрийн бус байгууллага, албан газар, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын оролцоо, дэмжлэгтэйгээр үр дүнд хүрэх тухай “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” тухай хуулинд тодорхой тусгагдсан билээ.

- Хуулиар ногдуулсан үүргийг иргэн бүр ухамсарлан биелүүлж чадвал гэмт хэрэг, зөрчлийн гаралтад эерэг нөлөө үзүүлэх сайн талтай билээ.

Үүний тулд бүх нийтээр дагаж мөрдвөл зохих төрийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, уламжлалт ёс заншлаа дагаж, ахмад үеэ хүндэтгэх, эх орноороо бахархах үзлийг өсвөр залуу үеийнхэнд төлөвшүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах нь чухал байна.

- Улс орны ирээдүй болсон хүүхэд багачуудад гэр бүл, сурган хүмүүжүүлэгч нараас тавих хяналтыг нэмэгдүүлж, тэднийг мэдлэг боловсролтой шударга иргэн болгох нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

- Төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох, түүгээр дамжуулан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөндөгдсөн эрх ашгийг нь сэргээх нь нэн тэргүүний шаардлага болж байна.

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажлын байраар хангах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, энэ ажилд аж ахуйн нэгж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь хэлэлцэж байгаа асуудлыг эерэгээр шийдвэрлэхэд чухал нөлөөтэй юм.

- Гудамж талбайн гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэх, телекамерийн хяналтад авах, дулааны худаг, хүн орогнодог хонгил, дээврийн хөндийг бэхэлгээтэй болгох, явган зорчигчдын болон авто замын засвар арчилгааг сайжруулах, гудамж, хашааг хаягжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байна.

- Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдаалдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төр, засаг, хууль хяналтын байгууллага иргэдээс тавих хяналтыг эрс сайжруулах шаардлагатай байна.

- Гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй гудамж талбай, эмзэг цэгүүдийг цагдаагийн хяналтад авах, энэ ажилд нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч, урамшилтай эргүүл жижүүр, нийтийн эргүүлийн дэмжлэг тусалцааг авч, нягт хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлыг улам боловсронгуй болгож материаллаг талаас нь анхаарах цаг нэгэнт болсон байна.

Эмзэг цэгүүдийг телекамерийн хяналттай болгоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал, санаачилга, дэмжлэг тусалцаа чухал байна.

- Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, гэмт хэрэгт сэжиглэгдэн батлан даалтанд гадуур шалгагдаж байгаа этгээд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй хүмүүс, архаг архичдыг бүртгэл судалгаанд бүрэн хамруулан тэдэнтэй уулзаж ярилцах, хамт олон, гэр бүлийн хяналт, дэмжлэгт тулгуурлан цаашид зөрчил дутагдал гаргахгүй байх олон хэлбэрийн ажлуудыг зохион байгуулах явдал нэн чухал юм.

- Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөндөгдсөн эрх ашгийг нь сэргээхэд үнэ цэнэтэй гэдгийг иргэн бүр ухамсарлан энэ талаар цагдаагийн байгууллагатай нягт хамтран ажиллахыг хүсч байна.

- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэргийн хор холбогдол урьдчилан сэргийлэх арга замын талаар бодит мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх нь тэднийг гэмт халдлагаас хамгаалахад чухал ач холбогдолтой бөгөөд цаашид энэ ажилд төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоо ч хэрэгтэй байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байнгын дэмжлэг тусалцаа үзүүлж хамтран ажиллаж ирсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд талархал дэвшүүлье.

Түүнчлэн хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарсан уулзалт ярилцлага, сургалт зөвлөгөөнийг зохион байгуулах зэргээр ажлын уялдаа холбоогоо улам сайжруулж үр дүн алдаа оноогоо дүгнэн цаашдын зорилтоо тодорхойлох талаар илүү санаачилгатай ажиллах явдал чухал байна.

Иймд та бүхнийг энэ чиглэлээр үр дүнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй Хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганаас гарах шийдвэрийг хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүний анхаарлыг төвлөрүүлж, холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Д.Дорлигжав

**Мэргэжлийн хяналтын асуудал
эрхэлсэн Монгол улсын сайд**

Өнөөдөр олон улсын хүний эрхийн өдрөөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор Хүний эрхийн үндэсний чуулганыг ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ сэдвээр зохион байгуулж буй нь Монгол улс хүний эрхийн талаар үндэсний болон олон улсын эрх зүйд нийцүүлсэн чухал асуудал болж байна гэдгийг юуны түрүүнд тэмдэглэн хэлье.

Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд “Хүн амьд явах эрхтэй”, “Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтууд болон түүнтэй уялдан гарсан хууль тогтоомж, аюулгүй байдлын стандартуудын хэрэгжилтийг хангуулах нь манай мэргэжлийн хяналтын байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргүүдийн нэг билээ.

Иймд хүний эрх, эрх чөлөөг хангах үндсэн асуудлын нэг хэсэг нь болох хүнс, бараа бүтээгдэхүүний, эмийн, байгаль орчны, барилга техникийн, хөдөлмөрийн эрүүл ахуйн зэрэг аюулгүй байдалд холбогдох нийгмийн харилцааны асуудлуудыг энэ талаар үйлчилж буй хууль тогтоомж, стандарт, эрх зүйн хүрээнд нь цогцоор нь авч үзэн шийдвэрлэх, тулгарч буй бэрхшээл зөрчил дутагдлыг арилгах нь манай улсын төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн үүрэг бөгөөд үүнийг хангаснаар Үндсэн хуулийнхаа дээр дурьдсан заалтыг бүрэн зөв утгаар нь хэрэгжүүлэх юм.

1. Хүнс, эм, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдал:

Дэлхийн эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар аливаа улс орны хүн амын эрүүл чийрэг, оюун ухаан сайтай, дундаж наслалт урт, хүүхэд багачууд нь өв тэгш өсч бойжих үндсэн нөхцлийн анхдагч суурь нь хоол хүнс гэж үзсээр байна.

Хоол хүнсний асуудал нь өрх гэрийн хүрээний асуудал мэт боловч чанартай, аюулгүй, хүртээмжтэй хүнсний зүйлээр хангах нь улс орны үндэсний аюулгүй байдлын тулгуур асуудлуудын нэг билээ.

НҮБ-аас дэвшүүлсэн Дэлхийн мянганы зорилтын нэгд хүнсний асуудал зүй ёсоор орж байгаа бөгөөд 1996 он, 2002 онуудад хүнсний асуудлаар дээд хэмжээнд чуулж, 2015 он хүртэлх зорилтоо дэвшүүлээд байна.

Статистикийн мэдээллээр 2004 онд жишсэн нэг хүнд мах, махан бүтээгдэхүүн 94.2 кг, сүү, цагаан идээ 138 кг, гурил, гурилан бүтээгдэхүүн

105.6 кг, өндөг 15.6 ш, төмс 33.6 кг, хүнсний ногоо 16.8 кг, жимс, жимсгэнэ 15.6 кг оногдож байна.

ХХААЯ-ны тайлангаас үзэхэд, улсын хэмжээнд 2004 онд 6.4 сая мал хүнсэнд хэрэглэж нядалгааны жингээр 199.3 мянган тн мах үйлдвэрлэсэн нь, 1990 оныхоос 20 шахам хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд жил дунджаар 312.6 мянган литр сүү үйлдвэрлэж 2004 онд 5.9 сая литр сүү боловсруулсан нь өмнөх дөрвөн жилийн дунджаас 2.1 дахин өссөн байна. Сүүлийн жилүүдэд түүхий эдийн хомсдолоос шалтгаалан эх орны гурилын үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлынхаа 15-20 хувийг буюу 47-54 мянган тн гурил үйлдвэрлэж, дотоодын гурилын хэрэгцээний 20-22 хувийг хангаж байна. Энэ нь газар тариалангийн үйлдвэрлэл буурсан, жилд хураан авч байгаа улаан буудайн хэмжээ 1990 оныхоос 10 гаруй дахин багассантай холбоотой гэж үздэг юм байна.

Төмс, хүнсний ногооны хувьд жилд дунджаар 55.7 мянган тн төмс, 29.9 мянган тн хүнсний ногоо хураан авч хүн амын физиологийн хэрэгцээт төмсний 63.5хувь, хүнсний ногооны 34.3 орчим хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

2004 онд Гаалийн Ерөнхий газраас гаргасан мэдээгээр 56 орны 89 нэр төрлийн хүнсний бүтээгдхүүн импортлосон байна. Импортлож байгаа нэр төрлийн 60-аас дээш хувийг ОХУ, БНХАУ, ХБНГУ, АНУ, БНСУ, 30-аад хувийг Япон, Малайз, Франц, Их британи зэрэг орнуудын бүтээгдхүүн эзэлж байна.

Импортын хүнсний хэмжээ нэмэгдэж байгаа нь нэг талаас хүн амын хүнсний хангамж сайжирч, өргөн сонголт хийх боломжоор хангагдаж байгаа мэт боловч нөгөө талдаа импортлогдож буй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага төдийлөн хангагдаж чадахгүй байгаа нь манай мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын үр дүнд илрүүлсэн зөрчил дутагдлаас тодорхой харагдаж байна.

Тухайлбал: 2004 оны байдлаар улсын хилээр “31” гол нэрийн 550 мянга гаруй тонн хүнсний бүтээгдэхүүн импортлосны 40 гаруй хувийг УМХГ-ын хилийн болон гүний мэргэжлийн хяналт шалгалтанд хамруулсан бөгөөд хяналтын явцад авсан 12500 гаруй сорьц, дээжинд УМХГ-ын Үндэсний төв лаборатори 31 мянга гаруй үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 8,2 хувь нь буюу 1012 сорьц эрүүл ахуйн аюулгүйн шаардлага хангаагүй гарсан байна.

Бүтээгдэхүүний нэр төрлөөр нь авч үзвэл, архи, спирт, цай, кофе, шоколадтай, кремтэй бүтээгдэхүүн, хоол амтлагчууд нь илүү бохирдолтой буюу хүний эрүүл мэндэд тохирох стандартын шаардлага хангаагүй байжээ.

Ургамал, ургамлын гаралтай нийт 52 нэр төрлийн бүтээгдэхүүний 2000 гаруй сорьцонд шинжилгээ хийсний 10 гаруй хувьд нь биологийн бохирдлын илрэл болох нитратын хэмжээ зөвшөөрөгдөх нормоос их гарч, шаардлага хангахгүй төмс хүнсний ногоо нь их төлөв хуурай илжрэл ихтэй байсан байна.

Жимс, жимсгэнэ, хүнсний ногоонд нитратын агуулга, цай, кофе, какаонд хөгц, мөөгөнцрийн бохирдол зөвшөөрөгдөх нормоос их, бүх төрлийн архи,

спиртэнд хийсэн шинжилгээгээр совсны тос, цууны алдегидийн хэмжээ стандартад заасан нормоос их гарчээ.

Ургамлын хорио цээрийн зөрчлийн дийлэнх нь үр тариа, гурил, будаа, элсэн чихэр, цай, самар, төмс хүнсний ногоо, жимс жимсгэний төрлийн бүтээгдэхүүнд илэрсэн байна.

Мал бэлтгэлийн төвлөрсөн систем үгүй болж, зах зээлд ил задгай нөхцөлд нядалсан мал мах зонхилж улсын хэмжээгээр бэлтгэж байгаа махны ердөө 4-5 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна.

Нийслэл Улаанбаатар хотын хүнсний захуудад борлуулагдаж буй махнаас дээж авч шинжлэхэд 100 хувь нянгаар бохирдсон байснаас гадна 60 хувь нь хальсгүйжсэн, 9-12 хувь нь үнэр, өнгөний өөрчлөлт орсон, 16 хувь нь өнгөц ялзалтай, 3.9 нь салсжилттай, хөгцрөлт, толботолт тус бүр 2 хувийг эзэлж байжээ.

2005 оны хаврын тариалалтанд зориулж улсын үрийн нөөцийн 11 салбарт 6200 гаруй тн үр тариа нөөцөлсөнөөс 1100 гаруй тн улаанбуудайг таваарын зориулалтаар хүлээн авсан байна. Үрийн зориулалттай нөөцөлсөн 5100 гаруй тн буудайнд хийсэн шинжилгээний дүнгээр шинжлэгдсэн үрийн дөнгөж 5.0 хувь нь тарих үрийн стандартад тэнцсэн, 93.0 хувь нь цэвэршилтээрээ, 94 хувь нь нэг кг дахь хог ургамлын үрийн хольцоороо стандартын шаардлага хангахгүй дүн гарчээ.

Хоол хүнсний аюулгүй байдлын асуудал хүний эрүүл мэндтэй шууд холбоотой байдаг. ЭМЯ-ны харьяа Эмнэлгийн тусламжийг удирдах газраас гаргасан 2003-2004 оны өвчлөлийн мэдээнээс үзэхэд нийт өвчлөлд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг 2-р байрыг эзэлж, улмаар хорт хавдрын тохиолдол, тархалт, нас баралтын үзүүлэлтэд элэгний болон ходоодны хорт хавдрын өвчлөлийн тохиолдлын тоо, тархалт, нас баралтын 10 000 хүн амд ногдох үзүүлэлтээр хамгийн их хувийг эзэлж, жилээс жил тутамд өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 3 жилийн /2002-2004/ байдлаар хоол хүнсээр дамжсан хоолны хордлогот халдварын 4 удаагийн томоохон дэгдэлт гарч нийт 300-аад хүн өвчилсөн бөгөөд энэ нь 2000-2001 оны өвчлөлөөс 4 дахин нэмэгдсэн байна.

Үүнийг тохиолдлоор нь авч үзвэл 2002 онд 100 гаруй хүн, 2003 онд зуслан амарч байсан 37 хүүхэд, Улаанбаатар хотод нэг гэрийн 5 хүн, 2004 онд 226 хүн, 2005 онд 57 хүнийг хамарсан хоолны хордлогот халдварын өвчлөл гарсан байна.

УМХГ-ын төв орон нутгийн болон хилийн хяналтын албадаас эдгээр нийтийг хамарсан хордлого, хордлогот халдварын нөхцөл шалтгааныг тодорхойлох, таслан зогсоох, түүнээс сэргийлэх арга хэмжээг холбогдох яам, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, зөрчлийг арилгуулж ажилласан бөгөөд цаашид шувууны ханиад, шүлхий, боом зэрэг олон улсын хөл хориот өвчин эмгэг улс оронд үүсэж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлж хүнсний үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоолны хяналтыг чангатган ажиллаж байна.

Улсын хэмжээнд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1500 гаруй жижиг, дунд үйлдвэр ажиллаж байгаагаас мах, махан бүтээгдэхүүн

боловсруулах 120 гаруй, гурил, гурилан бүтээгдэхүүний 600 гаруй, сүү, цагаан идээний 160 гаруй, спиртын 21, архины 183, шар айрагны 41, дарсны 9, цэвэр усны 19, рашааны 9, ундаа, жимсний шүүсний 350 гаруй үйлдвэр, цех байна.

Эдгээр аж ахуйн нэгж байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын дүнгээс авч үзвэл архи үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийн 8-10 хувь нь хяналт шалгалтанд хамрагдахаас зайлсхийдэг, 22-32 хувь нь бүтээгдэхүүн нь стандарт чанар, аюулгүй байдлын шаардлага хангадаггүй, 15-21 хувь нь ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй байна.

Хиамны үйлдвэр, цехийн 48.7 хувь нь зориулалтын бус байртай, 63.2 хувь нь үйлдвэрлэлийн явцын технологийн тэмдэглэл бүрэн хөтөлдөггүй, 60 хувь нь батлагдсан технологийн зааваргүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 6.9 хувь нь нянгийн бохирдолттой байсан байна.

Ийнхүү хүнсний зүйл, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын стандартын шаардлага хангагдахгүй байгаа шалтгааныг:

Монгол улсын Хүнсний тухай хуульд зааснаар хүнс бэлтгэх, үйлдвэрлэх, худалдаалах, импортлох харилцааг бүхэлд нь тусгасан эрх зүйн орчинг бүрдэж чадаагүй ба Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуулийн 22.2.7 дахь заалт нь Хүнсний тухай хуулийн холбогдох заалттай зөрчиддөн, хяналт үйлчилгээний давхардал үүсгэснээс импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүн хяналт шалгалтанд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа, Хүнсний бүтээгдэхүүнийг иж бүрнээр шинжлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий үндэсний хэмжээний лабораторийн чадавхи бүрэн бүрдээгүй, мөн хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн хэмжээнд тусгасан үндэсний стандартгүй байгаад оршиж байна гэж манай мэргэжилтнүүд үзэж байгаа юм.

Манай улс хэрэгцээт эмийнхээ 80 гаруй хувийг импортолдог. Ийм хэмжээний эмийг импортолдог улсын хувьд ДЭМБ-ын “Олон улсын худалдаанд зориулсан эмийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын схем”-ийг мөрдөж экспортлогч улсын эрх бүхий байгууллагын чанарын сертификат бүхий эмийг захиалан авч байх зарчмыг мөрдөх ёстой хэдий ч эмийн чанар, аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсон олон талын гэрээ хэлэлцээрүүдийг иж бүрнээр хийж баталгаажуулаагүйн улмаас уг зарчим тууштай мөрдөгдөж чадахгүй байна.

Дэлхийн эмийн зах зээлд эргэлдэж буй эмийн 10%-ийг хуурамч стандартын бус эм эзэлж, 32 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Манай хойд хөршийн эмийн зах зээлийн 35-40%-д хуурамч, стандартын бус эмийн бүтээгдэхүүн зарагдаж, өмнөд хөршид өнгөрсөн он гэхэд 1600 эмийн нууц үйлдвэрийг хаасан байна.

Манай эмийн чанарын хяналтын улсын байцаагчдаас эмийн худалдааны зах зээлийн борлуулалтанд хийсэн шалгалтаар импортын болон эх орны үйлдвэрийн нийт 18 нэр төрлийн эм хуурамчаар үйлдвэрлэгдсэн болохыг тогтоосон юм.

Эмийн чанарын лабораторийн материалаас үзэхэд эмнэлгийн эмийн санд найруулсан эмэнд 8-12% нь стандартын шаардлага хангаагүй эм байдаг байна.

Мөн 2005 оны эхний хагас жилд УМХГ, ЭМЯ-тай хамтран “Зах зээл дэх хуурамч эмийн танадалт” судалгааг нийслэлд болон 4 аймагт хийж үзэхэд зах зээл дээр шаардлага хангасан эм 73.3 хувь, чанарын шаардлага хангаагүй эм 26.7 хувь, хуурамч эм 13.3 хувийг тус тус эзэлж байна гэсэн дүнг гарсан зэргээс үзэхэд энэ чиглэлийн хяналтын үйл ажиллагааг улам сайжруулах, хүн амаа эрүүл аюулгүй хоол хүнс, эмээр хангах нь юуны түрүү чухал болохыг харуулж байна.

2.Байгаль орчны аюулгүй байдал:

Үүнд, нэгдүгээрт усны асуудал байна. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 2/3-ийг эзэлдэг тал хээр, говьд усны нөөцийн 36.7 хувь нь ноогддог байна.

2003 онд явуулсан усны тооллогоор 5097 гол горхи, 9582 булаг шанд бүртгэгдсэнээс 372 гол горхи, 1158 булаг ширгэсэн, 1530 уст цэг устаж үгүй болсон гэсэн тооцоо гарчээ.

Улсын хэмжээнд ундны усны 30.8 хувийг ус түгээгүүрийн төвлөрсөн системээр, 24.4 хувийг зөөврийн усаар, 35.7 хувийг ус түгээх цэг болон худгаас 9.1 хувийг булаг шанд, гол горхи, цас мөсний усаар хангаж байна.

Туул гол 5-р зэргийн бохирдолттой гарч энэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их байна. Бохирдсон усны 47 хувийг үйлдвэрийн хаягдал, 53 хувийг ахуйн болон орон сууцны хаягдал эзэлж байна.

Улаанбаатар хотын хүн амыг ундны цэвэр усаар хангах, усны эх үүсвэр түүний тэжээгдлийн мужийг хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Нийслэлийн Засаг дарга “Усны тухай” /1995,2005 онд батлагдсан/ хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн эрх зүйн орчинг бүрдүүлэх, хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох талаар дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлж чадахгүй байгаагаас цэвэр усны эх үүсвэрүүд дээр элдэв барилга байгууламж байгуулагдан аюулгүйн баталгааг алдагдуулах нөхцлийг бүрдүүлсэн нь манай байцаагчдын хяналт шалгалтаар тогтоогдсон байна.

Улаанбаатар хотын ундны усны төвийн эх үүсвэр нь Оргил рашаан сувиллын зүүн урд хэсэг Их тэнгэрийн гүүрний хойд хэсгээс Гачууртын хар усан тохой хүртэлх нийт 15 км орчим газар үргэлжилдэг. Гэтэл усны эх үүсвэрийг хамгаалах асуудал сул бөгөөд хоногт 114.0 мянган шоо метр ус олборлох хүчин чадалтайгаас одоо 70.0 мян.шоо метр ус олборлож байгаа нь хотын усны хэрэглээний 50 гаруй хувь, хүн амын усны хэрэглээний 70-80 хувийг хангаж байна.

Төв орон нутгийн МХГ-ын лабораторит нийт 2442 усны дээжинд хими, физик, нян судлалын 10119 үзүүлэлтээр шинжилгээ хийсний 36.5% нь ундны усны чанарын шаардлага хангаагүй гарчээ.

Улаанбаатар хотын ундны усны төвийн эх үүсвэрийн хөрсөн бүрхэвч нь нянгийн бохирдолтоор дунд зэргийн хэмжээнд, ус нь нянгийн болон хүнд металлын бохирдолттой, тухайлбал, Дунд голын урд хэсэг 36 дугаар худаг орчим,

Нарантуул захын урд хэсэг, Улиастайн гүүрний баруун урд, төмөр замын гармын урд 27 дугаар худаг, баруун захын 43 дугаар худаг орчимд хүнд металлын бохирдолт харьцангуй өндөр гарсан дүнтэй байна.

Хяналтын явцад хийгдсэн шинжилгээний дүнгээс харахад ундны усанд агуулагдвал зохих аммиак, нитрит, магни, хатуулаг, төмөр, нянгийн тоо, коли-титр, коли-индекс зэрэг үзүүлэлтүүд стандартад заасан шаардлагаас өндөр гарсан байна.

Ундны усны шим болон нян судлалын үзүүлэлтүүдийн халдварт өвчинд нөлөөлөх нөлөөллийг судлаж үзэхэд нийт халдварт өвчний гаралтад ундны усны нянгийн бохирдолт нөлөөлсөн байна гэсэн дүн байна.

Хөрс, орчин, агаарын бохирдлын байдалд хийсэн шалгалтын дүнгээс авч үзэхэд Улаанбаатар хотод амьдарч байгаа гэрийн хорооллын айл өрхүүдийн 67 хувь нь стандартын шаардлага хангаагүй бие засах газартай, 34.5 хувь нь бие засах газаргүй, бохир усны цооноггүй байна.

2004 онд хөрсний дээжинд хийсэн нян судлалын шинжилгээгээр 35.0% нь 3 дугаар зэргийн, 65.0% нь 4 дүгээр зэргийн бохирдолттой гарснаас харахад хөрсний бохирдолт жилээс жилд нэмэгдсээр байна.

Иймд хөрс, ус, агаарын бохирдлын зөвшөөрөгдөх нормын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж гаргах, ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоож, нөөцийг нэмэгдүүлэх. Асуудлыг бодлогын хэмжээнд цогцод нь шийдвэрлэж явах шаардлагатай байна.

Улс орон аж үйлдвэржиж, хотжихын хэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээ улам өсөн нэмэгдэж, дулаан, цахилгааны эрчим хүч үйлдвэрлэлийн явцад түлшний шаталтаас үүсч байгаа төрөл бүрийн хийн ба хуурай төлөвтэй хаягдлууд нийслэл хотын агаарын бохирдлыг жил ирэх тусам нэмэгдүүлж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдол 10 дугаар сараас эхлэн дараа оны 3 дугаар сар хүртэл ихэсдэг ба энэ нь галлагаа эхэлснээр агаарт гаргах бохирдуулах бодисын хэмжээ нэмэгддэгтэй холбоотой байна.

Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдол дараахь гол эх үүсвэрүүдээс шалтгаалж байгааг байгааг мэргэжлийн хяналтаар тогтоосон юм. Үүнд:

- Жилд 3.3 сая гаруй тонн нүүрс хэрэглэдэг 3 дулааны цахилгаан станц, тэдгээрээс агаар мандалд хаягдаж байгаа хүхэр ба азотын исэл, нүүрс төрөгчийн исэл, дэгдэмхий үнснээс бүрдсэн хорт бодис;
- 700 гаруй маркийн 70 мянга гаруй автомашин;
- Нүүрс, модоор галладаг зуух бүхий 90 гаруй мянган айл өрхийн пийшин зуухнаас агаарт гаргаж байгаа хорт утаа;
- Нүүрс түлдэг халаалтын болон технологийн зориулалттай /нам даралтын/ 400 орчим жижиг зуух, тэдгээрт жилд их хэмжээний нүүрс шатааж ямар ч шүүлтүүр, хяналтгүйгээр агаар мандалд хаяж буй хорт бодис;
- Жил ирэх тутам нэмэгдэж байгаа хаягдал төмөрлөг боловсруулах 30 гаруй үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт гаргаж байгаа хорт бодис;

- Эвдрэл, элэгдэлд орсон газраас боссон тоос шороо, хогийн цэгийн шаталт зэрэг болно.

Агаарыг бохирдуулагч дээрх эх үүсвэрүүдэд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

- Дулааны цахилгаан станцууд агаарт гаргаж байгаа бохирдуулагч бодисыг тодорхойлох дотоодын хяналтын багажаар тоноглогдож байгаа ч /ДЦС-4, ДЦС-3/ агаарт гаргах бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээний норм, стандарт байхгүйгээс хяналт тавихад хүндрэлтэй байна.
- Сүүлийн үед олноор байгуулагдаж байгаа хаягдал төмөр боловсруулах үйлдвэрүүд агаарт гаргаж байгаа хорт утааг хянах, бохирдлын хэмжээг бууруулах ямар нэгэн шүүлтүүр, тоног төхөөрөмжөөр тоноглоогүй, агаарт их хэмжээний хорт утаа гаргаж байгаа ба темрийн үйлдвэрийн агаарт гаргах бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээний норм, стандарт тогтоогдоогүй байна.
- Төвлөрсөн халаалтын шугаманд холбогдоогүй аж ахуйн нэгж байгууллагыг халааж байгаа БЗИУ-100, НР-24, НР-54 маркийн халаалтын зуухнууд нь олон арван жил ашигласан АҮК багатай, агаарт гаргах бохирдол ихтэй, техник технологийн шинэчлэлт хийгддэггүй, хоцрогдсон.
- Жил ирэх тусам нэмэгдэж байгаа АҮК багатай гэр хорооллын айл өрхүүдийн зуухны галлагаанаас агаар их хэмжээгээр бохирдож байна.

Дээрх эх үүсвэрүүдээс агаарт гаргаж байгаа утаан дахь бохирдуулагч хортой бодисуудын гаралтын норм, стандарт байхгүйн улмаас өнөөгийн нөхцөлд манай улсын байгаль орчны хяналтын байгууллагууд эх үүсвэр бүрийн агаарын бохирдолд үзүүлж байгаа нөлөөллийг бодитойгоор үнэлэх, хяналт тавих боломжоор муу байна.

Иймд нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд бохирдол багатай түлш ашиглах, дулааны үүсгүүрүүдийн ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлж, түлшийг аль болох хэмнэлттэй зарцуулах шаардлагатай байна. Үүний тулд дулааны эх үүсгүүрүүдийн ажиллагааны үед үүсч байгаа азот, нүүрстөрөгчийн ба хүхрийн исэл, үнс, тоос зэрэг хортой, бохирдуулагч бодисуудын гаралтын хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нормчлон тогтоож, хяналт тавих шаардлага урган гарч байгаа юм. Мөн түүнчлэн утаа ихтэй хуучин автомашины импортыг хязгаарлах, бохирдол ихтэй хоцрогдсон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхгүй байх зэрэг асуудлыг анхаарч хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.Барилга техникийн аюулгүй байдал:

Улаанбаатар хот өдрөөс өдөрт өргөжин тэлж, хамгийн сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмж, шинэ материал, хийц эдэлхүүн хэрэглэсэн, хэрэглэгчдийн ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн, тэдний

таашаалд нийцсэн, олон арван барилга байгууламж баригдаж, ашиглалтанд орж, талархлыг хүлээж байгаа нь барилгын салбарынхны ажлын үр дүн билээ.

Барилгын салбар түргэн хурдацтай хөгжиж, барилга угсралтын ажил өсөн нэмэгдэж байгаа хэдий ч барилгын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээ хангалтгүй байна. Барилга угсралтын ажилд “Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм” БНБД 3.01.05-90-ийг мөрдөхгүй байна.

Улаанбаатар хот болон бусад хүн ам өргөнөөр суурьшсан хот, аймгийн төвүүдийн газар хөдөлөлийн баллын муж, бүслэлийг тодотгон тогтоогоогүй байж барилга байгууламжийг олноор барьж байгуулан барилга техникийн аюулгүй ажиллагаа зөрчсөнийг шалгаж тогтоон стандарт, норм журмыг хангуулах ажлыг эхлүүлээд байна.

Сүүлийн жилүүдэд шинээр баригдсан барилга байгууламж ялангуяа орон сууцны барилгатай холбоотой оршин суугчдын гомдол их ирж байна.

Оршин суугчдаас ирүүлдэг гомдлын ихэнх хувийг вакум цонхны талаарх гомдол эзэлж байна.

Вакум гэж нэрлээд байгаа битүүмжилсэн цонхыг байгаль цаг уурын ямар нөхцөлд хэрэглэж болохыг тогтоогоогүй, цонх үйлдвэрлэх болон цонхны битүүмжлэлт, эдэлгээний чанарын талаар дагаж мөрдөх улсын стандарт, угсралтын ажлыг гүйцэтгэх аргачилсан заавар зөвлөгөө байхгүй байхад шинээр баригдсан бүх барилга байгууламжуудад вакум цонх угсарч байна.

Орон сууцны барилга барьж байгаа байгууллага аж ахуйн нэгжүүд нь барилгын дотор сантехникийн хэрэглэл, шугам хоолойн тоноглолуудыг сонгож хэрэглэхдээ зохих стандартыг судалж нэвтрүүлсний дараа хэрэглэх шаардлагатай байна.

Ер нь сантехник, ариун цэврийн өрөөний тоноглолуудын талаарх зөрчлүүд оршин суугчдыг байнга бүхимдуулж байна.

Нөгөө талаар сүүлийн үед барилгын материалын түүхий эд, бүтээцийн үйлдвэрлэлд хуурамч бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж импортлох байдал цөөнгүй гарч байна.

Эдгээр зөрчил дутагдал нь нэг талаас барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчдийн мэдлэг мэргэжил дутмаг, тэдгээрт эрх зөвшөөрөл олгож буй бодлогын яамнаас гүйцэтгэгчдэд тавих стандартын шаардлага сулаас шалтгаалан үйлдвэрлэлийн явцад БНБД-ын үзүүлэлт шаардлага зөрчигдөж буй бөгөөд нөгөө талаас барилгын материал түүхий эдийг импортлолж, худалдаалж буй байгууллага, иргэд, чанарын шаардлага хангаагүй түүхий эд, бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагын чанарын гэрчилгээгүйгээр цэвэр ашиг хөөсөн үйлчилгээ эрхэлдгээс шалтгаалан стандартын бус, хуурамч хаяг шошготой бүтээгдэхүүн зах зээлд цөөнгүй нийлүүлэгдэж байна.

Хэрэглэгчийн гомдлын мөрөөр зах зээлд нийлүүлэгдэн худалдаалагдаж буй цементийн чанарт шалгалт хийхэд хэрэглэгчийг чанарын болон, эдийн засгийн аргаар хохироосон ноцтой зөрчлүүд удаа дараа илэрчээ.

Дээжис балгиа ХХК-ны борлуулагч Б.Заяа гэгч этгээд Хятад улсын нэр хүндтэй үйлдвэрийн уут шоггыг ашиглан Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн цементийг нэг уут цементээс 2-3.5 кг дутуу савлан зарж байсан, БҮК-2 ХХК-ны хашаан дотор байрлах Буянцогт эзэнтэй савлах цэг Хөтөлийн үйлдвэрийн уутыг хуурамчаар дууриалган ашиглаж стандартын бус цемент савлаж байсан, Стандартаар савлагдах ёстой цемент нь 4.025 маркийн байх ёстой байтал түүн дээр 3.025 маркийн доод зэрэглэлийн цементийг хооронд нь хольж савлан хуурамч бүтээгдэхүүн болгон худалдаалсан зэрэг зөрчлүүдийг жишээ татаж болно.

Иймд барилга, техникийн аюулгүй байдлын асуудлаар хүний эрхийг хангах хүрээнд цаашид:

- Газар хөдлөлийн баллын муж, бүслэлийг тодотгон тогтоогоогүй бүсүүдэд баригдсан барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулах;
- Барилгын материал, эдлэхүүн, бүтээцийн норм дүрэм, стандартуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж гаргах;
- Барилгын материалын түүхий эд, бүтээцийн үйлдвэрлэлд гарч буй хуурамч бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг таслан зогсоох зорилгоор бодлогын яамнаас барилгын зураг төсөл зохиогчид, материалын үйлдвэрлэл, барилга угсралтын ажил гүйцэтгэгч байгууллагуудад эрх зөвшөөрлийг олгохдоо стандартын шаардлагыг заавал хангуулах, үгүй тохиолдолд эргээд энэ нь эд материал, цаг хугацаа, эрүүл мэндийн ихээхэн хохирол авчирна гэдгийг ухамсарлуулах;
- Одоогийн үүссэн нөхцөл байдлаас дүгнэхэд барилгын материал, түүхий эд, бүтээцийг импортлох эрхийг тусгай зөвшөөрлийн дагуу олговол хүний эрхийг хангах үүднээс чанартай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүй, чанарын баталгаатай бүтээгдэхүүнийг импортлох нөхцөл болох талтай.
- Мөн түүнчлэн хот, аймгуудын хуучин ерөнхий төлөвлөгөөг улс орны нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд зохицуулан шинэчлэн хийх нь энэ асуудлын хүрээнд шийдэгдэх шаардлагатай байгаа юм.

4. Авто замын аюулгүй байдал:

Монгол улс 49250 км авто замтай бөгөөд үүний 4% буюу 2329.7 км нь хатуу хучилттай, 8% буюу 3947.1 км хайрган буюу сайжруулсан, бусад нь хөрсөн зам, 27000 м урттай төмөр бетон болон модон гүүртэй байна. Мөн орон нутгийн чанартай 38129 км авто замтай бөгөөд үүнээс Улаанбаатар хотод 371 км хатуу хучилттай авто зам, 3018.5 у/м гүүр байна.

Авто зам гүүр нь байгаль, цаг агаарын байнгын нөлөөлөл, өдөр тутмын харилцан адилгүй динамик ачаалал, газар зүйн байршил хучилтын төрөл хийцээс хамаарч ашиглалтанд орсон тухайн цаг мөчөөс эхлэн элэгдэж гэмтэж эхэлдэг байнгын хамгаалалт, арчлалтанд байх шаардлагатай инженерийн байгууламж юм.

УМХГ-аас олон улсын болон улс, орон нутгийн чанартай зам, гүүрийн зураг төсөл барилга угсралт, арчлалт, хамгаалалтын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийдэг бөгөөд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор зөрчил дутагдлыг илрүүлж арилгуулах арга хэмжээ авч байна. Тухайлбал: Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Дархан-Эрдэнэт чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын 91 дэх км-т БНБД зөрчигдөж зохиогдсон зураг төслийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж тухайн цэгт автын осол удаа дараа гарсанд байцаагчийн дүгнэлт гарч холбогдох арга хэмжээ авахуулсан. Мөн Мянганы зам төслийн хүрээнд хэрэгжсэн Багануур-Өндөрхаан чиглэлийн хатуу хучилттай авто замд үзэгдэх орчин хязгаарлагдмал, эргэлтийн хэвгий авто зам төсөлөөх норм дүрмийн дагуу бус төлөвлөгдсөн нь хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхүйц болсонд хяналт шалгалт хийж холбогдох арга хэмжээ авсан байна.

Сүүлийн жилүүдэд хүн ам оршин ам олноор төвлөрөн суурьшиж зорчигч үйлчилгээний хүрээ тэлж, тээврийн үйлчилгээ эрхлэх байгууллага аж ахуйн нэгж ард иргэд олшрохтой уялдан гудамж замаар зорчих автотээврийн хэрэгслийн тоо жил бүр 7-10 хувиар өсөж хөдөлгөөний эрчим эрс нэмэгдэн уулзварууд болон замд бөглөрөл үүсэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахгүйд хүрэх боллоо. Нийслэл хотын нутаг дэвсгэр дэх авто зам, гүүрийн өнөөгийн байдалд хот төлөвлөлт, газар олголтын асуудлаас болж нилээд хүндрэл учраад байна.

Хотын барилга байгууламжуудын инженерийн шугам сүлжээний төлөвлөлт авто замын доогуур байдаг учир зам дээрхи дулаан, цэвэр бохир усны худгуудын таг цөмрөх, алдагдах зэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Авто замын аюулгүй байдлыг хангаж хэрэглэгчдийг осол аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлж байхын тулд цаашид авто замын салбарт шаардагдаж байгаа бодлогын чанартай хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг энд хэлье. Үүнд:

- Авто замын салбарт мөрдөгдөж байгаа БНБД, стандартыг өнөөгийн авто замын хөгжил, авто тээврийн хэрэгслийн эрчимжилтийн өсөлт, авто машины шинэчлэл, хурданд тохируулан шинэчилж боловсронгуй болгож гадаадын хөрөнгө оруулалтын шугамаар хэрэгжиж байгаа төслийн техникийн баримт бичиг, ААЗНТО, АЗТМ зэрэг стандартуудыг өөрийн орны нөхцөлд тохируулан шинэчлэн боловсруулж үндэсний стандарт болгох
- Авто замын зураг төслийг стандарт норм дүрмийн шаардлагад нийцүүлэн төлөвлөж байх, зураг төслийн экспертизийг газар дээр нь чанартай гүйцэтгэж байх
- Авто замын арчлалтыг тогтмолжуулж арчлалтын ажлыг чанартай гүйцэтгэж байх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

- Хот суурин газрын ерөнхий төлөвлөлтөнд авто тээврийн хэрэгслийн зогсоол, гарц, уулзвар, газар доорхи явган хүний нүхэн гарц зэргийг хот байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан тусгах зэрэг нь өнөөгийн хэрэгцээ шаардлага болоод байна.

5. Хөдөлмөрийн эрүүл ахуйн аюулгүй байдал:

Монгол улсад хүний эрхийг хангах нөхцөлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь иргэдэд хөдөлмөр эрхлэх нөхцөл боломж бий болгох, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт заавар журмыг төгс ойлгуулан, мөрдүүлж хэвшүүлэх явдал юм.

Иргэн хүнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрхийг хангахад хоногийн гуравны нэгээс илүү хугацааг зарцуулдаг ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчны нөхцөлийг сайжруулах асуудал бөгөөд энэ харилцааг манай байцаагчид хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох стандартын биелэлтэнд хяналт тавих замаар хэрэгжүүлж байна.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр 2004 онд 6085 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж, 22.2 мянган зөрчил илрүүлэн нийт зөрчлийн 81.6 хувийг арилгуулсан дүнтэй байна.

Улсын байцаагчид 2004 онд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ноцтой зөрчил гаргасан 9 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүр мөсөн, 59 аж ахуйн нэгж, байгууллагын, нэгжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, холбогдох арга хэмжээг авч ажиллажээ.

Ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах баталгааг сайжруулахын тулд хяналтын байгууллагын зүгээс үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулах чиглэлээр хяналт тавьж үр дүнг тооцон ажиллаж байна.

УМХГ-аас үйлдвэрлэлийн ослыг бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан 2004 оныг “Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх жил” болгон тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд 2004 онд 305 осол гарч үйлдвэрлэлийн ослын тоо 2003 оныхоос 20.0 хувь, осолд өртөгсөдийн тоо 16.3 хувиар тус тус буурсан юм.

Ажлын байрны сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс болж жил бүр мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөгсөдийн тоо 463-522 нэмэгдэж сүүлийн 5 жилд 2.3 мянган хүн шинээр мэргэжлийн өвчний онош тогтоолгон, ажлын нөхцөлөө өөрчилж, хөдөлмөрийн чадвараа 40-75 хувиар алдсан байна.

Мэргэжлээс шалтгаалах өвчин, уул уурхай, эрчим хүч, барилгын салбарын ажилтны дунд зонхилон тохиолдож нийт мэргэжлээс шалтгаалах өвчний 90 гаруй хувь нь эдгээр салбарт ноогдож байна.

Сүүлийн жилүүдэд дээрх салбарын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо эрс нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл нь стандартын шаардлага хангаагүй байгаа

нийтлэг зөрчил хяналт шалгалтаар илэрч байгаа нь цаашид энэ салбарт мэргэжлээс шалтгаалах өвчлөл нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

2005 онд Налайхад нүүрс олборлож байсан иргэдээс 16 хүн ослын улмаас нас барсны 9 нь агааргүй орчинд ажилласнаас, 5 нь нуралт үүссэнээс дарагдаж амь насаа алджээ.

Энэ бүхэн нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын наад захын шаардлагыг хангаагүйтэй холбоотой байна.

УМХГ-аас хөдөлмөрийн чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд нэн тэргүүнд “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-д даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, хамрагдах хүрээг өргөтгөх чиглэээр нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хурлаар шийдвэрлүүлж, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо хэмжээг бууруулж чадсан ажил олгогчийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгох асуудлыг дэмжиж байгаа юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хүний амьд явах эрхтэй холбоотой дээрх бүхий л асуудлыг шийдвэрлэх, хүний аюулгүй байдалд нөлөөлж буй эрсдэлийг бууруулах, багасгах, зөвшөөрөгдөх хэмжээнд нь барих, арилгахад мэргэжлийн хяналтын байгууллага бүхий л хүч бололцоогоо дайчлан ажиллаж цаашид орчин үеийн лабораторийн хүчин чадлыг бий болгож, мэргэшсэн боловсон хүчний тусламжтайгаар мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг Төрийн хяналт шалгалтын хуулинд заасан үүргийнхээ дагуу улс орны хэмжээнд хэрэгжүүлж байна.

Хүнс, эм, байгаль орчин, барилга, авто зам, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг нь манай хяналт шалгалтын үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд бид эдгээр чиглэлийн хяналт шалгалтыг нэгдсэн удирдамжтайгаар хамтран шалгаж ажлын уялдаа холбоог зохицуулж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилт тавин ажилладаг нь манай улсын мэргэжлийн хяналтын байгууллагын өнөөгийн бүтэц, зохион байгуулалтын нэг онцлог, амжилттай давуу тал билээ.

Бид Монгол улсын иргэд эрүүл, аюулгүй нийгэмд ажиллаж амьдарч, сурах, хөдөлмөрлөх эрхийг хангах үүднээс бүхий л талын байгууллагуудтай хамтран ажиллаж хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдалтай асуудал нь цаашид хүний амьд явах эрхийг тодорхой хэмжээгээр хохироож болзошгүй эрсдэл үүсгэж байггийг онцгой анхаарч, холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үнэлэх, арилгах талаар “Төрийн нүд чих болж” ажиллаж байдгийг та бүхэн мэдэх билээ.

Иймд Хүний эрхийг хамгаалах энэ чухал өдөр мэргэжлийн хяналтын байгууллагын илтгэлийг сонсохоор шийдсэн бид их талархаж байна. Илтгэлд дурьдагдсан тоо баримт, нөхцөл байдал бол улс орны хэмжээнд бидний хамтдаа шийдвэрлэх асуудал бөгөөд энэ талаар цаашид төрийн болон төрийн бус байгууллага ард иргэд хэрхэн хамтран ажиллах талаар чуулганаас гарах зөвлөмжид тодорхой санал, дүгнэлт гарна гэж найдаж байна.

АЮУЛГҮЙ СТАНДАРТУУД, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Ё.Баярмаа
Монголын Оюуны өмч
эзэмшигчдийн Академи,
ерөнхийлөгч

1992 оны Үндсэн хуульд Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, эрх зүйн этгээд байх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, хүний салшгүй эрхүүдийг баталгаажуулсан юм. Түүнчлэн Монгол улсын иргэн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, биет бус хөрөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шудрагаар олж авах, ажил мэргэжлээ эрх чөлөөтэй олж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэйг заасан билээ.

Монгол улсын Их Хурлаас 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т хүний хувийн эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх аж ахуй эрхлэх, хөдөлмөрлөх эрхийг хангах талаар тодорхой заасан байдаг.

Гэвч аюулгүй стандартуудын хэрэгжилтийн өнөөгийн байдал хүмүүсийн амьд явах, амьдрах, эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх зэрэг эрхийг хангахгүй байгааг үгүйсгэх аргагүй болоод байна.

Хүний эрхийг хангах гол стандартууд болсон хүнсний аюулгүйн стандартууд, эрүүл мэндийн аюулгүйн стандартууд, орчны аюулгүйн стандартууд, ариун цэврийн аюулгүйн стандартууд хангалтгүй байгаа талаар иргэд, аж ахуйн нэгжийн тулгамдсан асуудал болоод байна.

Ийм учраас бид суурь ач холбогдол бүхий хүнсний аюулгүйн стандартууд, эрүүл мэндийн аюулгүйн стандартууд, орчны аюулгүйн стандартууд, ариун цэврийн аюулгүйн стандартуудын өнөөгийн байдлыг судалж хүнийг эрсдлээс хамгаалах механизмыг бий болгож эхлэх шаардлагатай гэж үзлээ.

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэсний эцэст монголд хүний аюулгүй стандартыг хангаж чадахгүй байгаа дээрхи салбаруудын нөхцлийг тодорхойлсноор хүний эдийн засгийн эрхийг хангах, аж ахуйн нэгж, байгууллагуудыг зах зээлийн өрсөлдөөнд шудрагаар оролцож сургах, хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн хүргэдэг болгох зэрэг олон талын чухал ач холбогдолтой ирээдүйтэй ажил боллоо гэж үзэж байна.

Бид судалгааны ажлын дүгнэлтийг Монгол улсын Их Хурлаас батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжууд, 2001 оноос хойш олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн судалгааны ажил, төрийн бус байгууллагуудын дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдуулан хийсэн

судалгааны ажлууд, тус Академийн гишүүн салбарын эрдэмтэдийн боловсруулсан баталгаат технологийн зааврыг стандартын хамт, Монгол улсын стандартын каталоги зэргийг судалж гаргасан болно.

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж байгаа Монгол улсын Их Хурлаас 2003 оны 10 дугаар сарын 24-нд батлагдсан “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”-ийг хэлэлцэх чуулга уулзалт цаг үеэ олсон чухал арга хэмжээ болж байна.

Хүнийг эрсдлээс хамгаалах арга замын боловсруулж, холбогдох арга хамжээг авч хэрэгжүүлснээр төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор Монгол улсад Аюулгүйн стандартын хэрэгжилтийг хангаж, хүнийг эрсдлээс хамгаалах, хүний эрхийг хангах цогц механизм ажиллах юм.

Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас хүний эрхийн асуудлаар “Аюулгүйн стандартуудын хэрэгжилт” сэдэвт судалгааг бид:

- Хүнсний аюулгүйн стандарт,
- Орчны Аюулгүйн стандарт,
- Ариун цэврийн аюулгүйн стандарт,
- Эрүүл мэндийн аюулгүйн стандарт гэсэн ерөнхий бүтэцтэйгээр хийж гүйцэтгэлээ.

“Хүнсний аюулгүйн стандартын хэрэгжилт” судалгааны ажлыг 100 үйлдвэрлэл, 100 худалдаа, 100 хэрэглэгч дээр социологийн болон урьд өмнөх судалгааны ажлын үр дүнтэй харьцуулалтын аргыг хэрэглэн судалгааны ажлыг хийлээ. Судалгаанд нийт хамрагсдын 40.6% нь хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангахгүй байна 40.7% хагас дутуу, 11% нь мэдэхгүй гэж хариулсан нь хүн амын унд, хүнсний хэрэглээний аюулгүй байдлын талаар эрсдэл 94.3%-тай байна гэж үзжээ. “Орчны Аюулгүйн стандартын хэрэгжилт” судалгааны ажлыг социологийн аргыг хэрэглэж, барилгын ажиллагсад, оршин суугчид, авто зам тээврийн судалгаа гэсэн бүтэцтэйгээр авч хэрэгжүүлсэн бөгөөд эрсдэл 68.3%-тай байна гэж үзлээ.

“Ариун цэврийн аюулгүйн стандартын хэрэгжилт”-ийг нийт судалгааны ажлын асуулгад оруулан авсан бөгөөд нийт оролцогчдын үйлдвэрийн хог хаягдал 33%, ахуйн хог хаягдал 51.2%, эзэлж байна гэж үзээд хүний эрүүл эрсдэлгүй орчинд амьдрах нөхцөл хангагдахгүй байна гэж үзлээ.

“Эрүүл мэндийн аюулгүйн стандартын хэрэгжилт” судалгааны ажлыг эмийн худалдаа, хэрэглэгчийн судалгааны асуулгаар гаргахыг зорилоо.

Судалгаанд нийт оролцогчдын өвчлөлийг бууруулахад эмийн зохистой аюулгүйн хэрэглээний талаар асуулгад 68% нь мэдэхгүй гэсэн хариулт өгч байгаа нь эрсдлээс урьдчилан сэргийлэх, талаар мэдлэгийн түвшин хангалтгүй гэсэн үзүүлэлт харагдаж байлаа.

АЮУЛГҮЙН СТАНДАРТУУДЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүний эрүүл, аюулгүйн орчинд амьдарч, ажиллахаас эхэлдэг цогц эрхүүдийг хангахад:

- Төрийн бодлогын хийдэл,
- аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зөрчил,
- хувь хүний хариуцлагагүй үйл ажиллагаанаас болоод одоогийн байдлаар төрөөс аюулгүйн стандартуудын талаар баримталж байгаа бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

Тайлбарлал: Төрийн бодлогын хэрэгжилтийг хангах суурь стандартын нэгжүүд боловсруулагдаагүй байгаа нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ачаалал хэтэрснээс хаана юу хэрэгтэй байгаа түүнийг хэрхэн боловсруулах талаар иргэдээс ирэх мэдээлэл байхгүй, өдөр тутмын үйл ажиллагаанаасаа хэтрэхгүй байгаатай холбон тайлбарлахаас өөр аргагүй байна.

Одоогийн байдлаар боловсрогдоогүй байгаа гол гол стандартын нэгжүүдийг салбар чиглэлээр нь гаргавал. Үүнд:

Хүний амьдарч, ажиллах орчин болон үйлдвэрлэлийн холбогдолтой суурь стандартууд:

1. Хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээ стандартын нэгж байхгүй
2. Үйлдвэрлэлийг бүрдүүлэх үйл явц стандартын нэгж байхгүй,
3. Үйлдвэрийн үйл явцын хэмжилт ба хяналт стандартын нэгж байхгүй,
4. Үйлдвэрт зориулсан үйлчилгээ стандартын нэгж байхгүй,
5. Аж ахуйн нэгжид зориулсан үйлчилгээний стандартын нэгж байхгүй,
6. Үйлчилгээний нийтлэг асуудал стандартын нэгж байхгүй,
7. Үйлдвэр, худалдааны зориулалттай барилгын стандартын нэгж байхгүй,
8. Худалдааны тээврийн хэрэгслийн нийтлэг асуудал стандартын нэгж байхгүй,
9. Худалдааны бусад тээврийн хэрэгсэл стандартын нэгж байхгүй,
10. Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл стандартын нэгж байхгүй,
11. Түгээх ба худалдах машин стандартын нэгж байхгүй.
12. Автобус стандартын нэгж байхгүй,
13. Ахуйн аюулгүй байдал стандартын нэгж байхгүй,
14. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг стандартын нэгж байхгүй,
15. Бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт стандартын нэгж байхгүй,
16. Хаягдлын ерөнхий стандартын нэгж байхгүй,
17. Хатуу хаягдал стандартын нэгж байхгүй,
18. Шингэн хаягдал стандартын нэгж байхгүй,
19. Тусгай хаягдал стандартын нэгж байхгүй,
20. Хаягдлыг устгаж, боловсруулах тоног төхөөрөмж иж бүрдэл стандартын нэгж байхгүй байна.

21. Барилгын технологи стандартын нэгж байхгүй,
22. Газар хөдлөлт чичиргээний хамгаалалт стандартын нэгж байхгүй,
23. Гэмт халдлагаас хамгаалах стандартын нэгж байхгүй байгаа нь
24. Монгол улсын Үндсэн хуулинд заасан үндэсний баялагийг эх үүсвэр болсон оюуны хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн эрхийг хангах талаар баримтлах бодлого алдагдсантай шууд холбоотой юм.

Монгол улс Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Шинэ юм зохион олох ба оновчтой сайн санал гаргагчдыг урамшуулах” заавар батлан гаргаснаар Монгол оронд Патентийг эрх зүйн талаар хамгаалах, зохиогчийн бүтээлч сэтгэлгээг хөхиүлэн дэмжих ажлын эрх зүйн үндэс анх тавигдсан байна.

Хүмүүсийн оюуны бүтээлч ажиллагааны биежсэн хэлбэр - техникийн бүтээл зохиогчийн эрхийг хамгаалах, бүртгэж баталгаажуулах ажил оновчтой санал хэлбэрээр 1944 оноос эхэлсэн түүхтэй бөгөөд 1961 оны 1 сарын 1-нд анхны шинэ бүтээл зохиогчийн гэрчилгээг олгосноор Монгол улсад шинэ бүтээл оновчтой саналын улсын нэгдсэн бүртгэл эхэлжээ.

Энэ үеэс Монгол улсад техникийн бүтээлд зохиогчийн гэрчилгээ эсвэл патентийн гэрчилгээний аль нэгийг зохиогчийн хүсэлтийг үндэслэн олгож байхаар болжээ.

Патентийн ажлыг хөгжүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газар 1960 онд “Шинэ бүтээл оновчтой саналын дүрэм”, 1967 онд “Барааны тэмдэг барааны гарлын заалтын тухай дүрэм”, 1971 онд “Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дүрэм”, 1976 онд “Бүтээгдэхүүний загварын тухай дүрэм”-ийг хэрэгжүүлэх талаар заавар журам гаргаж Монгол улсад оюуны бүтээл түүний биежсэн хэлбэрүүд болох шинэ бүтээл бүтээгдэхүүний загвар, оновчтой санал гаргах, бараа үйлчилгээний тэмдгийг бүртгэх хөдөлгөөн эрчимжсэн байна.

Техник технологийн эдгээр бүтээлээс шинэ бүтээлийг бүтцийн хувьд авч үзвэл:

- Үйлдвэрлэлийн технологи - 60%
- Машин тоног төхөөрөмж - 19%
- Багаж хэрэгсэл техникийн эд анги - 15%
- Бусад 6% гэсэн чиглэлээр зохион бүтээгджээ.

Улсын бүртгэлд орсон эдгээр технологиуд нь үйлдвэрлэлд нэвтэрснээр хүн амын хэрэглээг хангаж, шинжлэх ухаан технологийн хөгжлөөр манай улс дэлхий дахинд ямар хэмжээнд явж байгааг илэрхийлэх толь болж байгаа билээ.

Оюуны бүтээл гэж шинжлэх ухааны дэвшилтэт арга зүйгээр урт удаан хугацааны судалгааны ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчин, хүн амд хор нөлөөгүй нь батлагдсан үйлдвэрлэлийн технологийн горимын баримт бичгийг, стандартын хамт хэлнэ.

Энэхүү баримт бичгийг боловсруулж оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрхийн болон патентийн гэрчилгээ авсан бүтээлийг зохиогчийн өмч гэнэ.

Эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээл нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэлэгдснээр биет бус хөрөнгө болно.

Одоо манай улсын өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын ашиглаж байгаа биет бус хөрөнгө нь:

- Төрийн өмчийн биет бус хөрөнгө
- Хувийн хэвшлийн биет бус хөрөнгө гэсэн бүтэцтэй байгаа билээ.

Биет бус хөрөнгийн ашиглалт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлэгдэж санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд тусгагдахгүй байгаагаас төрийн болон иргэний эдийн засгийн эрх зөрчигдөж байгаа нь аюулгүйн стандартын хэрэгжилтийг хангах механизмын цогц тогтолцоог бүрдүүлэхэд саад болж байна.

Иймд биет бус хөрөнгийн ашиглалтын бүртгэл тооллогын ажлыг хийсний үндсэн дээр төрийн болон иргэний биет бус хөрөнгийг хэрхэн ашиглах талаар дүрэм журам, заавар, аргачлалыг боловсруулж, Монгол улс дахь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагуудад дагаж мөрдүүлэх шаардлагатай байна.

Дээрхи ажлыг зохион байгуулснаар ажлын байрны стандартад хүний эрхийн орчныг тусгаж, эрсдэлгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд шудрагаар өрсөлдөснөөр нийгэм дэх аюулгүйн стандартын хэрэгжилтийг хангах хөрс бүрдэх юм.

Хүнийг эрсдлээс хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд өгөх дүгнэлт:

Хүнийг эрсдлээс хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагууд нь:

1. Төрийн байгууллагууд
2. Төрийн бус байгууллагууд гэсэн үндсэн хоёр бүтэцтэй байдаг.

Төрийн байгууллагууд:

Төрийн хяналтын зарим үйлчилгээний чиг үүрэг давхардаж байгаа нь хүнийг эрсдлээс хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд дүгнэлт өгөхөд саад учруулж байна. Үүнд:

Үндэслэл № 1

Монгол улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2.3-т зааснаар “Агентлагийн үйл ажиллагаа төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардахгүй байх” гэсэн заалт нь зөрчилдөж, Монгол улсын Засгийн газрын Тохируулагч агентлаг болох Улсын Мэргэжлийн Хяналтын Газрын байцаагчийн үйл ажиллагаа, Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг болох Оюуны өмчийн газрын байцаагчийн үйл ажиллагаа давхардснаас иргэний болон аж ахуйн нэгжийн эдийн засгийн эрх ахирах, төрийн хяналт шалгалтын талаар иргэд, аж ахуйн нэгж төөрөгдөлд оруулах, төрийн хяналт шалгалтын ажлын үр дүнг сулруулах, хариуцлагын тогтолцооны талаар нэгдсэн ойлголтгүй байх үндэслэл болж байна.

Жишээ нь: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Оюуны өмчийн газар нь патентийн гэрчилгээ олгох эрхтэй байдаг.

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийнхоо дагуу санхүүгийн баримтад бүртгэгдэх баталгаат технологи /биет бус хөрөнгө/, үндсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэлтэй холбогдох дүрэм журам зааврыг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу боловсруулан баталж мөрдүүлэх, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

Харин эдгээр бодлогын хэрэгжилтэд Засгийн газрын Тохируулагч агентлагийн Санхүүгийн болон салбарын хяналт шалгалтын хэлтэсүүд хяналт тавьж ажиллах үүрэгтэй байдаг.

Гэтэл Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар нь бодлого боловсруулагч байгууллага боловч тохируулагч агентлагийн үүргийг гүйцэтгэж улсын байцаагч ажиллуулж гэрчилгээ олголтонд хяналт тавьж байгаа нь Засгийн газрын Агентлагийн тухай Монгол улсын хуулийг зөрчиж, хяналт шалгалтын ажлыг давхардуулах, зөрчлийг арилгах арга хэмжээг төөрөгдүүлэх үндэс болж байна.

Үндэслэл №2

Бодлого боловсруулагч нар нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор хууль тогтоомж гаргасан хэдий ч хэрэгжүүлэхдээ нарийн мэргэжил шаардсан аж ахуйн үйл ажиллагаанд баталгаат технологи /биет бус хөрөнгөтэй/ холбоотой гол асуудлыг тусгалгүй шууд үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг олгожбайна.

Энэ байдал нь мөн л төрийн болон иргэний эдийн засгийн эрхийг зөрчиж, нарийн мэргэжил шаардах үйлдвэрлэлийн баталгаат технологийн нууцыг алдах, ажлын байрны стандартад хүний эрхийн орчны тусгахгүй байх, технологийг хулгайлах, эд хөрөнгө завших, олон нийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, стандартын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэгчийг хохироох үндэс болж байна. Жишээ нь:

Эмийн үйлдвэрлэл, согтууруулах ундааны үйлдвэрлэл, барилгын үйлдвэрлэл зэрэг бүх төрлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхэд олгодог “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл”-ийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд олгож байгаа асуудал нь хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг төрөөс баталгаажуулж байгаа асуудал юм.

Үндэслэл № 3

Улсын Мэргэжлийн Хяналтын Газар нь төрийн бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьж хүнийг эрсдэлээс хамгаалах механизмыг боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий байгууллага хэдий ч хяналт шалгалтын ажлын хариуцлагыг үндэслэлгүй тооцож иргэд, аж ахуйн нэгжийг хохироож байна.

Тайлбар: Улсын байцаагч нь эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд туссан лицензийн гэрээгээр ашиглаж байгаа баталгаат технологийн баримт бичигтэй танилцсны үндсэн дээр технологийн горим зөрчсөн эсэх, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн чухам юунаас болсон шалтгааныг тогтоож хариуцлага тооцох ёстой байдаг.

Төрийн үйлчилгээний давхардлаас болж улсын байцаагч нар хяналт шалгалтын ажлыг давхардуулах, иргэд, аж ахуйн нэгжид хариуцлага тооцож эдийн засгийн болон эд материалаар хохироох, авилгалыг арилгах, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах асуудлыг шгэцэлж чадахгүй байна.

Үндэслэл №4

“Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.2.4.-т заасан “Төрийн бус байгууллагыг дэмжиж, гэрээний үндсэн дээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, төр, засгийн нийтлэг үйлчилгээний өгөөж, хүртээмжийг сайжруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах талаар өнгөрсөн хугацаанд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэнгүй.

Дээрхи 3 /гурав/ жишээгээр үндэслэн хүнийг эрсдлээс хамгаалах төрийн байгууллагын үйл ажиллагаанд хангалтгүй гэсэн дүгнэлт өглөө.

Төрийн бус байгууллага:

Иргэд өөрсдийнхөө сонирхол санаачлагаар эвлэлдэн нэгдэж эрх, эрх чөлөө, эрх ашиг, ашиг сонирхлоо хамгаалах, хамгаалуулахаар соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллагыг байгуулах, нэгдэн орох зэргээр эрхээ эдлэх болон төлөөлөн хамгаалагч нараар дамжуулан төртэй харьцаж байдаг.

Хүний эрхийг хангах талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэхэд иргэнд хамгийн ойр байж тэднийг аливаа мэдээ, мэдээлэлээр хангах, бодлогын хэрэгжилтийн талаар бодит судалгааг гаргаж ирэх байгууллага нь төрийн бус байгууллага байдаг юм.

Монгол улсад албан ёсны бүртгэлтэй 4000 орчим төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна гэсэн статистик тоо байдаг нь энэ үзүүлэлтээр бол төрөөс хүний эрхийг асуудлаар баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг төрийн бус байгууллагууд иргэндтэй хамгийн ойр, тэдний дунд байж хангах бүрэн үндэстэй гэж үзэж болно.

Хүний эрхийг хангах талаар төрийн бус байгууллагууд:

1. Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд үйл ажиллагааныхаа чиглэлээр нэгдээгүй.
2. Хүнийг эрсдлээс хамгаалах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар төрийн бус байгууллагын нэгдсэн бодлого байхгүй.

3. Хүнийг эрсдлээс хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох нөлөөллийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхгүй байна.
4. Төрөөс, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих бодлого хангалтгүй байгаагаас тэдний дүрмийн зорилгоо хэрэгжүүлэх бодит боломж маш хязгаарлагдмал хууль, хуулийн төсөл боловсруулах, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх чадвар муутай хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн бодитоор гарахгүй байна.

Хүнийг эрсдлээс хамгаалах асуудлаарх төрийн бус байгууллагын үйл ажиллагааны дүгнэлтийг Оюуны өмч эзэмшигчдийн академи нь Засгийн газрын “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги”-ийн Бодит салбарын бодлогын зөвлөлийн төрийн бус байгууллагын төлөөллийн хувьд өөрсдийн өмнө тулгарч байгаа бэрхшээлээс үндэслэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэсэн болно.

Дээрхи үндэслэлээр төрийн бус байгууллагуудын гол зарчим болсон хүнийг эрсдлээс хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд хангалтгүй гэсэн дүгнэлт өглөө.

ЭРСДЛИЙГ АРИЛГАЖ, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АРГА ЗАМ

Монгол улсад хүнийг эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулах, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байрны стандартад хүний эрхийн орчныг тусгах, хүний эрхийг хангах арга замыг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа.

1. Хүнийг эрсдлээс хамгаалах төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг зохицуулж төрийн бодлогын хэрэгжилтийн хийдлийг арилгах.
2. Хүний эдийн засгийн эрхийг хангаснаар аж ахуйн нэгж байгууллагыг зах зээлийн өрсөлдөөнд шудрагаар оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлж хэрэглэгчийг эрсдлээс хамгаалах хяналт шалгалтын механизмыг боловсронгуй болгох.
3. Хүний эрхийг хангах талаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих төрийн бодлогыг боловсруулах.
4. Хүний эрхийг хангах асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд үйл ажиллагааныхаа чиглэлээр нэгдсэн зохион байгуулалтад орох.
5. Хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын стратегийн баримт бичгийг боловсруулах.
6. Хүнийг эрсдлээс хамгаалах төрийн үйлчилгээний байгууллагуудын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлснээр төрийн ачааллыг багасгаж, ил тод байдлыг хангах.
7. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэх чиглэлээр үндэсний стандартыг боловсруулах, эрсдлийг арилгах механизмыг бүрдүүлэхэд хувь нэмрээ

оруулахаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн бодлого болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

8. Төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаагаар иргэний төрөө дээдлэх, үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэн хөгжүүлснээр иргэн бүрийн хувийн идэвхи, хариуцлагын тогтолцоог бий болгох.

ЭРСДЛИЙГ АРИЛГАХАД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Технологийн горимд заасан хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны нөхцлийг хангаж ажлын байрны стандартад хүний эрхийн орчныг тусгаж хэрэгжүүлдэг болгох.
2. Зах зээлд өрсөлдөж байгаа нэрийн бүтээгдэхүүний талаарх үнэн зөв баталгаат мэдээллийг холбогдох байгууллагуудаар батлагдсан нөхцөлд зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэдэг болгох.
3. Үл хөдлөх хөрөнгө болон нэрийн бүтээгдэхүүний гэрээ, сав баглаа боодлын шошго тэмдгэнд хэрэглэгчид хүрвэл зохих чанарын мэдээллийн стандартыг боловсруулж нийт аж ахуйн нэгжүүдэд мөрдүүлэх,
4. ОНРТ зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
5. Төрийн болон хувийн хэвшлийн баталгаат технологи /үнэлэгдсэн биет бус хөрөнгө/-ийн ашиглалтын бүртгэл, тооллогын ажлыг явуулах.
6. Төрийн болон хувийн хэвшлийн биет бус хөрөнгө ашиглалтын бүртгэл тооллогын ажлыг гүйцэтгэснээр хүний эдийн засгийн эрхийг хангах, хэрэглэгчдийг эрсдлээс хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах.
7. Хүний эдийн засгийн эрхийг хангах эрх зүйн үндэс болсон биет бус хөрөнгө /баталгаат технологи/-ийг санхүүгийн баримтад бүртгэж, тайлан тэнцэлд тусгах ажлыг зохион байгуулах.
8. Улсын Мэргэжлийн Хяналтын газар нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлэгдсэн, санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд туссан, худалдаж авсан болон лицензийн гэрээгээр ашиглаж байгаа баталгаат технологийн заавартай танилцсны үндсэн дээр стандартын шаардлага, технологийн горим зөрчсөн шалтгааныг тогтоож хариуцлага тооцдог болох.
9. Сургалт, сурталчилгааны ажлаа эрэмбэ дараатайгаар явуулж нийгэмд цэгцтэй ойголт өгөх аюулгүй стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ АЖЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмжийг хэрэгжүүлэх бүтэц:

- 1) Төрийн байгууллагад зориулсан зөвлөмж
- 2) Төрийн бус байгууллагад зориулсан зөвлөмж
- 3) Иргэдэд зориулсан зөвлөмж

Төрийн байгууллага:

- 1) Оюуны хөдөлмөрийн нийгэм, эдийн засгийн үнэлэмжийг дээшлүүлэх, төрийн болон хүний эдийн засгийн эрхийг хангах, аж ахуйн нэгж байгууллагыг эдийн засгийн эрх зүйн үндсэн дээр зах зээлийн шудрага бус өрсөлдөөнөөс хамгаалах, хэрэглэгчийг эрсдлээс хамгаалах талаар цогц бодлогыг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлэх.
- 2) Эрсдлийг арилгах, хүний эрхийг хамгаалах, төрийн нийтлэг үйлчилгээний ачааллыг хөнгөвчлөх талаар төрийн бус байгууллагуудын нэгдлээс ирсэн санал хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэдэг болох механизмыг бүрдүүлэх.
- 3) Төрийн хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн болон хүний эдийн засгийн эрх, биет бус хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг механизмыг бүрдүүлэх.
- 4) Оюуны хөдөлмөрийн нийгэм, эдийн засгийн үнэлэмжийг дээшлүүлэх, төрийн болон хүний эдийн засгийн эрхийг хангах, аж ахуйн нэгж байгууллагыг эдийн засгийн эрх зүйн үндсэн дээр зах зээлийн шудрага бус өрсөлдөөнөөс хамгаалах, хэрэглэгчийг эрсдлээс хамгаалах эрх зүйн үндэс болсон биет бус хөрөнгийн ашиглалтын бүртгэл тооллогын ажлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.
- 5) Тооллогын ажлыг зохион байгуулж төр болон иргэний биет бус хөрөнгийг хуулийн дагуу өмчлөх, эзэмших, төлбөртэй ашиглуулах эрх зүйн нөхцлийг бүрдүүлж, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах.
- 6) Өмч хувьчлалын бодлогод биет бус хөрөнгийн талаар тусгах.

Төрийн бус байгууллага:

- 1) Оюуны хөдөлмөрийн нийгэм, эдийн засгийн үнэлэмжийг дээшлүүлэх, төрийн болон хүний эдийн засгийн эрхийг хангах, аж ахуйн нэгж байгууллагыг эдийн засгийн эрх зүйн үндсэн дээр зах зээлийн шудрага бус өрсөлдөөнөөс хамгаалах, хэрэглэгчийг эрсдлээс хамгаалах, төрийн үйлчилгээний ачааллыг хөнгөвчлөх талаар үйл ажиллагааныхаа чиглэлээр төрийн бус байгууллагууд нь нэгдсэн зохион байгуулалтад орж төлөөллөөрөө дамжуулан төртэй хамтран ажиллах.
- 2) Оюуны хөдөлмөрийн нийгэм, эдийн засгийн үнэлэмжийг дээшлүүлэх, төрийн болон хүний эдийн засгийн эрхийг хангах, аж ахуйн нэгж байгууллагыг эдийн засгийн эрх зүйн үндсэн дээр зах зээлийн шудрага бус өрсөлдөөнөөс хамгаалах, хэрэглэгчийг эрсдлээс хамгаалах эрх зүйн үндэс болсон биет бус хөрөнгийн ашиглалтын бүртгэл тооллогын ажлыг мэргэжлийн төрийн бус байгууллага гүйцэтгэж салбар тус бүрээр төрийн өмчийн биет бус хөрөнгийг үнэлж хүлээлгэн өгөснөөр эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах.

- 3) Тооллогын ажлыг зохион байгуулж төр болон иргэний биет бус хөрөнгийг хуулийн дагуу өмчлөх, эзэмших, төлбөртэй ашиглуулах эрх зүйн нөхцлийг бүрдүүлж төрийн ачааллыг багасгах.
- 4) Төрийн болон хүний эдийн засгийн эрх, биет бус хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага нь, төрийн хяналт шалгалтын байгууллагатай хамтран ажилласнаар хариуцлагын тогтолцоо үнэн бодитой, ил тод болж төрийн болон хүний эдийн засгийн эрх хамгаалагдана.
- 5) Хойч үеийг оюуны хөдөлмөр эрхлэлт, шинжлэх ухааны ололт амжилтад тэмүүлэх эрмэлзлэлийг хөгжүүлэх талаар сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагуудын уриа болгож дүрмийн зорилгын үндсэн хэсэг болгож хэрэгжүүлэх.

Иргэн:

- 1) Тооллогын ажлыг зохион байгуулснаар иргэн нь биет бус хөрөнгөө хуулийн дагуу захиран зарцуулах, төлбөртэй ашиглуулах эрх зүйн нөхцөл бүрдэж эдийн засгийн эрх нь хангагдана.
- 2) Эдийн засгийн эрх нь хангагдснаар нийгмийн тодорхой бүлгийн ядуурал буурна.

ХОТ СУУРИН ГАЗРЫН ИРГЭДИЙГ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ НЬ СЭДЭВТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОЙМ

Ч. Тамир
Судалгааны багийн ахлагч,
МУИС-ийн Социологийн
тэнхмийн багш

НЭГ. МОНГОЛ ДАХЬ ГЭМТ ХАЛДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Улаанбаатар хот нь хүмүүсийн шилжин ирэх хөдөлгөөний сүүлийн цэг болдог тул хүн амын төвлөрөл бусад хот суурингаас харьцангуй их, гэмт явдал ихээхэн гардаг газар гэдгийг статистик ба социологийн судалгаанаас харагдаж байна.

Гэмт хэргийн төрөл хэлбэр, тархалт, хувь хэмжээг ийнхүү үнэлүүлэхдээ “Орон нутагт аль төрлийн гэмт халдлагад хүмүүс хамгийн их өртдөг вэ?” гэсэн асуултад хариулт авсан юм. Эл асуултанд олон нийтийн зүгээс хэрхэн хариулсан дүнг статистиктай уялдуулан харахын тулд асуулгад орсон гэмт халдлагуудын тодорхой тохиолдлуудыг бүлэглэн дараах байдлаар харж болно.

Дугаар	Гэмт хэргийн төрөл	Тоо	Хувь
1	Хулгай	503	25.4
2	Дээрлэл	488	24.1
3	Хэргийн гэмт халдлага	389	19.3
4	Хэрэгсэл	273	13.5
5	Тамсаг	260	12.9
6	Гэр бүлийн гэрээг үл мэдэгдэх	179	8.9
7	Огноо, амьдрал	168	8.3
8	Хүчин	127	6.3
9	Хэргийн гэмт халдлага	88	4.3
10	Хулгай	77	3.8
Хэрэгсэлгүй гэмт халдлага		2200	100%

Эндээс харахад иргэдийн дунд хулгай, дээрэм, залилангийн гэмт хэрэг хамгийн их гардаг байна. Түүнчлэн нэлээд хүндэтэр хэргүүд ч ихээхэн гардаг гэж иргэд үзсэнийг дээрх хүснэгтээс харж болох юм.

Бид судалгааны асуулгад гэмт халдлагын тархалт, хэлбэрийг гаргах зорилгоор гэмт халдлагын ямар тохиолдлуудад хувь хүн болон түүний хүрээлэн буй хүмүүс өртөж байгаа талаар нээлттэй асуусан. Өөрөөр хэлбэл хулгайн гэмт хэрэгт мөнгө эд зүйлээ сүйлуулах, гэр орон ажлын байраа ухуулах зэрэг, харин ИЭЧЭМ-ийн эсрэг гэмт хэрэгт бие махбодид халдах, гэмтээх, хэл амаар доромжлох гэх зэрэг гэмт халдлагын тохиолдлуудыг багтаасан болно.

Өнөөдөр иргэдэд хамгийн бодитой тулгарч байгаа аюул бол хулгайн болон дээрмийн гэмт халдлагын төрөл юм. Тухайлбал судалгаанд оролцсон иргэд, хувь хүмүүсийн дунд сүүлийн нэг жилд хулгай, дээрэм, залилан зэрэг гэмт халдлагад өртөж байсан 40 тохиолдол байгаа бөгөөд эдгээрийг нарийвчлан авч үзвэл, хулгайд эд зүйлсээ алдсан(15), дээрэмдүүлсэн(10), эд юмсаа булаалгасан(6), зодуулсан(6), залилуулсан(2) тус тус байна.

Харин судалгаанд оролцогчдын гэр бүлийн хэн нэг нь гэмт халдлагад өртсөн 30 тохиолдол байгаа бөгөөд эдгээрээс хамгийн их давтамжтай төрөл хэлбэрүүд нь гэвэл дээрэм(16), хулгай(12), танхайрал(10) зэрэг бөгөөд эдгээрийн зэрэгцээ залилан, автын осол, хүчингийн хэргүүд мөн мэр сэр гардаг байна.

Гэмт халдлагад өртсөн иргэдийн хувьд 50 хувь нь гэмт халдлага үйлдэгчид бүлгээрээ байсан гэж хариулсан нь илүү зохион байгуулалтын шинжтэй болсныг харуулж байна. Гэмт халдлагыг бүлгийн шинжтэй болсон гэвэл та хүлээн зөвшөөрөх үү гэсэн асуултанд иргэдийн 63.4 хувь нь тийм гэж хариулжээ. Гэмт халдлагад өртсөн иргэдийн хувьд 24 хувь нь нэгээс дээш удаа гэмт халдлагад өртсөн байгаа нь гэмт халдлагын хор хөнөөл хичнээн их ужигарч байгааг харуулах тоо баримт мөн ажээ. Нийт гэмт халдлагын 55.7 хувь нь гудамж талбайд болдог, 35 хувь нь бар цэнгээний газар болдог гэж үзсэн нь цагдаагийн байгууллагаас гаргасан судалгаанаас ялгаатай байгаа юм. Нийт судалгаанд оролцогчдын 5 хувь нь гэмт хэрэг мафийн зохион байгуулалтанд орсон гэж үнэлсэн. Гэмт хэрэгт ихэвчлэн залуучууд өртөж, залуучууд үйлдэх хандлагатай байна.

Статистик судалгааны дүнгээс үзэхэд нийслэл хотод гэмт хэргийн төрөл, ангиллын хувьд хулгай үйлдэгдсэн бүх гэмт хэрэгт нилээд өндөр хувийг эзэлсээр иржээ.


Гэвч энэ төрлийн гэмт хэрэг нь нийслэл хотын хувьд зонхилон үйлдэгдэж байгаа бөгөөд түүнтэй тэмцэх тусгайлсан арга хэмжээг шаардаж байна. Гэмт хэргийн талаарх олон нийтийн үнэлгээнээс харахад ч дээрх нь батлагдсан юм.

Судалгаанд оролцогчдын харьцангуй олонхи нь буюу 26.9% нь орон нутагт хулгайн гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг гэж хариулсан болно. Үүнийг нарийвчлан авч үзвэл мөнгө эд зүйлсээ гудамж талбайд хулгайд алддаг гэж 9 орчим хувь нь, гэр орон, ажлын байрнаас хулгайд алддаг гэж 18 хувь нь тус тус хариулжээ.

Орон нутгийн хувьд ажилгүйдэл, амжиргааны түвшин дорой байдал нь гэмт хэрэг зөрчил гарах үндсэн шалтгааны нэг болох нь олон эх сурвалжаас харагдаж байгаа юм.

Статистик тоо баримтанд тулгуурлан гэмт хэргийн нийт холбогдогч болон эрхэлсэн ажилгүй, сургуулийн харьяалалгүй хүмүүс хоорондын харьцааг харж болно.

Гэмт хэрэгт холбогдогчийн ажил эрхлэлтийн түвшин



Сүүлийн 4 жилийн байдлаас харахад гэмт хэрэгт холбогдогчдын 64-80 орчим хувь нь эрхэлсэн ажил сургуульгүй байжээ.

Гэхдээ энд нэг зүйлийг тэмдэглэхэд албан ёсны статистикаар нийт гэмт хэргийн тоо буурсаар ирсэн байхад, харин нийт гэмт хэрэгт холбогдогчдын дунд ажил сургуульгүй хүмүүсийн эзлэх хувь 5 жилийн өмнөхөөс өссөн байна. Энэ нь нэг талаас орон нутгийн ажилгүйдэл гэмт хэрэг үйлдэх шалтгаан болж буйг нөгөө талаас орон нутагт гэмт хэрэг үйлдэх магадлалтай, ажил сургуульгүй хүмүүсийн тогтвортой бүлэг бий болсныг харуулж байна. Эдгээр хүмүүс нь бусад хүмүүсийн адил амьдрал ахуйгаа авч явах боломж нэн хомс тул орон нутгийн эрүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлэх, гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр юм.

Хүмүүс ажилгүй, ядуурлын нөхцөл байдалд байгаа нь тэдний зүгээс боловсролын түвшин доогуур, мэргэжил эзэмшээгүй зэрэг хүчин зүйлтэй холбоотой. Гэмт хэрэгт холбогдогчдын талаарх судалгаагаар хүмүүс гэмт хэрэг үйлдэх нь бас тэдний боловсролын түвшинтэй шууд холбоотой нь харагдаж байна. Орон нутаг дахь ажилгүйдэл, ядуурал нь тэр хэрээр архидан согтуурах явдал даамжрах үндэс бөгөөд энэ нь ч гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлөх томоохон хүчин зүйл мөн юм.

Сүүлийн 5 жилийн гэмт хэрэгт холбогдогчдын судалгаагаар авч үзвэл нийт хэргийн 25-30% нь согтуугаар үйлдэгджээ. Тухайлбал, энэ оны эхний 7 сарын байдлаар 221 гэмт хэрэг бүртгэгдэж байхад 3 үйлдэл тутмын нэг нь согтуугаар хийгдэж байна.

Юуны өмнө гэмт хэргийн гаралт ерөнхий жингээрээ буурсан боловч, эрүүгийн нөхцөл байдал харьцангуй хүндэрч, гэмт хэргийн тодорхой төрлүүд давтагдан бүлгээр үйлдэгдэх нь ихээхэн түгээмэл боллоо. Мөн гэмт халдлага бүлгийн шинжтэй, зохион байгуулалттай болж байна. Орон нутагт зонхилон тохиолдох хулгайн гэмт хэрэгт мөн бууралт ажиглагдаж байна. Гэхдээ гэмт

хэргийн эл төрөл нь орон нутгийн тодорхой нутаг дэвсгэрийн онцлогтой холбоотой үйлдэгдэж байна. Харин ИЭЧЭМ-ийн эсрэг гэмт хэргийн гаралт өссөн бөгөөд энэ нь иргэдийн эрх зүйн ухамсар хандлага өөрчлөгдсөнтэй холбоотой байна. Иргэд аль нэг зөрчлийн дагуу хууль шүүхийн байгууллагад хандах нь нэмэгдсэнтэй ч энэ нь холбоотой. Юуны өмнө орон нутагт хорих байгууллага удаан байршсан болон ял эдэлж байсан хүмүүс тэнд олноороо суурьшиж ирсэн нь тухайн орон нутагт хүнд гэмт хэрэг гарахад ихээхэн нөлөөлж байна. Энэ үйл явц цаашид үргэлжлэх магадлалтай. Орон нутгийн архины хэрэглээний түвшин нэн өндөр байна. Энэ нь санамсаргүй гэмт хэргийн төрлийг ихээхэн нэмэгдүүлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон нутгийн тогтолцоо, дархлааг бий болгох, энэхүү ажилд олон нийт, аж ахуйн нэгж, төрийн болон төсөвт байгууллагын хувь нэмэр, оролцоог өнөөгийн байдалд үндэслэн тодорхойлох хэрэгтэй байна. Мөн гэмт хэрэгт өртөмтгий болон өртөх магадлал өндөр бүлгүүдийн нарийвчилсан судалгааг яаралтай гаргах, ингэхдээ судалгаанд олон нийтийг татан оролцуулах шаардлагатай юм. Дээрх бүлгүүдийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд тулгуурлан явуулах, энэ үйл ажиллагаанд иргэний нийгэм, ТББ-ын дэмжлэгийг авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг ТББ, олон улсын байгууллагаар тогтмол гүйцэтгүүлэх, нэн ялангуяа эмзэг бүлгийнхний хүрээнд хийх, хорих ял эдэлж байгаа хүмүүс болон нутгийн иргэдийн хоорондын харилцаанд хяналт тавих, гэмт зан үйлийн халдвараас өсвөр үе, залуучуудыг хамгаалах, хорих байгууллагаас суллагдан орон нутагт үлдсэн болон үлдэхээр шийдсэн хүмүүсийг нийгмийн амьдралд оролцоход нь туслах, нийгмийн болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, тэдэнтэй байнга холбоотой ажиллах, гэмт хэрэгтэй тэмцэх ажил амжилттай явагдах нэг үндэс бол архидалтын эсрэг орон нутаг цогц байнгын арга хэмжээ авах цаг болжээ.

ХОЁР. ГЭМТ ХАЛДЛАГЫН ШАЛТГААН НӨХЦЛИЙН ТУХАЙ

А. Нийгмийн шалтгаан

Шалтгааны төрлийн үндэстэй	Далдлага	Тоо
Ахмадтай	386	38.9
Мэргэж	296	29.5
Малчдадтай	290	28.9
Эх сурвалжгүй, гурвалжинбайрлалтай	110	10.9
Төрийн газар, өмчлөх, амьдралын тус	70	6.9
Мэргэжлээрх өмчлөл	60	5.9
Гэр бүлгүйнхэндээ, өмчлөх тус	20	1.9
Тус бус өмчлөл	20	1.9
Бусад	1	0.1
Удвал	1177	116.8

Архидалт

Гэмт явдлын шалтгаан болж буй нийгмийн хүчин зүйлүүдээс хамгийн их жин дарж байгаа нь архидалт байна. Архидалт нь нийгмийн гаж үзэгдлийнхээ хувьд гэмт хэрэгтэй хамгийн ойр холбоотой сүлбээтэй оршдог, хамгийн их хамааралтай болох нь харагдсан юм. Өөрөөр хэлбэл судалгааны явцад гэмт хэрэг нийгмийн бусад гаж үзэгдлүүдтэй хамаарах хамаарлын талаар асуухад судалгаанд оролцогчдын 82.9 хувь нь архидалт гэмт хэрэг онцгой хамааралтай гэсэн хариулт өгчээ.

	Өмнөд хэсэгээрэй	Хажуугаарэй	Төвийн хэсэгээрэй	Ахуйн	Бусад
Архидалт	82.9%	13.8%	1.1%	1.2%	100.0%

Нөгөө талаас гэмт хэргийн гаралтад архидалт хэр зэрэг нөлөөлж байна гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 88.5 хувь нь ихээхэн нөлөөлж байна гэснээс тодорхой харагдаж байна.

Гэр бүл ба гэр бүлийн харилцаан дахь сөрөг үзэгдлүүд

Гэр бүл бол нийгмийн тогтвортой байдлыг хадгалагч, хөгжил дэвшлийн суурь институт гэж үзэх тул өнөөгийн манайд тохиож буй гэмт явдлын түвшин, хэр хэмжээ нь дээрх институцийн хүрээн дэх гаж хийгээд сөрөг үзэгдлүүдтэй ихээхэн хамааралтай байгаа юм. Монголын гэр бүлийн амьдрал олон хүндрэл бэрхшээл тохиолдсоны дээр түүний хэвийн хөгжил, сайн сайхан байдалд сэв суулгаж ирлээ. Өнөөгийн манай нийгэмд гарч буй гэмт явдалд гэр бүлийн зүгээс нөлөөлж байна гэж доорх байдлаар судалгаанд оролцогчдын зүгээс хариулсан байна.

	Ихэвчнээр	Дунд зэргээр	Хэвчнээр	Ахуйн	Бусад
Гэр бүлийн тогтворгүй байдал, саяалт	43.7%	37.9%	8.6%	10.5%	100.0%
Гэр бүлийн харилцаанд сөрөг үзэгдэл	36.9%	47.9%	7.9%	7.3%	100.0%

Харин гэр бүлийн хүрээн дэх хүчин зүйлүүдийг нарийвчлан үзэх үүднээс гэмт хэрэг үйдсэний улмаас ямар нэг шийтгэл авсан тохиолдлуудаас уламжлан тандсан болно. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдоос тэдний гэр бүл, ойр дотны хүмүүсээс шүүхэр шийтгэгдсэн хүн байгаа гэж 10 гаруй хувь нь хариулсан бөгөөд тэдгээр нь тухайн тохиолдолд гэр бүлийн зүгээс гэмт хэрэг үйдэхэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг үнэлсэн билээ.

	Далбаа	Үүн
Гэр бүлийнхүү эрэг-болов	43	34.7
Гэр бүлийнхүү эхнэр, эгэлт эрэг	48	38.6
Гэр бүлийнхүү эхнэр, эгэлт эхнэр, эгэлт эхнэр	27	21.3
Гэр бүлийнхүү, эгэлт эхнэр	18	14.3
Гэр бүлгүй	18	14.3
Гэр бүлийнхүү эгэлт эхнэр	8	6.4
Бусад	28	22.3
Нийт	174	138.6

Өнөөгийн улс орны эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй байдал нь ихэнхи өрх гэрүүдийн ахуй амжиргаанд хүндээр тусч тэдний зүгээс амин зуулгаа хангах түвшин, боломжыг маш доогуур түвшинд аваачсантай холбоотой, энэ нь тэдний гишүүдээс гэмт явдалд татагдан ороход нөлөөлдөг бизээ. Энэ хугацаанд гэр бүлийн харилцааны хүрээнд ихээхэн сөрөг үзэгдлүүд бий болж зарим хүний үзсэнчлэн гэр бүлийн эвдрэл бий болсон байна. Хүний амьдралын хамгийн ойр дотно, нандин орчны харилцаа сэтгэцтэй тухайлбал, гэр бүлийн хараа хяналт алдагдах, зөрчил давамгайлах, хайр халамж дутагдах, уламжлал, сургааль үлгэргүй болох цаашилбал салж сарнихтай холбоотойгоор хүмүүс гэмт хэргийн ертөнц рүү хөл тавьсаар байна.

Ёс суртахуун, хувь хүний хүмүүжил, нийгэмшил

Тоон болон чанарын судалгааны дүнгээс үзэхэд өнөөдөр гэмт явдлын шалтгаанд нийгмийн ёс суртахууны харилцааны уналт, доголдол онцгой байр суурь эзлэх нь тодорхой байна. Нийгэм бүхэлдээ ёс суртахуун, хүмүүжлийн харилцааны гажуудалтай болж, энэ нь ихээхэн анхаарах асуудал болжээ. Нийгмийн ёс суртахуун гэхээр хийсвэр ойлголт хэмээн хойш тавихаа больж, хүмүүсийг гэгээрүүлэх, хүмүүжүүлэх, хүмүүнжүүлэх тал дээр тогтолцооны

Гэмт хэргийн үйлдэл, үйлдвэрлэл, гэмт хэргийн үйлдэл	Далбаа	Үүн
Архи үүн болон бусад бусад зориулалт	46	36.1
Эл сурталзүйн ашигласан	25	19.6
Төлөөлөл, бүтээгдэхүүн	28	21.7
Таруулахгүй болгохгүй үйлдэл	26	20.1
Ажил төрөлгүй байдал	25	19.6
Амьдралын зориулалт, хэргийн байдал	21	16.6
Төлөөлөл, бусад байдал	17	13.3
Бусад	3	2.3
Нийт	198	154.1

хэмжээнд анхаарах хэрэгтэй байна. Мөн түүнчлэн гэмт явдлын шалтгааны талаар ихэнхидээ ерөнхий, нийгэм эдийн засгийн, тогтолцооны шинжтэй зүйлсийн талаар ярьж байдаг уламжлалаас татгалзах хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Эцсийн эцэст нийгэм хувь хүмүүс дээр тогтох тул гэмт хэргийн шалтгаанд хувь хүний ёс суртахуун, сэтгэл зүйн дотоод учир шалтгаан руу өнгийх хэрэгтэй байгаа юм.

Хүн амын төвлөрөл, хотжилт

Гэмт явдалд нөлөөлөх хүчин зүйлүүдэд хотжилт, хүн амын төвлөрлийн байдал улам өсөн нэмэгдэх хандлагатай болжээ. Судлаачдын үздэгчлэн хүн амын төвлөрөл нь хүмүүсийн биеэ авч явах байдал, сэдэлд шууд нөлөөлдөггүй ч дам болон механик нөлөө үзүүлдэг. Өнөөдөр манайд бий болсон нөхцлөөс үзэхэд гэмт хэрэгтнүүдийн бөөгнөрөл, гэмт зан үйлийн халдварлал, холбогдох байгууллагын хяналт алдагдах, хүн хүч, техник хэрэгсэл, хүчин чадал хүрэлцэхгүй байх, үйлчилгээ хүн амын ачааллыг дийлэхгүй байх, бүртгэлгүй иргэд олшрох болон бусад байдлаар гэмт хэргийг өсгөн хөөрөгдөж байна. Хүн амын бараг тал орчим хувь нь оршин байгаа нийслэл хот нь энэ утгаараа хүмүүсийн бөөгнөрөлөөр нөхцөлдсөн гэмт явдлын томоохон бүс болох магадлалтай болжээ.

Б. Эдийн засгийн шалтгаан

	Мэргэжлийн хөдөлмөр	Дүн зуураг	Нөхцөл	Хөдөлмөр	Нийт
Эдийн засаг	85.2%	11.0%	0.4%	1.5%	100.0%
Хөдөлмөрийн	77.8%	19.0%	0.0%	1.5%	100.0%
Эдийн засаг, хөдөлмөр	32.4%	57.4%	20.0%	9.5%	100.0%

Шилжилтийн үеэс манай нийгэмд гарч буй гэмт хэргийн хамгийн нөлөөтэй шалтгаануудын нэг бол ядуурал, ажилгүйдэл гэх мэт эдийн засгийн суурь хүчин зүйлсээр сөрөг үзэгдлүүд юм. Хэдийгээр судлаачдын дунд ядуурал, ажилгүйдэл зөвхөн эдийн засгийн шинжтэй бус гэх тухайлбал оюуны, нийгмийн ядуурал, үнэ хүндийн, хүн амзүйн болон орон нутгийн ажилгүйдэл зэргийн талаар их яригдах болжээ. Үнэхээр дан ганц эдийн засгийн асуулгатай байдаггүй нь үнэн боловч өнөөгийн манай улсын хөгжлийн бодит түвшин, нийгмийн нөхцөл байдал, онцлогоос хамаарч гэмт явдлын бодит шалтгаан болох хувьдаа эдийн засгийн агуулга нь давамгайлж байна. Ажилгүйдэл, ядуурал нь нийгэмд хамгийн их тархсан нийтлэг тогтолцооны шинжтэй байгаа нь манай улсад тулгарч байгаа эдийн засгийн хүндрэл бэрхшээлээр нөхцөлдөж байна.

В. Эрх зүйн буюу хуулийн зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой хүчин зүйл

Өнөөгийн нийгэмд бий болсон гэмт явдлын нэг онцлог нь эрх зүйн хүчин зүйлээр нөхцөлдөж байгаа нь харагдаж байна. Өнөөдөр шуудхан хэлэхэд манай оронд аливаа хэм хэмжээний нэгэн адил эрх зүйн хэм хэмжээний үйлчлэл уналтын буюу гажуудлын байдалд орсон нь ерөөс нийгмийн түвшинд гэмт хэрэг өсөн цэцэглэх таатай хөрс суурь болжээ. Эрх зүйн хэм хэмжээ, хууль ёс

алдагдаж байгаа нь үндсэндээ хууль хэрэгждэггүй, хуулийг зөрчих явдал газар авсан, хууль ёсны хариуцлага хүлээлгэх явдал хаягдсан, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны чиг үүрэг хангалтгүй, хуулийн орчин боловсронгуй бус зэрэг зүйлүүдээр илэрч тэдгээр нь эргээд нийгмийн гэмт явдалд хамгийн их нөлөөлж байна гэж судалгаанд оролцогчид үзжээ.


	Иргэдийн хэлэлтэй	Эгнэ хүснэгт	Ажлааргүй	Илдэвгүй	Нийт
Ажлааргүй явдал	58.7%	25.7%	6.5%	9.3%	100.0%
Хууль ёсны хариуцлага хүлээлгэхгүй	54.3%	54.3%	3.6%	7.7%	100.0%
Хууль ёсны хариуцлага хүлээлгэхгүй	40.0%	58.8%	9.1%	12.1%	100.0%
Гэмт зоргоос гурвалжин сэтгэлдээ даан цагаалгүй	88.3%	50.7%	3.4%	7.0%	100.0%
Үүнийг цагаалмаггүй үргэлж гүйцэтгэх чөлөөгүй	30.0%	40.7%	9.6%	17.2%	100.0%
Хууль ёсны орчин боловсронгуй бус	25.0%	45.8%	19.8%	19.0%	100.0%

ГУРАВ. ГЭМТ ХАЛДАГЫН ЦААШДЫН ХАНДЛАГА

Цагдаагийн байгууллагаас гаргасан сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг харвал 2001 оноос хойш гэмт явдлын тоо багаар ч болов зогсолтгүй буурсан дүнтэй харагдаж байна. Гэвч энэ нь наад зах нь гэмт хэрэг буурсан уу? Эсвэл хүмүүс гэмт хэргийг талаархи мэдээллийг цагдаад бүртгүүлдэг эсэх цаашилбал энэ статистик нийгэмд байгаа бодитой гэмт хэргийг илэрхийлж чадах уу гэсэн асуултанд хариулт хайх хэрэгтэй болно. Үүнийг нарийвчлан судлахгүйгээр гэмт явдлын цаашдын хандлагыг тодруулахад ихээхэн төвөгтэй байх нь эргэлзээгүй.

Нэг. Манай судалгаанд хамрагдсан иргэдийн дөнгөж 17.5% нь гэмт халдлагад өртсөн бол цагдаад бүртгүүлдэг хэмээн хариулжээ. Үлдсэн хувь нь тэр болгон бүртгүүлдэггүй гэж үзсэн. Яагаад гэвэл цагдаад хандаад хэрэг шийдэгдэнэ гэж итгэдэггүйгээс (37.8%) гадна шийдэгдтэлээ хэрэг төвөг хэт сунжирдаг (28.6%) гэж тэд хариулж байна. Зарим тохиолдолд гэр бүлийн хүрээнд гарсан ч юм уу дотно хүмүүсийн хүрээнд хэрэг явдал дарагддаг гэж судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь үзэж байна.

Гэхдээ хууль хүчний байгууллагын урагшгүй үйл ажиллагаатай холбоотойгоор гэмт хэрэг бүртгүүлдэггүй гэж үзэж байгаа хүмүүс гурван хүн тутмын хоёр нь болж байгаа нь (66.4%) иргэд эдгээр байгууллагуудад хэр зэрэг итгэдэг, тэдний нэр хүнд, ажлыг үр дүнг үнэлэх үнэлгээ ямар түвшинд байгааг харуулах үзүүлэлт мөн. Энэ нь одоогийн бүртгэгдсэн гэмт хэргээс нийт гэмт хэргийн тоо дор хаяж 6 дахин олон байгаа гэсэн үг юм. Үүнээс ч



олон байх бодит боломж, нөхцөл шалтгаан байгаа. /Энэ талаар гэмт хэргийн шалтгаан нөхцөл гэсэн бүлгээс үзнэ үү/

Хоёр. Гэр бүлийн хүрээнд гарсан гэмт явдлын ихэнх нь бүртгүүлдэггүй гэж судалгаанд оролцогчдын 48% нь үзжээ. Цаашилбал хамаатан садны хүрээнд хэд /24.1%/ болон найз нөхдийн хүрээнд /24.4%/ үйлдэгдсэн гэмт халдлагууд ихэнх нь бүртгүүлдэггүй гэж иргэд үзэж байна. Ийнхүү социаль зай ойртох тусам иргэд гэмт явдлыг нуун дарагдуулах хандлагатай байдаг бол энэхүү зай холдох тусам гэмт явдлыг мэдэгдүүлэлгүй бүртгүүлэлгүй дарагдуулах ямар нэг шалтгаан байхгүй учраас бүртгүүлэх хандлагатай хэмээн үзэцгээжээ. Гэвч гэмт явдал бүрэн бүртгэгддэг эсэх талаар иргэдийн дийлэнх нь ямар нэг ойлголтгүй учраас мэдэхгүй гэдэг хариултыг өгцгөөжээ. Энэ нь ч гэмт явдал бүрэн бүртгэгдэж, шийдэгддэгт иргэд итгэлгүй байдгийг харуулах үзүүлэлт мөн. Тэд өөрсдийн ойрын хүрээний тухайлбал гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, хамт ажиллагсдын хүрээнд гарсан гэмт хэргийн зарим нь л бүртгүүлдэг гэж 30-40% нь үзэцгээж байна.

Гэр бүл болон, хамаатан садан найз нөхдийн хүрээнд гэмт явдалд уруу татагдаж болзошгүй, гэмт явдалд орооцолдох нуугдамал боломж бүхий эрсдэлтэй хүмүүс хэр зэрэг байгааг тандаж үзсэн юм. Ингэхэд гэр бүлийн хүрээнд нь ийм хүмүүсийн аль нь ч байхгүй гэж судалгаанд оролцогчдын 51 хувь нь хариулсан бол, найз нөхдийн хүрээнд ийм хүн байхгүй гэж дөнгөж 33.4%, хамаатан садны хүрээнд байхгүй гэж ердөө л 28.3% нь хариулсан байлаа. Сургууль завсардсан юм уу суугаагүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, эзэмшсэн мэргэжилгүй, архи согтууруулах ундаа хэрэглэдэг, зан суртахууны эвдрэлтэй, байнга хэл ам таталдаг, танхай, эсвэл ял эдэлж байсан, хормой султай зэрэг хүмүүс гэр бүлийн хүрээнд нь байдаг гэж судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь хүлээн зөвшөөрсөн байлаа. Онолын үүднээс үзвэл хүн бүр гэмт хэрэгтэн байх бүрэн бололцоотой ч дээрх бүлэг хүмүүсийг гэмт хэрэгтэн байх, гэмт явдалд орооцолдох эрсдэл бүхий бүлэг гэж үзэж бид судалсан. Ингэхэд гэмт хэргийн нуугдамал боломжит бүлэг нийт гэр бүлийн 50 шахам хувьд байдаг бол, найз нөхдийн хүрээнд 66%, хамаатан садны хүрээнд бүр 70 гаруй хувьд хүрч байна. Энэ нь манай нийгэм гэмт хэргийн нийгэм болсон гэмт хэрэгтнүүдийн нийгэм болоход маш ойрхон байгааг харуулах юм.

Гурав. Судалгаанд оролцогчдын 51.4% нь сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өссөн гэж үзэж байгаа бол дөнгөж 10.9% нь гэмт хэрэг буурсан гэж үзэж байна. Гэмт хэрэг өсөхийн зэрэгцээ нөхцөл байдал нь улам хүндэрч байна гэж 62.3% нь үзэж гайгүй болох хандлагатай гэж мөн л 10.3% нь үзэж байна. Иргэдийн дийлэнх нь гэмт хэргийн тоо өсөж, нөхцөл байдал нь хүндэрч байгаа гэж үзэж байгаа нь гэмт явдлын асуудал иргэдийн сэтгэлийг онц их түгшүүлсэн асуудал болоод байгааг харуулж байна. Тэгээд ч тэд цаашид гэмт хэргийн тоо буурна гэдэгт ч итгэхгүй байна. Мөн л 12.3% нь цаашид гэмт хэргийн тоо буурна гэж өөдрөгөөр бодож байна. Бусад нь хараахан ингэж үзэхгүй байгаа ажээ. Ер нь 10-12% хувь нь гэмт хэргийн нөхцөл байдлыг өөдрөгөөр төсөөлж байгаа байдал ажиглагдаж байгаа нь сайн хэрэг боловч харамсалтай нь энэ тоо хэтэрхий чамлалтай тоо юм. Эндээс үзвэл гэмт хэргийн өсөлт иргэдийн

санааг зовоож буй асуудлын нэг байнга байсаар ирснийг харж болохоор байна.

Дөрөв. Гэмт хэрэг нь манай Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох Ажилгүйдэл+Ядуурал+Архидалт гуравтай салшгүй холбоотой зүйл бөгөөд эдгээр үзэгдлүүдтэй харилцан уялдаж, эдгээр үзэгдлийн суурь дэвсгэр дээр өргөжин тэлдэг. Гэтэл ажилгүйдэл, ядуурал, архидалт гурав огцом гэж хэлж болохуйц буураагүй байхад гэмт явдлын тоог буурсан гэж дүгнэх нь эргэлзээ төрүүлнэ. Тиймээс энэ нь тодорхой бодлоготойгоор дэс дараатай арга хэмжээ авсаны үр дүнд гэмт явдлын уг шалтгааныг бууруулсан гэхээсээ илүүтэйгээр тоон мэдээллээр хуурч, гэмт явдлын хэрэг бүртгэлтийг хангалтгүй хийсэнтэй холбоотой буй заа. Мөн хотжилт, түүнтэй уялдан хот суурин газарт шилжин ирэгчид сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн нь гэмт хэрэг өсөхөд хүргэсэн гэдгийг ихэнх мэргэжилтнүүд хэлж байгаа. Урьд нь хийсэн судалгаа байхгүй учир 5 жилийн өмнө гэмт явдал хэдэн хувьтай бүртгэгдэж байсныг хэлэхэд хэцүү боловч гэмт хэрэг бүртгэлт сайжирсан гэх ямар ч үндэсгүй байна. Тиймээс хэрэг бүртгэлт буурснаас гэмт хэргийн тоо буурсан дүнтэй гарчээ гэхэд нэг их хилсдэхгүй юм.

Хүснэгт.1. Таны санааг зовоож байгаа асуудлууд.

№	Асуулганы	2000	2001	2002	2003	2004	2005	2006
1	Төрийнхөн	11.3	10.3	—	10.7	—	—	—
2	Төрийнхөн бусад	—	10.0	—	—	—	—	13.9
3	Ажилгүйдэл/ядуурал	28.1	27.3	26.1	25.7	—	7.7%	8.7%
4	Архидалт	16.1	15.6	14.7	14.1	20.1	14.0%	17.0%
5	Аюулгүй	11.1	10.9	10.8	10.9	10.9	10.0%	10.0%
6	Аюулгүй	14.1	13.8	13.6	13.7	13.1	10.0%	11.0%
7	Аюулгүй	11.1	—	11.1	10.1	7.1	10.0%	11.0%
8	Гэмт явдлын тоо буурсан	10.8	10.3	14.1	11.7	—	11.0%	10.0%
9	Түрэггүй ажилтан	—	—	—	10.8	—	—	—
10	Төрийнхөн	—	—	—	11.9	—	11.0%	11.0%
11	Төрийнхөн бусад/байхгүй	10.1	11.3	—	—	—	14.0%	11.0%
12	Түрэггүй ажилтан/архив	—	—	11.7	—	—	—	—
13	Түрэггүй ажилтан	—	—	11.0	—	—	—	—
14	Ажилгүйдэл/ядуурал	—	—	—	—	—	7.0%	8.0%
15	Ажилгүйдэл/ядуурал	—	—	—	—	—	—	14.1
16	Бусад	11.1	11.7	11.7	11.1	11.1	10.0%	11.0%

¹ “УИХ-ын сонгууль 2000” Социологийн академи. Түүвэр 600

² “Ерөнхийлөгчийн сонгууль 2001”, Социологийн академи. Түүвэр 500.

³ “Хүний эрхийн боловсрол” 2002 он, МУИС-ийн Социологийн тэнхим. Түүвэр 2400

⁴ “Нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал” Социологийн тэнхимийн дэргэдэх Парадигм клуб. 2003 он. Түүвэр 850

⁵ “Сант Марал” төвийн судалгааг ашиглав. 2004 оны 3 сарын 10. Энэ багананд байгаа тоонууд нь түүврийн хэмжээнд харгалзах хувь болно.(Pct of Cases)

⁶ 2005 оны 3 сарын 16 “Социологийн академи төв” Түүвэр 600

⁷ 2005 оны 4 сарын 16-17 “Социологийн академи төв” Түүвэр 900

⁸ 2005 оны 11 сарын 5-10. Социологийн академи төв. Хот суурин газарт иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нь

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд хуримтлагдсан дээрх сөрөг үзэгдлийн үр дагавар цаашид улам ч гүнзгийрэх магадлалтай, хор уршиг нь төсөөлөхийн аргагүй их гэдгийг тооцвол гэмт явдалтай тэмцэх ажлыг нийгмийн суурь шалтгаанаас эхэлж, шат дараатай арга хэмжээг даруй авч эхлэх шаардлага тулгамдсан шинжтэй байна.

ДӨРӨВ. ИРГЭДИЙГ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХИЙХ ТЭМЦЭЛ

Иргэд гэмт хэргээс хэр зэрэг хамгаалагдсан байдаг вэ? Бидний судалгаанаас үзэхэд гэмт халдлагаас хамгаалагдсан байдлаар нь шалгуур болгон үзвэл дараах үндсэн гурван бүлэг үүсч байна.

НЭГ. ХАМГААЛАЛТАЙ ХҮМҮҮС: Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дөнгөж 3.2 хувь нь өөрийгөө гэмт хэргээс хамгаалагдсан гэж үзэж байна. Тэдний 60 хувийг нь 35 хүртэлх насныхан эзэлж байна, 66 хувь нь орон сууцанд юмуу өөрийн хувийн тохилог орон сууцанд амьдардаг байна. Тиймээс тэд өөрсдийгөө бусдаас бүрэн хамгаалагдсан гэж боддог аж. Хамгаалагдсан хүмүүсийн 70 хувь нь хотын төвд буюу төв талдаа амьдардаг гэж хариулжээ. Чухам ингэж хотын төвд амьдардаг нь тэднийг бас тодорхой хэмжээгээр гэмт халдлагаас хамгаалах хүчин зүйл болдог.

ХОЁР. ТААРУУХАН ХАМГААЛАГДСАН ХҮМҮҮС: Гэмт халдлагаас өөрсдийгөө тааруухан хамгаалагдсан гэж гэж үнэлсэн хүмүүс нийт иргэдийн 59.1 хувийг буюу дийлэнхи олонхи нь эзэлж байна. Энэ бүлэгт 40-44 насныхны 60 хувь нь, 45-49 насныхны 57 хувь нь, 50-54 насныхны 52 хувийг, 55-59 насныхны 63 хувь нь буюу өөрөөр хэлбэл тааруухан хамгаалагдсан хүмүүс дотор 40-өөс дээш насны ахимаг хүмүүсийн дийлэнхи нь оржээ. Хүйсийн хувьд бараг тэнцүү, дээд боловсролтой хүмүүсийн олонхи нь өөрсдийгөө тааруухан хамгаалагдсан гэж санаа зовниж явдаг аж. Тэдний 40 хувь нь орон сууцанд амьдарч байгаа нь нөгөө хоёр бүлэгтэй харьцуулахад ихээхэн өндөр байна. Тааруухан хамгаалагдсан хүмүүсийн бараг 40 хувь нь хотын төв талдаа, 39 хувь нь хотын захад амьдардаг, нөгөө хоёр бүлгээсээ хавьгүй олон хүмүүс хотын бүрэн захад алслагдмал нөхцөлд амьдардаг.

ГУРАВ. ЯМАР Ч ХАМГААЛАЛТГҮЙ ХҮМҮҮС: Хэзээ ч гэмт халдлагад өртөж болзошгүй, өөрөөр хэлбэл гэмт халдлагад байнга өртдөг, ямар ч хамгаалалт байхгүй гэж судалгаанд оролцогчдын 37.7 хариулжээ. Тэд ерөнхийдөө боловсролын түвшин бага байгаа нь боловсролын түвшин ба эрсдэлээс өөрийгөө хамгаалагдсан гэж үзэх үзэл хоёрт хамаарал байгааг харуулна. Эл бүлгийн хүмүүсийн 40.5 хувь нь хотын захад, мөн хотын бүрэн захад амьдардаг хүмүүсийн тал нь ямар ч хамгаалалтгүй хэсэгт багтаж байгаа нь хотын хаана амьдарч байгаагаас хамаарч эрсдэлийн нөхцөл байдал өөр өөр байдаг байна.

Хэн ажиллах вэ?

1. Гэмт халдлагатай тэмцэх үйл ажиллагааг хэн хийх ёстой вэ гэсэн асуултанд иргэд дараах байдлаар хариулсан байна. Судалгаанд хамрагдсан ихэнхи иргэдийн хувьд гэмт халдлагыг заавал цагдаа нартай холбон үзэж тэмцэгч гол субъектээр цагдаа байх ёстой гэж үзэх нь хэвээрээ байна. Тиймээс цаашид цагдаа нарын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж иргэд үзсэн байна.

2. Хот суурин газарт гарч байгаа аливаа төрлийн гэмт халдлагаас хамгаалах түүнийг багасгахад иргэдийн өөрсдийнх оролцоо чухал гэж 35 орчим хувь нь үзсэн. Бусад улс орнуудад ч гэсэн иргэдийн өөрсдийн хамтын ажиллагаа, олон нийтийн идэвхийг дээшлүүлэхэд төр засгийн зүгээс анхаардаг.

3. Мөн багш нар 7.8 хувь, хорооны нийгмийн ажилтнууд 7.4 хувь нь, хороон дарга нар гэж 5.8 хувь нь хариулсныг анхааралдаа авах хэрэгтэй юм.

4. Төрийн бус байгууллага буюу иргэний нийгэм гэмт явдалд анхаарал хандуулах шаардлагатай гэж судалгаанд хамрагдсан хүмүүсийн 3.8 хувь нь үзсэн байна.

Нэн түрүүнд юу хийх вэ?

Нэгдүгээрт. Төрийн байгууллагын хүрээнд

1. Цагдаагийн шуурхай үйлчилгээ: Судалгаанд хамрагдсан иргэдийн 31.3 хувь нь буюу бараг 3 хүн тутмын нэг нь иргэдийг гэмт халдлагаас хамгаалахад цагдаагийн шуурхай үйлчилгээ чухал гэж үзсэн байх юм.

2. Гудамж талбайн нөхцлийг сайжруулах: Гудамж талбайн нөхцлийг сайжруулахгүйгээр иргэдийг гэмт халдлагаас хамгаалах боломжгүй гэж иргэдийн 27.7 хувь хариулсан. Мөн гэмт халдлагын дийлэнхи нь буюу 55.7 хувь нь гудамж талбайд болдог.

3. Эргүүлийн цагдаагийн тоог олшруулах. Судалгааны өмнө хэсэг гэмт явдал үйлдэгдэж цаг хугацаа, орон зай зэргийг үзвэл гэмт явдал үйлдэгдэж байх нөхцөлд цагдаад хандах боломжгүй байдаг ажгуу.

Тийм ч учраас эргүүлийн цагдаа нарын тоог олшруулах шаардлагатай байгаа гэж хариулсан хүмүүс нийт иргэдийн 25.4 хувийг эзэлжээ.

4. Хохирогч гэрчийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх. Монголын нийгэм нь гэмт хэргийн нийгэм мөн. Гэмт хэргийн нийгэмд гэмт хэрэгтнүүд ба иргэд холилдон оршдог. Тиймээс гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь зайлшгүй хохирогч гэрчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 5.5 хувь нь ийм хөтөлбөр маш чухал гэдгийг тэмдэглэсэн.

5. Аюулгүй такси. Сүүлийн үед гэмт этгээдүүд такси хөлөглөн гэмт хэрэг хийх боллоо. Тиймээс аюулгүй такси иргэдийн хувьд ихээхэн чухал бөгөөд анхаарал татаж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 5.5 хувь нь уг асуудлыг сонгосон байна.

Хоёрдугаарт Төрийн бус байгууллагын хүрээнд

6. Гэмт халдлага ба төрийн бус байгууллага. Өнөөдөр Монголд нийтдээ 4000 орчим төрийн бус байгууллага байгаагаас гэмт хэргийн талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага нэлээд хэд байгаа юм. Гэвч төрийн бус байгууллагуудын талаар иргэдийн санаа бодол тийм ч сайнгүй байна. Иргэдийн

төрийн бус байгууллагуудын үйл гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг 4.7 хувь нь маш сайн гэж хариулсан байхад, 25.8 хувь дунд зэрэг, 19.5 хувь нь сонссоноос хэтрэхгүй, 21.1 хувь нь тааруухан гэж үнэлжээ.

7. Гэмт халдлагад өртсөний дараа зөвөлгөө авах. Гэмт явдалтай холбоотой иргэдэд шаардлагатай байдаг нэгэн чухал хэрэгцээ бол зөвөлгөө авах юм. Өмнө өгүүлсэнчлэн гэмт халдлагад өртсөн хүн бүхэн цагдаад ханддаг уу гэсэн асуултанд 51.1 хувь үгүй, ханддаггүй гэж хариулсан нь гэмт хэргийн нуугдмал байдлыг харуулж байна. Хот суурин газарт амьдарч байгаа иргэдийн 15.5 хувь нь гэмт халдлагатай холбоотой зөвлөгөө авах асуудал юм.

Гуравдугаарт. Иргэдийн түншлэл хамтын ажиллагааны хүрээнд

1. Муу хүмүүсээс хамгаалуулах. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 10.4 хувь нь буюу 10 хүн тутмын нэг нь муу хүмүүстэй хамт амьдардаг гэж хариулсан. Муу хүмүүс гэдгийг тэд архи уудаг, ажилгүй, ширүүн догшин зантай, ядуу зүдүү гэмт хэрэгт орооцолддог хүмүүс гэж тодорхойлсон.

2. Аюулгүй мэдээлэл сурталчилгааг сайжруулах. Судлаачдын санал нийлдэг нэг зүйл бол гэмт халдлагад өртөхгүйн тулд иргэдийн гэмт халдлагаас өөрсдийгөө хамгаалах, чадвар, хангалттай сайн мэдлэг, бэлтгэл чухал юм. Үүнийг аюулгүйн мэдээлэл, сурталчилгааг сайжруулах гэж томьёолж болно. Хот суурин газар амьдардаг иргэдийн 9.9 хувь нь ийм мэдээлэл сурталчилгааны ажлыг сайжруулах хэрэгтэй байгаа гэдэгтэй санал нэгджээ.

3. Олон нийтийн оролцоо хөршийн холбоо. Иргэдийг гэмт халдлагаас хамгаалахад иргэдийн өөрсдийн оролцоо, хөршийн холбоо хамтын ажиллагаа туйлын чухал юм. Тиймээс иргэдийн оролцоог дээшлүүлэх орон нутаг иргэдээс өөрөөс нь гаргаж байгаа санал санаачлагыг идэвхжүүлэх түүнийг зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 12.4 хувь нь олон нийтийн оролцоо иргэдийн өөрсдийн өөрийгөө хамгаалах үйл ажиллагаатай холбон үзсэн.

4. Сургуулийн автобус. Сүүлийн үед гэмт халдлагад хүүхдүүд өртөх болсон. Тиймээс иргэдийн 3.1 хүүхдийг элдэв аюул ослоос нь сэргийлэх, сургуульд нь хүргэж өгөхөд сургуулийн автобус гэсэн хөтөлбөр чухал байгаа гэж үзсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа явуулахад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа туйлын хангалтгүй байгааг иргэдийн 16.6 хувь нь итгэдэг гэж хариулснаас харж болох бөгөөд тэдний үйл ажиллагааг удаан, найдваргүй, хэрэгтэй үед байдаггүй, хүнд сурталтай гэх зэргээр шүүмжилсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд нийгэм дэх гэмт хэргийг багасгах, бууруулах стратеги үйл ажиллагаа нь иргэдийн өөрсдийн хэрэгцээн дээр тулгуурласан, тэдний идэвхтэй үйл ажиллагааг дэмжсэн, хоршсон, хамтарч ажиллаж байж үр дүнд хүрнэ гэдгийг судалгаа харуулж байна. Тиймээс олон газарт иргэд өөрсдийгөө хамгаалах хөршийн холбоо, сайн дурын эргүүл, өсвөрийн сэргийлэгч зэрэг төрөл бүрийн зохион байгуулалтын хэлбэрийг бий болгож цагдаагийн байгууллагатай түншлэн ажиллахгүйгээр зөвхөн цагдаагийн байгууллага тэмцдэг гэсэн уламжлалт хандлагаас татгалзах шаардлагатай болсныг харуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮД

2005-12-09

Улаанбаатар хот

Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл доор Хүний эрхийн байгууллагуудын үндэсний Чуулганыг “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх” – гэсэн сэдвээр Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хамтран 2005 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав.

Тус Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр оролцон, дэлгэрэнгүй үг хэлж, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Аюулгүйн стандартын хэрэгжилт, Хот суурин газарт иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нь гэсэн сэдвүүдээр төрийн болон төрийн бус байгууллагуудаас илтгэл тавьж хэлэлцүүлэв. Түүнчлэн Чуулганы салбар хуралдаанууд дээр олон хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах, аж төрөх эрхээ эдлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлууд, цаашид хийх ажил, зохион байгуулах үйл ажиллагааны талаар санал дэвшүүлэв.

Чуулганаас дараах зөвлөмжүүдийг санал нэгтгэйгээр батлав. Үүнд:

Нэг. Үндэсний хөтөлбөрийн талаар

1.1. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг авч хэлэлцэхийг Улсын Их Хуралд хүсэлт болгох

1.2. Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах үүргээ биелүүлж, Үндэсний хөтөлбөрийн хорооны ажлыг эхлүүлэхийг Засгийн газарт зөвлөмж болгох.

Хоёр. Аюулгүйн стандартыг хэрэгжүүлэх талаар

2.1. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн эрх зүйн баталгааг хангахын тулд Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Авто замын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Авто тээврийн тухай, Агаарын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай, Усны тухай, Химийн хорт бодисоос хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Эмийн тухай зэрэг хуулиудын хэрэгжилтийг судлан цаашид боловсронгуй болгохын зэрэгцээ Хүнсний тухай хуулийг өөрчлөн шинэчлэх, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн хэлэлцэн батлан гаргахыг УИХ-д зөвлөмж болгох.

Засгийн газар, түүний харьяа байгууллагуудад зөвлөмж болгох нь:

2.2. Улсын болон аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газруудад хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг нэгтгэн судалгаа, дүгнэлт хийж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн үр нөлөөтэй арга хэмжээ авах.

2.3. Хот, суурин газрын барилга, байгууламжийн аюулгүй байдлын стандартыг боловсруулж, түүний хэрэгжилт, хяналт шалгалтыг хүчтэй болгож барилга угсралт, барилгын материалын болон бусад үйлдвэрийн техник, технологийн стандартыг боловсруулах, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах шат дамжлагын технологийн хяналтыг үр нөлөөтэй болгох. Тэрчлэн газар хөдлөлийн баллын муж, бүслэлийг тодотгон, тогтоогоогүй бүсүүдэд баригдсан барилга, байгууламжийг паспортжуулах, нийслэл болон төв суурин газруудын авто зам, газар доорхи явган зорчигчийн нүхэн гарц, хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих зам болон шат, авто машины зогсоол, гарц, уулзварыг орчин үеийн хот байгуулалтын техникийн шаардлагад нийцүүлэн барих, засч өөрчлөх цогцолбор арга хэмжээ авах.

2.4. Химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх материал, түүхий эдийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, ашиглалт, борлуулалтыг тогтоосон горим, технологийн дагуу хийж, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

2.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр болон Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт тусгагдсан эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхтэй холбогдолтой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

2.6. ШТС байгуулах байршил болон шатах, тослох материал хадгалах, тээвэрлэх, түгээх ажиллагааны стандартыг чанд мөрдүүлэх журам тогтоон ажиллах.

2.7. Ой, хээрийн болон гэр ахуйн чанартай гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар тавих хяналтыг боловсронгуй болгож, гал түймрийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар олон нийтэд сурталчлан ойлгуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байх.

2.8. Агаар, ус, хөрсний орчны талаархи стандарт, норм, нормативыг хот суурин газрын хүрээлэн байгаа орчны онцлогтой уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй шинэчлэн тогтоох, улмаар орчны болон ус, агаарын бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн гамшигтай тэмцэх чиглэлээр эрх зүйн болон эдийн засгийн орчин бүрдүүлэх асуудлыг нийгмийн хамгаалал болон бусад хөшүүрэг, урамшууллын механизмтай уялдуулан боловсронгуй болгох.

2.9. УМХГ-т хүнсний аюулгүй байдалд тавьж буй хяналт, шалгалтын үйл ажиллагааг хууль, эрх зүйн орчиндоо тохируулан улам боловсронгуй болгох, үйл ажиллагааны давхардлыг арилгаж, чанарыг сайжруулах, Лавлагаа лаборатори байгуулах болон хүнсний аюулгүй байдлын хяналтын дүрэм, аюулгүй байдлын үзүүлэлтүүд боловсруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх.

2.10. Аюулгүйн стандартуудыг хэрэгжүүлэх үйлст иргэний нийгмийн оролцоог идэвхижүүлэх, тэдгээрээс гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийг судлан хэрэгжүүлэх, дээрх асуудлаар төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг тэднээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авах.

2.11. Санхүүгийн бүртгэлд туссан, баталгаат технологийн заавраар, стандартын шаардлага хангасан нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тавих хяналтыг сайжруулах.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон нийслэл, аймгийн Засаг дарга нарт зөвлөмж болгох нь:

2.12. Төв, суурин газарт агаарын болон хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг багасгах, энэ талаар тавих хяналтын механизмыг төгөлдөржүүлэхийн тулд олон нийтийн оролцоог идэвхижүүлэх, утаагүй түлш хэрэглэх, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлэх.

2.13. Өвлийн улиралд төв, суурин газрын зам, талбайн цас, мөс цэвэрлэх ажиллах хүч, техник хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх, энэ талаар хувийн хэвшил, олон нийтийн оролцоог сайжруулах, харьяалах аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчдад хариуцуулах арга хэмжээг авах.

2.14. Барилга, байгууламж барих газрыг олгохдоо хот байгуулалт, төлөвлөлтийн орчин үеийн шаардлага, стандартад нийцүүлж, зохистой байршлыг бий болгоход онцлон анхаарах.

2.15. Нийслэл, аймаг, орон нутгийн хүн амын хүнсний аюулгүй байдал, зохистой хоол, хүнс хэрэглэх мэдлэг, боловсрол олгохын тулд сургалт, сурталчилгааны ажлыг системтэй зохион байгуулж байх.

Иргэний нийгэм, ТББ, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж болгох нь:

2.16. Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын, хүнсний аюулгүй байдлын, эрүүл мэнд, ариун цэврийн аюулгүй байдлын стандартуудын хэрэгжилтэд тавих иргэний нийгмийн хяналтыг өргөжүүлэн үр нөлөөг дээшлүүлэх, үйл ажиллагааг идэвхижүүлэх.

2.17. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зүгээс ус, хөрс, агаарыг бохирдуулахгүй байх, аюулгүйн стандартыг хэрэгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх, энэ талаарх тэдний хийж буй тэмцэл, санаачилгыг дэмжиж, идэвхижүүлэх хөшүүргийг бий болгон ажиллах.

2.18. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой олон улсын болон үндэсний стандартаар сургалт, сурталчилгаа явуулан иргэд, төрийн байгууллагын ажилтнуудын мэдлэг чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол авч байх.

2.19. Аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо зам, талбайн гэрэлтүүлэг, тохижилт, ариун цэврийн нөхцөлийг сайжруулахад онцгойлон анхаарч, хөрөнгө оруулалт хийж байх.

Гурав. Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах ажлын хүрээнд

Засгийн газар, түүний харьяа байгууллагуудад зөвлөмж болгох нь:

3.1. Нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн бүрэн эрх, үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх.

3.2. Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг судалж, тэдгээрийг арилгах, нөлөөллийг нь саармагжуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

3.3. Иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалахад онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг Сагдаагийн байгууллагын албан хаагчдын ажлын ачаалал, иргэдэд үйлчлэх хүртээмж, тэдгээрийн орон тоог засаг захиргааны тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоотой уялдуулан тогтоох арга хэмжээг авах.

3.4. Сагдаагийн байгууллагын албан хаагчдын ажлын нөхцөл, ахуй хангамжийг сайжруулах, харилцаа холбоо, унааны хангалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

3.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах.

3.6. Хуулийн байгууллагуудын ажилтнуудын үйл ажиллагаанаас иргэнд учирсан гэм хор, хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хуулийн заалтуудыг биелүүлэх, буруутай ажилтнуудад хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгох.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон нийслэл, аймгийн Засаг дарга нарт зөвлөмж болгох нь:

3.7. Хот, суурин газарт цагдаагийн эргүүлийг нэмэгдүүлэн тогтмолжуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, төрийн бус байгууллагуудтай нягт хамтран түншилж, гудамж талбай, үзвэр үйлчилгээний газрын гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах арга хэмжээг авах.

3.8. Нийтийн орон сууцны бүх орц, хонгил, гэр хорооллын гудамж, замыг байнгын гэрэлтүүлэгтэй болгох, дохиоллын болон хяналтын систем нэвтрүүлэх ажлыг дэмжиж ажиллах.

ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД



ТЭМДЭГЛЭЛ



Mongolia

НҮ ХХ нь илүү өндөр амьдрал, нөөцийн хангамж, улс орнуудын өмнөх ач холбогцлыг олон нийтийн хамтын ажиллагаа замаар илүү сайн амьдралын амьдралыг доголлон байгуулахад хамт туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 327136, 320284

Цахим шуудан: nco@mongol.net

Цахим хуудас: <http://www.mn-nhrc.org>